




ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

БҮХ ШАТНЫ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ
ЗӨВЛӨЛ, ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАДЫН
БҮРЭЛДЭХҮҮНД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА





Бүх шатны гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, гамшгаас хамгаалах албадын бүрэлдэхүүнд зориулсан Гамшгийн эрсдэлийн удирдлага гарын авлагыг Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газрын захиалгаар Уур амьсгалын Ногоон сангийн санхүүжилтээр Байгаль орчин аялал жуулчлалын яам, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам хамтран НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй хэрэгжүүлж буй **“МОНГОЛ ОРНЫ ХӨДӨӨГИЙН ИРГЭДИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ЧАДАМЖ БОЛОН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ”** төслийн дэмжлэгтэй эмхэтгэн боловсруулав. Тус гарын авлагын агуулга санхүүжүүлэгч болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудын албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлэхгүй болно.

Ашгийн бус зорилгоор олшруулж мэдээлэл түгээхийг зөвшөөрнө. ©2023



БОЛОВСРУУЛСАН:

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН: Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн баг

ГЭРЭЛ ЗУРГУУД: Онцгой байдлын ерөнхий газар, НҮБХХ



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

БҮХ ШАТНЫ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ
ЗӨВЛӨЛ, ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАДЫН
БҮРЭЛДЭХҮҮНД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	5
ГАРЫН АВЛАГЫН ТАНИЛЦУУЛГА	6

БҮЛЭГ 1. ГАМШГИЙН ЭРСДЭЛ, ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ

АЖИЛЛАГАА	8
1.1. Гамшиг, гамшгийн эрсдэл.	8
1.2. Гамшгийн эрсдэлийн төлөв байдал.	17
1.3. Гамшгийн эрсдэлийн удирдлага, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа	21
1.4. Уур амьсгалын өөрчлөлтөөс гамшгийн эрсдэлд үзүүлэх нөлөөлөл.	33
1.5. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хандлага.....	40

БҮЛЭГ 2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗАСАГЛАЛ

2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны бодлого, эрх зүйн орчин.	49
2.2. Монгол Улсын гамшгийн эрсдэлийг бууруулах тогтолцоо.	59
2.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл.	60
2.4. Онцгой комисс.....	67
2.5. Гамшгаас хамгаалах алба.....	76
2.6. Онцгой байдлын байгууллага.....	84

БҮЛЭГ 3. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ

3.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөлт	86
3.2. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг тусгах	88
3.3. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг тусган төлөвлөх нь.....	93
3.4. Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга зам, туршлага.....	97
3.5. Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтэд нөлөөллийн аргыг ашиглах.....	105
3.6. Цаг агаар, уур амьсгалын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилтийн аргыг гамшгийн эрсдэлийг бууруулахад ашиглах нь	124

БҮЛЭГ 4. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ, ҮР ДҮН

4.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хяналт.....	138
4.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үр дүн.	152

НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ	159
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	163



ӨМНӨХ ҮГ

Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан гамшгийн тохиолдох давтамж ойртож, хамрах хүрээ, эрч хүч нь улам бүр нэмэгдэж, гамшиг нь улс орны тогтвортой хөгжлийн ололтод сөргөөр нөлөөлөх хүчин зүйлд тооцогдох боллоо. Уур амьсгалын өөрчлөлтөөс бий болсон шинэ нөхцөлд нийцэн амьдрах буюу дасан зохицох, гамшгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж гамшгийн эрсдэлийн бууруулах замаар гамшгийг аль болох хохирол багатайгаар даван туулах чадварыг бүх түвшинд бэхжүүлэх хэрэгцээ, шаардлага улам бүр чухлаар тавигдаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан **“ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭГ МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ”**-д гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг харилцан уялдаатай хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талуудын гамшгийн эрсдэл, эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхийг онцолсон.

Энэ стратегийг хэрэгжүүлэх хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн гишүүд, яам агентлагийн гамшгаас хамгаалах асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон бусад холбогдох талуудын гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, тэдгээрт эрхэлж буй ажлынхаа хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд уялдуулан тусгах, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг төлөвлөх, хэрэгжүүлэх арга зам, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр зохих мэдлэг, ур чадвар олгох зорилгоор энэхүү гарын авлагыг боловсруулж та бүхэнд толилуулж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн Ажлын албыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга удирдаж, ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг тус байгууллагын гамшгийн эрсдэлийн удирдлага хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж хариуцан ажиллаж байна. Энэ хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газрын захиалгаар Уур амьсгалын Ногоон сангийн санхүүжилтээр Байгаль орчин аялал жуулчлалын яам, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам хамтран НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй хэрэгжүүлж буй **“МОНГОЛ ОРНЫ ХӨДӨӨГИЙН ИРГЭДИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ЧАДАМЖ БОЛОН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ”** төслөөр **“ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА”** гарын авлагыг боловсрууллаа.

Онцгой байдлын байгууллагын гамшгийн эрсдэлийн удирдлагад гүйцэтгэх үүрэг нь оролцогч талуудын нөөц, бололцоо, үйл ажиллагааг гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглүүлж тэдгээрийн харилцан ажиллагааг хангахад оршино гэдгийг тодотгож өгсөнд энэ гарын авлагын ач холбогдол нь оршино.

Тус гарын авлага нь бүх шатны гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, гамшгаас хамгаалах албадын бүрэлдэхүүн болон холбогдох талуудын гамшгийн эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд уялдуулан тусгах ур чадварыг дээшлүүлж, бүх түвшинд гамшгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд бодитой ахиц дэвшлийг авчирна гэдэгт итгэлтэй байна.



ГАРЫН АВЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү гарын авлага нь гамшгийн эрсдэлийн бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн гишүүд, яам агентлагийн гамшгаас хамгаалах асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон бусад холбогдох талуудын гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, тэдгээрт эрхэлж буй ажлынхаа хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг уялдуулан тусгах үр чадварыг олгох зорилготой.

Монгол Улс 2017 оны Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд үзэл баримтлалын хувьд гамшгаас хамгаалах удирдлагаас гамшгийн эрсдэлийн удирдлагад шилжсэн. Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал нь нарийн төвөгтэй, салбар дундын хамтын ажиллагаа шаарддаг, тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн цогц үйл ажиллагаа тул засгийн газар, түүний харьцангуй хязгаарлагдмал нөөцийн хүрээнд ажилладаг онцгой байдлын байгууллага дангаараа энэ бүхнийг хийх боломжгүй юм. Иймд төр нь гамшгаас хамгаалах, иргэдийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон нийтийг оролцуулах шаардлага үүсдэг.

Энэ утгаараа гамшгаас хамгаалах, нэн ялангуяа гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд, түүнчлэн төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн өмчийн хэлбэр үл харгалзан, нийт иргэдийн оролцоонд тулгуурлан зохион байгуулж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулахад зөв зохистой бүтэц, тогтолцооноос гадна хүрэлцэхүйц санхүүгийн эх үүсвэр нэн шаардлагатай. Олон улсын туршлагаас харахад гамшгийг урьдчилан харж, болзошгүй эрсдэлийг бууруулах нь түүнээс учрах хор хохирлыг арилгах үйл ажиллагаанаас **15-20 ДАХИН БАГА ЗАРДАЛ ШААРДАНА** гэдгийг тогтоосон байна.

Гамшгаас хамгаалах тогтолцоо нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах чиг үүрэг бүхий орон тооны бус Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл, мэргэжлийн дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй төрийн захиргааны холбогдох яам, агентлагийг түшиглэсэн гамшгаас хамгаалах орон тооны бус албад, болон гамшгийн нөхцөл байдал үүссэн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажлыг шуурхай зохион байгуулах чиг үүрэг бүхий онцгой комиссоос бүрдэнэ. Эдгээр бүтцийг гамшгаас хамгаалах төрийн бодлого, гамшгаас хамгаалах талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй онцгой байдлын байгууллага нь уялдуулан зохицуулдаг.

Тус гарын авлагыг Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл, Гамшгаас хамгаалах улсын албадын гамшгаас хамгаалах асуудал хариуцсан мэргэжилтэн, бусад холбогдох талууд гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд уялдуулан тусгах, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг төлөвлөх, хэрэгжүүлэх арга зам, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр онолын мэдлэг, үр чадвар олгох, өөрсдийн үйл ажиллагаандаа шууд ашиглах боломжтой байхаар боловсруулав.

Гарын авлагыг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан. Үүнд:



- Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого, хууль тогтоомжид нийцсэн байх;
- Монгол Улсын хөгжлийн бодлогын төлөвлөлт, төсөв, санхүүгийн өнөөгийн тогтолцоотой уялдсан байх;
- Дэлхий нийтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлын хөгжлийн чиг хандлагатай нийцсэн байх;
- Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид нийцүүлэх;
- Монгол Улсын онцлог чанаруудыг харгалзан үзэж, хамгийн тохиромжтой гэж үзсэн болон олон улсын хэмжээнд хамгийн шилдэг шийдэл, арга хэмжээ, сайн туршлагыг санал болгох.

Гамшгийн эрсдэлийн удирдлага гарын авлага нь **товч танилцуулга, товчилсон үгийн тайлбар, нэр томъёоны тодорхойлолт, үндсэн 4 бүлэг, 18 дэд бүлэг, ашигласан эх сурвалжийн жагсаалт, хавсралтаас** бүрдэнэ.

Танилцуулга хэсэгт гарын авлагын зорилго, ач холбогдол, боловсруулахад баримталсан зарчмыг, нэгдүгээр бүлэгт гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, түүний бодлого, эрхзүйн орчныг, хоёрдугаар бүлэгт гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны тогтолцоо, оролцогч талуудыг болон бодлого, эрхзүйн орчныг, гуравдугаар бүлэгт гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого, төлөвлөлтийн баримт бичиг дэх гамшгийн эрсдэлийг бууруулах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах арга замуудыг, сүүлийн бүлэгт гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хяналт, үр дүнг хэрхэн тооцохыг тус тус тодорхойлж өгсөн болно.

Монгол Улсын Засгийн газар НҮБ-аас байгууллагаас баталсан **“Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг”, “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030”, “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээр”**-ийг бүрэн дүүрэн дэмжиж ирсэн бөгөөд цаашид эдгээр баримт бичгийн зорилтуудын уялдааг хангах, цогцоор нь хэрэгжүүлэх талаар бүх түвшинд хүчинд чармайлт гарган ажиллаж байна. Эдгээр бодлогын баримт бичгүүдийн аль нэгнийх нь амжилттай хэрэгжих эсэх нь үлдсэн хоёр баримт бичгийн хэрэгжилтээс хамаарах учиртай.



Та “Гамшгийн эрсдэлийн удирдлага гарын авлага”-ыг судалснаар орон нутаг, байгууллагын үйл ажиллагааны онцлог, орон нутгийн байгаль, цаг агаарын нөхцөл байдалдаа нийцүүлэн гамшгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, эрхэлж буй ажлынхаа хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг уялдуулан тусгахад шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшинэ хэмээн найдаж байна.

БҮЛЭГ 1. ГАМШГИЙН ЭРСДЭЛ, ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. ГАМШИГ, ГАМШГИЙН ЭРСДЭЛ

Хүн төрөлхтөн бий болсон цагаасаа эхлэн байгалийн аливаа аюулт үзэгдэл, хүнд хэцүү саад бэрхшээлтэй тулгарч, зарим үед хүчин мөхөсгөж, зарим тохиолдлыг даван туулан хөгжил, дэвшлийг бий болгосоор өнөө хүрсэн билээ. Гэвч сүүлийн жилүүдэд дэлхий дахинд байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой гамшгийн тохиолдол нэмэгдсээр байгаа нь хүмүүсийн олон зуун жилийн турш бүтээсэн хөгжлийг хоромхон зуур үгүй хийх эрсдэлтэй нөхцөл бүрдсэнийг харуулна. Гарын авлагын энэ бүлэгт гамшгийн эрсдэлийн зарим тулгуур ойлголтыг товчхон авч үзье.

ГАМШИГ Гамшиг нь ямар нэгэн аюул тохиолдож, түүний улмаас ихээхэн хэмжээний хохирол учрах, учирсан хохирлыг арилгахад нийгэм, эдийн засгийн чадавх хүрэхгүй байх нөхцөлөөр гол төлөв тодорхойлогдоно.

Энэ ойлголтыг Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд **“ГАМШИГ” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ** гэж заасан.

АЮУЛ Аюул гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг хэлнэ.

Аюул бол ирээдүйд аюул занал учруулж болох ч, одоогоор далд байдалд байгаа нөхцөл юм. Аюулыг эх үүсвэрээр нь дараах байдлаар ангилдаг. Үүнд:

- Байгалийн гаралтай
- Хүний үйл ажиллагаатай холбоотой.

Гэхдээ зарим аюул нь байгалийн болон хүний үйл ажиллагааны хавсарсан нөхцөл байдлаас үүсэж болно.




БАЙГАЛИЙН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ: Байгалийн хүчин зүйлийн нөлөөлөл, зүй тогтол, хувьсал өөрчлөлтийн нөлөөний үр дүнд үүсэх аюулыг байгалийн гаралтай аюулт үзэгдэл гэх бөгөөд дараах ангилалд хуваагдана (Хүснэгт 1.1)

ХҮСНЭГТ 1.1. БАЙГАЛИЙН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ

БАЙГАЛИЙН ГАРАЛТАЙ АЮУЛТАЙ ҮЗЭГДЛИЙН АНГИЛАЛ	ОНЦЛОГ ШИНЖ	ХАМААРАХ АЮУЛТ ҮЗЭГДЛИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР
ГЕОЛОГИЙН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ		Газар хөдлөлт: <ul style="list-style-type: none"> ➤ Газар хөдлөлтийн чичирхийлэл* ➤ Цунами ➤ Хөрсний ус нэвчилт* ➤ Хөрсний гулсалт* ➤ Газрын гадаргуугийн шилжилт*
		Галт уулын дэлбэрэлт: <ul style="list-style-type: none"> ➤ Галт уулын шавар урсах ➤ Галт уулын үнс унах ➤ Халуун хайлмал лав урсах
		Газрын гадаргуугийн өөрчлөлт: <ul style="list-style-type: none"> ➤ Шилжилт* ➤ Хөрсний гулсалт* ➤ Нүх үүсэх ➤ Газрын хий (CH₄, Rn гэх мэт) ➤ Хад асга нурах
БИОЛОГИЙН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ	Амьд организм, түүний хоруу чанарын нөлөөлөл, бичил биетээр үүсгэгдэн дамжих чанартай хүн, мал амьтан, ургамлын халдварт өвчний тархалт.	Халдварт, гоц халдварт өвчин: <ul style="list-style-type: none"> ➤ Вирусийн гаралтай өвчин (Zika, COVID-19)* ➤ Бактерийн гаралтай өвчин (Тарваган тахал, боом)* ➤ Паразитын гаралтай өвчин* ➤ Мөөгөнцрийн гаралтай өвчин ➤ Прионы гаралтай өвчин
		Хортон тархах: <ul style="list-style-type: none"> ➤ Хортон шавж тархах* ➤ Хортон мэрэгч тархах*
ЦАГ АГААРЫН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ	Агаар мандлын хувьсал, өөрчлөлт, нөхцөл байдлын нөлөөгөөр үүснэ.	Тропик-халуун бүсийн гаралтай шуурга Конвекцын гаралтай шуурга: <ul style="list-style-type: none"> ➤ Хуй салхи* ➤ Мөндөр* ➤ Аянга цахилгаан* ➤ Аадар бороо* ➤ Хар салхи

		<ul style="list-style-type: none"> ➤ Шороон шуурга* ➤ Цасан шуурга* ➤ Хүчтэй салхи* ➤ Далайн эргийн хар салхи <p>Агаарын хэмийн эрс өөрчлөлт:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Хэт халалт* ➤ Огцом хүйтрэлт* ➤ Өвлийн улирлын эрс тэс нөхцөл: их цас буюу зудын нөхцөл, мөстөлт, хөлдөлт* <p>Манан*</p>
<p>УС ЗҮЙН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ</p> <p>Газрын гадаргуу дахь усны шилжилт өөрчлөлт, хуваарилалтын нөлөөгөөр үүснэ.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Газрын гадаргуу дахь усны шилжилт өөрчлөлт, хуваарилалтын нөлөөгөөр үүснэ. 	<p>Үер:</p> <ul style="list-style-type: none"> ➤ гол мөрний үер* ➤ уруйн үер* ➤ шар усны үер* ➤ мөсөн хахаа* <p>Гулсалт, нуранги:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Цасан нуранги* ➤ Шавар урсах* ➤ Хад чулууны нуранги*
<p>УУР АМЬСГАЛЫН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ</p>	<p>Уур амьсгалын хүчин зүйлийн улирлын болон олон арван жилийн хугацаанд үүссэн хувьсал, өөрчлөлтөөс бий болсон агаар мандлын үйл явцаас шалтгаалан үүснэ.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Ган* ➤ Зуд* ➤ Цөлжилт* <p>Байгалийн түймэр:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Ой түймэр* ➤ Хээрийн түймэр*
<p>САНСРЫН ГАРАЛТАЙ АЮУЛ</p>	<p>Жижиг гариг, солирын биет, сүүлт од дэлхийн агаар мандалд нэвтрэх, унах тохиолдол</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Агаар дахь дэлбэрэлт/осол ➤ Сансрын биет унах (солир гэх мэт)* ➤ Цахилгаан соронзон орон ➤ Агаар мандлын ионжсон салхи
<p>ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ГАРАЛТАЙ АЮУЛ</p>	<p>Байгалийн болон экосистем гарсан өөрчлөлтөөс үүдэлтэй агаар, ус, хөрс, биологийн олон янз байдал аажмаар доройтох үйл явц. Хүний үйл ажиллагаатай хавсран бий болно.</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Биологийн олон янз байдлын доройтол* ➤ Газар, хөрс, агаарын бохирдол* ➤ Цөлжилт* ➤ Цэвдэг хайлалт* ➤ Далайн түвшин нэмэгдэх ➤ Далай, гол, нуурын эрэг элэгдэн урсах (хөрс ой модыг устгаснаас үүсэх)
<p><i>Тайлбар: Монгол Улсад ихэвчлэн тохиолдох аюулт үзэгдэл, ослыг * тэмдэглэв.</i></p>		



ХҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АЮУЛЫН АНГИЛАЛ	ОНЦЛОГ ШИНЖ	ХАМААРАХ АЮУЛ, ОСЛЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР
ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ХОЛБООТОЙ ОСОЛ	Үйлдвэрлэл, техник технологийн горим зөрчигдөж их хэмжээний хохирол учруулсан нөхцөлөөс үүснэ.	Үйлдвэрийн осол: <ul style="list-style-type: none"> ➢ Химийн бодисын осол* ➢ Нуралт* ➢ Дэлбэрэлт* ➢ Гал түймэр* ➢ Хий алдагдах* ➢ Цацраг идэвхт бодис алдагдах
		Тээврийн хэрэгслийн осол: <ul style="list-style-type: none"> ➢ Агаарын тээврийн осол* ➢ Авто зам тээврийн осол* ➢ Төмөр замын осол* ➢ Усан замын осол*
НИЙГМИЙН ШАЛТГААНТАЙ АЮУЛ	Үндэстэн хоорондын мөргөлдөөн, алан хядах ажиллагаа, дайн, дотоодын үймээн самуун зэргээс үүснэ.	Эмх замбараагүй байдал*
		Терроризм
		Үй олноор хөнөөх хэрэгсэл
<i>Тайлбар: Монгол Улсад ихэвчлэн тохиолдох аюулт үзэгдэл, ослыг * тэмдэглэв.</i>		

Эдгээр аюулын төрлүүд дангаараа, хосолсон, хавсарсан, цуварсан байдлаар тохиолдож болно. Олон улсын шинжлэх ухааны зөвлөл, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас 2020 онд хамтран боловсруулсан **“АЮУЛЫН ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ”** тайланд дэлхий дахинаа тохиолдож буй аюулын жагсаалтыг гаргасан байна.



Тус жагсаалтад нийт 302 төрлийн аюулыг багтсан бөгөөд үүнээс:

- Геологийн гаралтай 35,
- Биологийн гаралтай 88,
- Ус, цаг агаарын гаралтай 60,
- Хүрээлэн буй орчны гаралтай 24,
- Сансрын гаралтай 9,
- Техник, технологийн гаралтай 53,
- Химийн ослын 28,
- Нийгмийн шалтгаантай 8 аюул байна.

Монгол Улсад эдгээр аюулын төрлөөс 40 гаруй төрөл нь түгээмэл тохиолддог байна.

ӨРТӨХ БАЙДАЛ

Өртөх байдалд аюулын бүсэд байрлах, түүний нөлөөлөлд өртөх магадлал бүхий хүн ам, эд хөрөнгө, орон сууц, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ болон бусад биет эд хөрөнгө багтана.

Энэ нь өртөх байдалд байгаа бүх зүйл гамшгийн улмаас хохирол амсаж, эвдэрч сүйднэ гэсэн үг биш юм. Гамшиг, аюулт үзэгдэл, осолд өртөх зэрэг нь гамшгийн эмзэг байдал, чадавхаас шууд хамаарна. Тухайлбал, Монгол орны газар хөдлөлтийн бичил мужлалын зураг /500 жилийн эргэн тохиох/ дээр гаргасан улсын хэмжээнд газар хөдлөлтөд айл өрхийн өртөх байдлын мэдээллийг хүснэгт 1.3-д үзүүлэв. **2020 онд Монгол Улсад нийт 902,609 айл өрх байна. Эдгээр айл өрхийн 73.7% нь VIII ба түүнээс дээш, 17.5% нь VII балл, ердөө 8.6% нь VI баллын газар хөдлөлтийн эрчмийн бүсэд оршиж байгааг** судалгаа харуулж байна.

ХҮСНЭГТ 1.3. УЛСЫН ХЭМЖЭЭНД ГАЗАР ХӨДЛӨЛТӨД ӨРТӨЖ БОЛЗОШГУЙ АЙЛ ӨРХ (ХУВИАР)

Д/Д	АЮУЛ	ГАЗАР ХӨДЛӨЛТӨД ӨРТӨХ БАЙДАЛ АЙЛ ӨРХИЙН ХУВЬ /БАЛЛ/				
		<IV	V	VI	VII	>VIII
1	Газар хөдлөлт	-	-	8,6%	17,5%	73,7%

Бүсчилсэн хэлбэрээр авч үзвэл, **Улаанбаатар хотын нийт айл өрхийн 97.7%, баруун бүсийн 89%, өмнөд бүсийн 75.6% нь газар хөдлөлтийн VIII ба түүнээс дээш баллын эрчмийн бүсэд оршин сууж байгаа** нь манай орны хувьд айл өрхийн газар хөдлөлтөд өртөх байдал өндөр байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 1.4. УЛСЫН ХЭМЖЭЭНД ГАЗАР ХӨДЛӨЛТӨД ӨРТӨЖ БОЛЗОШГУЙ АЙЛ ӨРХ (БҮСЭЭР)

Д/Д	БҮС	НИЙТ ӨРХ	ГАЗАР ХӨДЛӨЛТӨД ӨРТӨХ ӨРХИЙН ТОО, ХУВЬ /БАЛЛ/				
			<IV	V	VI	VII	>VIII
1	Төвийн бүс	145,256	-	-	20,897 /14%/	86,483 /59,5%/	37,876 /20,7%/
2	Зүүн бүс	65,009	-	-	57,237 /88%/	7,351 /11,3%/	421 /0,6%/
3	Өмнөд бүс	170,468	-	-	-	43,560 /25,5%/	126,908 /75,6%/
4	Улаанбаатар	416,602	-	-	-	9,370 /2,2%/	407,232 /97,7%/
5	Баруун бүс	105,274	-	-	-	11,593 /11%/	93,681 /89%/
	НИЙТ ӨРХ	902,609			8,6%	17,5%	73,7%

ЭМЗЭГ БАЙДАЛ

Аюулт үзэгдэл, осолд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин өртөж хохирох, сүйдэх зэргийг **ЭМЗЭГ БАЙДАЛ** гэнэ. Эмзэг байдал их байх тусам гамшгаас учрах хохирол төдий чинээ их байна. Эмзэг байдлыг гамшгийг хэмжих хэмжээс гэж үзэж болох бөгөөд энэ нь байгалийн хүчин зүйлээс илүү нийгмийн хүчин зүйлс болох эдийн засаг, соёл, улс төр, засаглалын бүхий л хүчин зүйлийн үр дүн юм. Эмзэг байдлыг дараах төрлөөр ангилж болно. Үүнд:

- **БИЕТ ЗҮЙЛИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ:** хүн ам, газар зүй, дэд бүтцийн эмзэг байдал
- **НИЙГМИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ:** хувь хүн, нийгэм улс төр, соёлын эмзэг байдал
- **ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ЭМЗЭГ БАЙДАЛ:** хүрээлэн буй орчны болон байгаль орчны төлөв байдал – агаар, ус, хөрсний доройтол, бохирдол, ойн ба усны менежментийн дутагдалтай байдал
- **ЭДИЙН ЗАСГИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ:** гамшгийг даван туулах санхүү, эдийн засгийн чадамжгүй байдал, ДНБ, нөөцийн хомсдол, эдийн засгийн тогтворгүй хараат байдал зэрэг бүхий зүйлс хамаарна.

Яагаад нэг ижил аюулд улс орон, орон нутаг бүр өөр өөрөөр өртдөг вэ? Үүний шалтгаан нь тухайн аюулд хэр зэрэг эмзэг байдалтай байгаатай холбоотой. Тодруулбал, өртөх байдал нь аюулын нөлөөлөлд өртөх нөхцөлийг зөвхөн илэрхийлдэг бол эмзэг байдал нь аюулын нөлөөлөлд өртөж хор хохирол учрах байдлыг илэрхийлдэг.



ШИГТГЭЭ 1.

МОНГОЛ УЛСАД ГАМШГИЙН ЭМЗЭГ БАЙДЛЫГ
НЭМЭГДҮҮЛЖ БУЙ ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛ

БИЕТ ЗҮЙЛИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ:



- Хот, суурин газар руу чиглэсэн хөдөөгийн хүн амын шилжилт хөдөлгөөн эрчимтэй нэмэгдэж байна. Өвөлжилтийн хүндрэл, эудын нөхцөл байдлаас шалтгаалан амьжиргааны эх үүсвэр болсон мал сүргээ алдсан малчин өрх, хөдөө орон нутгийн оршин суугч суурин газарт нүүдэллэн ирэх нь түгээмэл. **2021 ОНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭГЭЭР МОНГОЛ УЛСЫН НИЙТ ХҮН АМЫН 69.3% НЬ ХОТ, СУУРИН ГАЗАРТ АМЬДАРЧ БАЙНА.**
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ус, цаг агаарын гэнэтийн аюулт үзэгдлийн давтамж, эрчим нэмэгдэж байна.
- Томоохон хот суурин газарт газар ашиглалтын зохицуулалт сайн хийгдэхгүй байгаа нь шинээр буй барилгажсан талбайн ихэнх нь гамшиг, аюулт үзэгдлийн үед зай талбай бага, аврах ажиллагаа явуулах орон зай хязгаарлагдмал байдал бий болсон.
- Гамшигт тэсвэртэй барилга, зам гүүр, харилцаа холбоо, эрчим хүч, бусад дэд бүтцийн байгууламжийн хийц бүтээц, норм стандартыг мөрдүүлэхэд тавих хяналт сул.

НИЙГМИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ:



- Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хүн амд хүртээмжтэй хүрэхгүй байна. КОВИД-19 цар тахлын улмаас хүүхэд, залуучуудын боловсрол тасалдсан.
- Гамшиг, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаарх хүн амын ойлголт мэдлэг олж авах, ойлголтоо бататган гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах ажиллагаа хангалтгүй.
- Улс төрийн тогтвортой бус байдал.
- Уламжлалт арга ухаанаас суралцах, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх асуудал хязгаарлагдмал.

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ЭМЗЭГ БАЙДАЛ:



- Хот, суурин газарт агаар, ус, хөрсний бохирдол ихтэй, хөдөөд хөрсний доройтол, цөлжилт эрчимтэй явагдаж байна.
- Байгалийн унаган төрх, араншинд суурилсан гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний шийдлийг огт хэрэгжүүлдэггүй
- Ус, ойн менежментийн дутагдалтай байдал.

ЭДИЙН ЗАСГИЙН ЭМЗЭГ БАЙДАЛ:

- Ядуурлын түвшин бодитой буурахгүй байна. **2020 ОНЫ СТАТИСТИКИЙН СУДАЛГААГААР НИЙТ ХҮН АМЫН 27.8% ЯДУУРЛЫН ТҮВШИНД БАЙНА (ҮСХ, 2022). ХӨДӨӨГИЙН ХҮН АМЫН ЯДУУРЛЫН ТҮВШИН ХОТЫН ХҮН АМААС 4.0% ИЛҮҮ БАЙНА.**
- Гамшгаас урьдчилан сэргийлэх ажиллагаанд зарцуулах зардал гамшгийн дараа хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох зардлаас харьцангуй бага байна.
- Гамшгийн үеийн нөөцийн хомсдолтой байдал.

ГАМШГИЙН ЭРСДЭЛ

Эрсдэлийг аль салбарт хэрэглэж байгаагаас хамааран олон янзаар тодорхойлж болно. **ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ (ISO 31000:2020)-Д “ЭРСДЭЛ НЬ ЗОРИЛТЫГ ТОДОРХОЙ БУС БОЛГОЖ БҮЙ ҮР НӨЛӨӨ” ГЭЖ ТОДОРХОЙЛСОН.** Тодорхойгүй байдал нь сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй. Тодорхой бус байдал гэдэг нь аливаа тохиолдол, түүний үр дагавар болон тохиолдох магадлалын талаарх ойлголт, мэдлэгтэй холбоотой мэдээлэл зарим нэг талаар хангалтгүй байхыг хэлнэ¹ гэж тодорхойлсон.

Эрсдэл нь аливаа аюулын улмаас хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд хохирол учруулж болзошгүй хүчин зүйлийг таамаглан тусгасан ойлголт юм.

Хамгийн нийтлэг хэрэглэгдэж байгаа нь **“ЭРСДЭЛ НЬ АЮУЛ УЧРАХ МАГАДЛАЛ, ТҮҮНЭЭС ҮҮСЭХ СӨРӨГ ҮР ДАГАВАР”** гэх тодорхойлолт юм.

Эрсдэл = Магадлал x Үр дагавар

Магадлал нь гамшгийн аюул тохиолдох магадлал (0.25, 25%) эсвэл давтамжаар (10 жилд 1 удаа), үр дагавар нь учирч болзошгүй хохирлоор хэмжигдэнэ. Гамшгаас хамгаалах салбарт эрсдэлийг аюул, өртөх байдал, эмзэг байдал, чадавхын харилцан хамаарлаар тодорхойлно. Эрсдэл нь аюул, өртөх байдал, эмзэг байдалтай шууд, харин чадавхтай урвуу хамааралтай. Аюул, өртөх байдал, эмзэг байдал нэмэгдэхэд эрсдэл нэмэгдэнэ, харин чадавх нэмэгдэхэд эрсдэл буурна.

Гамшгаас хамгаалах тухай ХУУЛЬД **“ГАМШГИЙН ЭРСДЭЛ” ГЭЖ ГАМШГИЙН УЛМААС ХҮН АМ, МАЛ, АМЬТАН, ЭД ХӨРӨНГӨ, ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧИНД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ХОХИРЛЫН МАГАДЛАЛЫГ ХЭЛНЭ** гэж заасан.

Хүний амь нас, ахуй амьдралд сөргөөр нөлөөлж хор хохирол учруулсан байгалийн аюулаас гадна техник технологийн хөгжлийн нөлөөгөөр хүмүүс бид өөрсдөдөө аюул учруулах орчин нөхцөлийг бий болгосон. Үүний үр дүнд өнөөгийн нийгэм нь байгалийн болон технологийн гаралтай эрсдэлийн дунд амьдарч байна.

¹ ISO 31000:2020, Эрсдэлийн менежментийн стандарт

Орчин үеийн болон ирээдүйн эрсдэлүүд нийгэм эдийн засгийн тогтолцоонууд дахь технологи, санхүү болон улс төрийн хэлхээ холбоо гүнзгийрэхтэй холбоотойгоор улам бүр нарийн төвөгтэй болж тэдгээрийн өмнө байгаагүй шинэ хувилбарууд бий болж байна. Үүний нэг хэлбэр нь нийлмэл эрсдэлүүдтэй бид нүүр тулгарах болсон явдал юм. Нийлмэл эрсдэлүүд нь:

- харилцан уялдаатай эрсдэл,
- хавсарсан эрсдэл,
- цуварсан эрсдэл байж болно.

Жишээлбэл, зуны улиралд гантай, ирэх өвөл нь зудын гамшиг тохиолдвол түүнийг харилцан уялдаатай эрсдэл гэж үзэх юм. Монголчуудын аж амьдралд гангаас үүдэлтэй зудын эрсдэл элбэг тохиолддог. Хавсарсан эрсдэлийн хувьд, КОВИД-19 цар тахал дэлгэрч хөл хорио тогтоосон үед гэнэтийн үер тохиолдож, иргэд олон нийтийг нүүлгэн шилжүүлэх байранд шилжүүлэх үед халдварт өвчний дэглэм алдагдаж, тус байранд олон хүн халдвар авч амь насаа алдах тохиолдол байж болно. Цуварсан эрсдэлийн хувьд газар хөдлөлтийн дараа гал түймэр, аюултай бодисын осол тохиолдох магадлалтай.

Монгол Улсад түгээмэл тохиолддог гамшгийн төрлөөр нийлмэл эрсдэл үүсэх нөхцөлийг дараах хүснэгтэд харууллаа.

ХҮСНЭГТ 1.5. МОНГОЛ ОРОНД ТОХИОЛДОЖ БОЛОХ ЦУВАРСАН ЭРСДЭЛИЙН ЖИШЭЭ

Дагалдах эрсдэл	Газар хөдлөлт	Хөрсний гулсалт	Үер	Салхи шуурга	Аянга	Ган, цөлжилт	Зуд	Халдварт өвчин	Хортон амьтан тархах	Аюултай бодисын осол	Дэлбэрэлт	Гал түймэр	Ой, хээрийн түймэр	Дэд бүтцийн эвдрэл	Зам тээврийн осол
Газар хөдлөлт	■		■					■		■	■	■	■	■	■
Хөрсний гулсалт		■				■				■	■	■		■	■
Үер			■					■		■	■	■		■	■
Салхин шуурга				■		■				■	■	■	■	■	■
Аянга					■					■	■	■	■	■	■
Ган, цөлжилт			■			■		■							
Зуд							■	■							
Халдварт өвчин								■	■						
Хортон амьтан тархах								■	■						
Аюултай бодисын осол										■	■	■		■	■
Дэлбэрэлт										■	■	■	■	■	■
Гал түймэр										■	■	■	■	■	■
Ой, хээрийн түймэр				■					■	■	■	■	■	■	■
Дэд бүтцийн эвдрэл										■	■	■	■	■	■
Зам тээврийн осол										■	■	■	■	■	■
Тайлбар	■ Магадлал их		■ Магадлал дунд												


1.2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Дэлхий дахинд гамшгийн тохиолдол сүүлийн 20 жилд харьцангуй нэмэгдсэн. 2000-2009 оны хоорондох арван жил нь гамшгийн давтамжаар бүх цаг үеийн хамгийн оргил үе байна². Энэ арван жилд нэг жилд тохиолдох гамшгийн тоо 350-500 гаруй болтол огцом нэмэгдсэн. Дараагийн арван жил буюу 2021-2030 онд гамшгийн тохиолдол 40 орчим хувиар нэмэгдэх магадлалтай байна (Зураг 1.1).

ЗУРАГ 1.1. ГАМШГИЙН ТОХИОЛДЛЫН ТОО, ТӨЛӨВ
(ОЛОН УЛСАД, 1970-2030)



ЗУРАГ 1.2. АМЬ НАСАА АЛДСАН ХҮНИЙ ТОО, ТӨЛӨВ (ОЛОН УЛСАД, 1990-2020)



Эх сурвалж: Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн тайлан-2022

² GAR 2022, page 17

ЗУРАГ 1.3. ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН ТОХИОЛДЛЫН ТОО (МОНГОЛ УЛСАД, 2004-2021)



ЗУРАГ 1.4. ГАМШИГ, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСЛЫН УЛМААС АМЬ НАСАА АЛДСАН ХҮНИЙ ТОО (МОНГОЛ УЛСАД, 2004-2021)



Эх сурвалж: ОБЕГ, 2022

Гамшгийн улмаас амь насаа алдаж болзошгүй хүний тоо өсөх хандлага ажиглагдаж байна (Зураг 1.2). Олон улсад 2000-2009 онд гамшгийн давтамж өссөнтэй холбоотойгоор амь насаа алдсан хүний тоо өмнөх арван жилтэй харьцуулахад нэмэгдсэн бол дараагийн арван жилд нь буурсан хэдий ч коронавируст халдварт (КОВИД-19) цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2020-2022 онд гамшгийн улмаас амь насаа алдсан хүний тоо огцом нэмэгдсэн.

Монгол Улсад бүртгэгдсэн гамшиг, аюулт үзэгдэл, ослын тоо давтамж мөн нэмэгдэж байна. Коронавируст халдварт (КОВИД-19) цар тахлын мэдээллийг оролцуулахгүйгээр 2021 оныг 2004 онтой харьцуулахад гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдлын болон амь насаа алдсан хүний тоо тус бүр ойролцоогоор 1.8 дахин нэмэгдсэн байна (Зураг 1.3, 1.4).



Монгол Улсад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ус, цаг агаарын гаралтай гамшиг, аюулт үзэгдлийн тоо 2015 онтой харьцуулахад 2021 онд 2.9 дахин ↑ нэмэгдсэн байна. 2015-2021 онд усны ослоор амь насаа алдаж буй хүний тоо бусад гамшгийн төрлөөс харьцангуй их буюу дангаараа 55 ХУВИЙГ % эзэлж байна³. Цаашид уур амьсгалын гаралтай гамшгийн эрсдэл нэмэгдэх төлөвтэй байна.


Монгол Улсын эдийн засгийн гол салбар болох хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйн салбарт ган, зудын гамшгийн эрсдэл ихээхэн хохирол учруулдаг. Манай орны хувьд эдгээр гамшгийн эрсдэлийн төлөв байдлыг буюу зуд болон ган-зуд дараалсан гамшгийг хамтад нь оруулан⁴ зудын эрсдэлийг 2020-2022, 2030, 2050 оноор тооцож гаргасан судалгаагаар 2030 оны үед зудын эрсдэл их зэрэглэлд байх газар нутгийн хэмжээ 2020-2022 оны дунджаас 14.4%, нэн их эрсдэлтэй байх нутаг 3.4% нэмэгдэх төлөвтэй үр дүн гарсан байна. Харин 2050 оны түвшинд манай орны ихэнх нутгаар зудын эрсдэл бүхий газар нутгийн хэмжээ ихээхэн нэмэгдэж, тухайлбал Их нууруудын хотгор болон Алтайн өвөр говиор эрсдэл нэн их байх дүр зурагтай байна.



³ ОБЕГ, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийн Монгол Улсын дунд хугацааны тайлан, 2022

⁴ БОАЖЯ, НҮБХХ, УАНС, АДАПТ төслийн "Уур амьсгалын эрсдэлийн мэдээллийг ашиглан газар, ус, мал аж ахуйн менежментийг үндэсний болон орон нутгийн түвшинд төлөвлөх заавар, аргачлал, гарын авлага"-ын Эрсдэлийн төлөвлөлтийн багийн тайлан, 2023

ЗУРАГ 1.5. ЗУДЫН ЭРСДЭЛИЙН ЗУРАГ 2020-2022, 2030, 2050 (ЭХ СУРВАЛЖ: УЦУСМХ, 2023)



Зудын эрсдэл нь эрсдэл их, нэн их зэрэг хүрч болзошгүй газар нутгийн хэмжээ 2030, 2050 онд нэмэгдээд, үүний үр дүнд одоо байгаа бага, дунд зэрэг эрсдэлтэй газар нутгийн хэмжээ багасах нь цаашид зудын гамшгийн эрсдэлийн нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө нэмэгдэхээр байна (Хүснэгт 1.6).

ХҮСНЭГТ 1.6. ЗУДЫН ЭРСДЭЛ БҮХИЙ ГАЗАР НУТГИЙН ӨӨРЧЛӨЛТ, ХУВИАР (%)

ЭРСДЭЛИЙН ЗЭРЭГ	ЗУДЫН ЭРСДЭЛ БҮХИЙ ГАЗАР НУТГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХУВЬ	НУТАГ ДЭВСГЭРТ ЭЗЛЭХ ХУВЬ		ӨӨРЧЛӨЛТИЙН ХУВЬ	
	2020-2022 оны дундаж	2030 он	2050 он	2030 он	2050 он
Хамгийн бага	0.2	0	1.9	-0.2	1.7
Бага	17.2	9.7	10.2	-7.5	-7.0
Дунд зэрэг	43.2	33.1	20.9	-10.1	-22.3
Их	38.9	53.3	49.1	14.4	10.2
Нэн их	0.5	3.9	17.9	3.4	17.4

Эх сурвалж: УЦУСМХ, 2023

Ийнхүү өсөн нэмэгдэж байгаа гамшгийн эрсдэл нь гамшиг, гамшгийн эрсдэлийг танин мэдэх, ойлгох, урьдчилан сэргийлэх, учирч болзошгүй хохирлыг бууруулах арга замыг олж, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхаа бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг иргэд, олон нийтийн түвшинд төдийгүй, цаашлаад улс орны тогтвортой хөгжил, аюулгүй байдлын түвшинд авч үзэж, гамшгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

1.3. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эрсдэлийн удирдлагыг гамшгаас хамгаалах удирдлагад нэвтрүүлэх асуудал бол харьцангуй шинэ хандлага, үзэл баримтлал билээ. Эрсдэлийн удирдлагын ерөнхий арга зүйг гамшгаас хамгаалах удирдлагад хэрэглэснээр гамшигт хүргэж болох аливаа аюулын мөн чанарыг ойлгох, тэдгээрийн сүйрэл учруулахуйц хэмжээний хор уршиг, үр дагавраас урьдчилан сэргийлэх, аюулыг аль болох гаргуулахгүй байх арга замыг эрэлхийлэх боломжийг бага ч болов олгоно.

Эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь болзошгүй эрсдэлд хяналт тавьж түүнийг удирдахад оршино. Энэ зорилго нь эрсдэлийн удирдлагын хүрээнд тодорхойлогдсон багц арга хэмжээгээр хэрэгждэг байна.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Гамшгийн эрсдэлийн удирдлагын үндсэн зорилго нь боломжтой тохиолдолд аюул тохиолдохоос сэргийлэх, эсвэл бодлогын болон инженер техникийн оновчтой шийдэл, аюулд тэсвэртэй барилга байгууламж, түүнчлэн хүрээлэн буй орчинтой зохистой харьцах, олон нийтэд зөв мэдээлэл, мэдлэг өгөх зэрэг өргөн хүрээний асуудлыг хамарсан арга хэмжээг авч хэрэгжүүлж аюулд өртөх нийгмийн эмзэг байдлыг бууруулах замаар хохирлын хэмжээг багасгахад оршино.

Энэ үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийн үнэлгээ хийх, аюулын магадлал, түүнд өртөх эмзэг байдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэн болзошгүй аюулын сөрөг нөлөөллөөс зайлсхийх, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ хамаардаг. Гамшгийн эрсдэлийн удирдлагын үйл явц нь эрсдэлийг тодорхойлох, шинжлэх, үнэлэх, бууруулах, хянах болон нөхцөл байдлыг тодорхойлох, харилцан хамтарч ажиллах үйл ажиллагааг тодорхой бодлого чиглэлтэйгээр цогцоор хэрэгжүүлэх гэсэн өөр хоорондоо уялдаатай дараах үйл явцаас бүрдэнэ.



ЗУРАГ 1.6. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛ ЯВЦ



Гамшгийн эрсдэлийн удирдлагын үйл явц эрсдэлийн үнэлгээ болон эрсдэлийг бууруулах арга хэмжээ гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэж, эдгээрийг хамрах хүрээ, харилцан ажиллах ба зөвлөлдөх, хяналт ба мониторингийн үйл явцаар дэмждэг.

Хамрах хүрээнд гамшгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой гадаад, дотоод хүчин зүйл буюу бодлого, эрх зүй, удирдлага, зохион байгуулалт, зорилго, эрсдэлийн шалгуур, эрсдэлийг үнэлэх арга, аргачлал болон мэдээ, мэдээлэл зэргийг хамааруулдаг.

Харилцан ажиллах ба зөвлөлдөхийн зорилго нь холбогдох оролцогч талуудад эрсдэл, шийдвэр гаргах үндэслэл, тодорхой арга хэмжээ авах болсон шалтгааныг ойлгоход туслахад оршино. Холбогдох гадаад, дотоод оролцогч талуудтай харилцан ажиллах, зөвлөлдөх нь эрсдэлийн удирдлагын үйл явцын бүх үе шатанд явагдах ёстой.

Хяналт, мониторингийн зорилго нь эрсдэлийн удирдлагын үйл явцын хэрэгжилт, үр дүнгийн чанар, үр нөлөөг баталгаажуулах, сайжруулахад оршино. Хяналт, мониторингийг эрсдэлийн удирдлагын бүх үе шатанд хийнэ.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Гамшгийн эрсдэл бол аюулын улмаас хүний амь нас, эд хөрөнгө, байгаль орчинд учирч болох хохирлын хэмжээс юм. Аюулын зэрэг, аюулд өртөх байдал, учирч болох хохирлын буюу эмзэг байдлын зэргийн хамаарлыг эрсдэлийн үнэлгээ гэж нэрлэдэг. Болзошгүй аюулд өртөх магадлал учирч болох хохирлын хамаарлыг эмзэг байдлын үнэлгээ гэнэ. Тиймээс эрсдэлийг үнэлэхдээ эхлээд ямар нэг аюулын зэргийн үнэлгээ буюу аюул тохиолдох магадлалыг тодорхойлно. Дараа нь эмзэг байдлын үнэлгээгээр тохиолдож болзошгүй аюулын улмаас учирч болох хохирлыг тодорхойлдог.

$$R = H * \frac{VE}{C}$$

Энд,
 R - эрсдэл;
 H - аюул
 V - эмзэг байдал
 E - өртөх байдал
 C - чадавх
 * - харилцан үйлчлэлийн тэмдэглэгээ.

Эдгээрийн хоорондын уялдаа холбоог үзвэл, гамшгийн эрсдэл нь аюул, эмзэг байдлаас шууд хамааралтай харин чадавхтай урвуу хамааралтай байна. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ нь зорилгоосоо хамаараад олон төрөл, хэлбэртэй байна. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний бүтээгдэхүүнийг буюу үр дүнг ямар зүйлд ашиглахад тохиромжтойг тодорхойлох нь үнэлгээний зорилгоос хамаарах төдийгүй түүнд ямар шийдвэр гаргагчид, оролцогч талууд оролцсон, үр дүнг нь хэрхэн ашиглах, үнэлгээний цар хүрээ, ашиглагдах мэдээнд тавигдах шаардлага, шинжилгээний нарийвчлал, нөөцийн бэлэн байдал зэрэг бусад олон хүчин зүйлээс хамаардаг.

Засгийн газрын 2020 оны 190 дүгээр тогтоолоор баталсан Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журамд **“ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГЫГ ХҮН АМ, ТОДОРХОЙ НУТАГ ДЭВСГЭР, ХУУЛИЙН ЭТГЭЭД, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ТОХИОЛДОЖ БОЛЗОШГҮЙ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХӨД ОРШИНО”** гэж тодорхойлсон.

Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалаар баталсан **“ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗААВАР”-Т** гамшгийн эрсдэлийн үнэлгээг эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг шинжлэх, эрсдэлд үнэлэлт өгөх гэсэн гурван үе шаттай хийнэ гэж тодорхойлсон.

- **ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ.** Эрсдэлийг тодорхойлох хүрээнд тохиолдож болзошгүй гамшгийн аюулын ямар эх үүсвэр байгааг илрүүлэх буюу аюулыг олж, тухайн аюулд хэн, юу өртөж болохыг тогтооход чиглэсэн өртөх байдал, эмзэг байдлын үнэлгээг хийнэ.
- **ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ШИНЖЛЭХ.** Эрсдэлийг шинжлэх нь олж тогтоосон аюулын тохиолдох магадлал, түүнээс учрах хор уршгийг шинжилж, эрсдэлийн түвшнийг тогтоох арга хэмжээ юм. Гамшгаас хамгаалах чадавхыг тодорхойлж, чадавхын энэ нөхцөлд гамшгийн эрсдэлийн тохиолдох магадлал, учирч болох хор уршиг нь ямар байхыг шинжилнэ. Энэ шинжилгээ аюул тохиолдох магадлал ямар байгааг болон тухайн аюулаас ямар хохирол учирч болохыг тодорхойлно. Шинжилгээний үр дүнд тулгуурлан эрсдэлийн түвшнийг тооцно.
- **ЭРСДЭЛИЙГ ДҮГНЭХ.** Урьдчилан боловсруулсан шалгууртай эрсдэлийн түвшнийг харьцуулан эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай эсэхээр нь эрсдэлийг зэрэглэнэ.

Манай улсын хувьд гамшгийн эрсдэлийн үнэлгээг ерөнхий болон нарийвчилсан гэсэн 2 төрлөөр хийх эрх зүйн зохицуулалттай. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний төрлүүдийн ялгааг дараах хүснэгтэд харьцуулав.

ХҮСНЭГТ 1.7. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ТЭДГЭЭРИЙН ОНЦЛОГ

ҮЗҮҮЛЭЛТ	ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ	ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ
ЗОРИЛГО	Гамшгийн эрсдэлийг тойм, суурь судалгаа байдлаар тодорхойлох	Гамшгийн эрсдэлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр мэргэжлийн түвшинд нарийвчлан тодорхойлох, болзошгүй хохирлын хэмжээг тооцох, түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээг төлөвлөх үндсийг бүрдүүлэх
ХИЙХ ЭЗЭН	<ul style="list-style-type: none"> ➤ Улсын болон стратегийн онц чухал объектын түвшинд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний томилсноор онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, холбогдох салбарын мэргэжилтэн, эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн ажлын хэсэг; ➤ Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд тухайн шатны Засаг даргын томилсноор төрийн байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг; ➤ Салбарын түвшинд тухайн салбарын удирдлагын томилсноор гамшгаас хамгаалах улсын алба, тухайн салбарын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг. 	<p>Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.3 дахь хэсэгт заасны дагуу шаардлага хангасан тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд хийнэ.</p> <p>Тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд дараах чиглэлээр олгоно:</p> <ul style="list-style-type: none"> ➤ уул уурхай; ➤ дэд бүтэц; ➤ хөдөө аж ахуй; ➤ байгаль орчин, түүх соёлын дурсгалт газар; ➤ үйлдвэр, үйлчилгээ; ➤ эрүүл мэнд.
ҮЕ ШАТ	<ul style="list-style-type: none"> ➤ Гамшгийн эрсдэлийг тодорхойлох; ➤ Аюулыг тодорхойлох; ➤ Өртөх байдал, эмзэг байдлыг тодорхойлох; ➤ Чадавхыг үнэлэх; ➤ Эрсдэлийн түвшин тогтоох. ➤ Гамшгийн эрсдэлийг үнэлэх: ➤ гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай эрсдэлийн маш их/их түвшинд байгаа гамшгийн төрлийг тодорхойлох; ➤ Маш их, их, дунд түвшинд байгаа эрсдэлийг бууруулах, бага, маш бага түвшинд байгаа эрсдэлийг цаашид хянах, тогтвортой байдлыг хадгалах талаар зөвлөмж боловсруулах. 	<p>Гамшгийн эрсдэлийг тодорхойлох:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Аюулыг үнэлэх (оршин байгаа нутаг дэвсгэрт тохиолдож болох аюулт үзэгдэл, ослын эх үүсвэрийг тогтооно, зураглал гаргана); ➤ Өртөх байдал, эмзэг байдлыг үнэлэх (тохиолдож болзошгүй аюулт үзэгдэл, ослын хүн ам, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлно, зураглал гаргана); ➤ Чадавхыг үнэлэх (тухайн нутаг дэвсгэр, салбар, аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, чадавх, нөөцийг болзошгүй

		<p>аюулын төрөл тус бүрээр авч үзэж тогтооно).</p> <p>Гамшгийн эрсдэлийг шинжлэх:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Тодорхойлогдсон аюул бүрийн тохиолдох магадлалыг тооцох; ➤ Аюул бүрээс хохирол учрах магадлал, болзошгүй хохирлын тооцоо, төсөөлөл, үр дагаврыг шинжлэх; ➤ Учирч болох эрсдэлийн түвшин тогтоох. <p>Гамшгийн эрсдэлийг дүгнэх:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Эрсдэлийг зэрэглэх; ➤ Эрсдэлийг бууруулах зөвлөмж боловсруулах.
--	--	---

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнд эрсдэлийн түвшнийг тодорхойлж, үзүүлж болзошгүй нөлөөллийн хэмжээгээр нь зэрэглэн, эрсдэлийг бууруулах шаардлагатай арга хэмжээг тодорхойлно (Хүснэгт 1.8).

ХҮСНЭГТ 1.8. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ТҮВШИН, ЗЭРЭГЛЭЛ

ЭРСДЭЛИЙН ТҮВШИН	ЭРСДЭЛИЙН ЗЭРЭГЛЭЛ, ӨНГӨ	ӨНГӨНИЙ КОД	ЕРӨНХИЙ ТАЙЛБАР
МАШ ИХ	5	R: 255 G: 0 B: 0	Зайлшгүй бууруулах арга хэмжээ авах шаардлагатай эрсдэл: Эрсдэлийг бууруулах арга хэмжээг нэн тэргүүнд авах.
ИХ	4	R: 255 G: 192 B: 0	Анхаарах, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай эрсдэл. Тухайн нөхцөл байдалд тохирсон урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
ДУНД	3	R: 255 G: 255 B: 0	Хяналтад байх шаардлагатай, хүлцэх эрсдэл, бууруулах арга хэмжээг төлөвлөж, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр хэрэгжүүлэх
БАГА	2	R: 146 G: 208 B: 80	Ажиглах шаардлагатай эрсдэл, урт хугацаанд эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хадгалах хариу арга хэмжээг төлөвлөх, тухайн нөхцөл байдлыг хяналтдаа байлгах, баримтжуулах;
МАШ БАГА	1	R: 0 G: 176 B: 80	Ажиглах шаардлагатай эрсдэл, ямар нэг арга хэмжээ авах шаардлагагүй, тухайн нөхцөл байдалд хяналт тавих, ажиглах

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний дүн нь гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах үндэслэл болно. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний үйл

явцыг, үнэлгээний үр дүнтэй хамт баримтжуулж, гамшгийн эрсдэлийн үнэлгээний тайланд тусгана.

ШИГТГЭЭ 2:

ЗУДЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНД АВЧ ҮЗЭХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зудын эрсдэлийн үнэлгээг аюул, өртөх байдал, эмзэг байдал, чадавхын үзүүлэлтүүдэд тулгуурлаж хийнэ. Монгол орны хувьд зудын эрсдэл цаг агаарын нөхцөл байдлаас ихээхэн шалтгаална.

ЭРСДЭЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН	ҮНЭЛГЭЭНД АШИГЛАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД
АЮУЛЫН ҮЗҮҮЛЭЛТ	<ul style="list-style-type: none"> ➤ дундаж агаарын температур ➤ цасны нягт, зузаан, агаарын температур ➤ ган ➤ үргэлжлэх хугацаа ➤ давтамж ➤ салхитай өдрийн тоо
ӨРТӨХ БАЙДАЛ ҮЭМЗЭГ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ	<ul style="list-style-type: none"> ➤ өртөх магадлалтай хүн ам, мал ➤ хүн амын бүтэц, тархалт суурьшил ➤ дэд бүтэц, түүний сул талууд ➤ малын тарга хүч ➤ малчин өрхийн эдийн засгийн чадавх ➤ өвс, тэжээлийн нөөц ➤ байгаль орчин түүний өртөмтгий чанар ➤ хөдөө аж ахуйн дэд бүтэц, өвөлжөө хаваржаа, худаг ус ➤ малын чанар, сүргийн бүтэц
ЧАДАВХЫН ҮЗҮҮЛЭЛТ	<ul style="list-style-type: none"> ➤ удирдлагын тогтолцоо ➤ зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөлт, бэлэн байдал ➤ мэдээллийн хэрэгслээр хангагдсан байдал болон мэдээллийг түгээх үйл ажиллагаа ➤ нөөц, хүч хэрэгслийн боломж ➤ эдийн засгийн чадавх, малчдын орлого ➤ нийгмийн үйлчилгээний боломж ➤ малчдын туршлага, ур чадвар, сургалт.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Гамшгийн эрсдэлийг бууруулах нь эхний ээлжид болзошгүй аюулын тохиолдох магадлал, түүнд өртөх байдал, эмзэг байдлыг бууруулж аюулын сөрөг нөлөөллийг багасгах, харин буурах боломжгүй олон хүчин зүйлсээс шалтгаалсан үлдэгдэл эрсдэлийг удирдах чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ авах гэсэн асар өргөн хүрээний асуудал юм.

Эрсдэлээс бүрэн гүйцэд ангижирч чадахгүй ч түүний хамрах хүрээ, учирч болзошгүй хохирлын хэмжээг олон төрлийн стратеги, арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд бууруулж болно.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЕРӨНХИЙ СТРАТЕГИ



Гамшгийн эрсдэлийг бууруулах хэд хэдэн ерөнхий стратеги бий. Үүнд:

- ЭРСДЭЛИЙН МАГАДЛАЛЫГ БАГАСГАХ,
- ЭРСДЭЛИЙН ҮР ДАГАВРЫГ БАГАСГАХ,
- ЭРСДЭЛЭЭС ЗАЙЛСХИЙХ,
- ЭРСДЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ,
- ЭРСДЭЛИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, ХУВААЛЦАХ БОЛОН ТАРХААХ.

1. ЭРСДЭЛ ТОХИОЛДОХ МАГАДЛАЛЫГ БАГАСГАХ

Тохиолдох нь нэгэнт тодорхой байгаа аюулын тохиолдох боломжийг бууруулж болно. Өөрөөр хэлбэл эдгээр аюулын тохиолдох магадлалыг нь багасгахад эрсдэлийн түвшин буурна. Гэхдээ аюул бүрийн хувьд тохиолдох магадлалыг нь багасгах боломжгүй. Тухайлбал, байгалийн аюулт үзэгдлийн хувьд тохиолдох магадлалыг бууруулах боломж хүний үйл ажиллагаатай холбоотой ослыг бодвол харьцангуй бага.

Технологийн болон хүний буруутай үйл ажиллагаатай холбоотой аюулууд нь хүний үйл ажиллагаа, тэдгээрийн гаргаж байгаа шийдвэртэй холбоотой байх учраас аюулын магадлалыг багасгахад чиглэсэн арга хэмжээг өргөнөөр хэрэглэж болно. Хот суурин газарт гэнэтийн хүчтэй аадар бороо, үргэлжлэн орох зүсэр борооны улмаас үер буух эрсдэл өндөр байдаг.

Иймд үерийн эрсдэлийн магадлалыг багасгахын тулд үерийн усанд автаж болзошгүй газарт газар ашиглалтыг оновчтой хийж, хамгаалах далан, суваг байгуулах, мод тарьж байгалийн аргаар их усыг шингээх гэх зэрэг арга хэмжээг авч болох юм. Ингэснээр хот суурин газарт учирч болзошгүй үерийн эрсдэлийн тохиолдлыг багасгана.

2. ЭРСДЭЛИЙН ҮР ДАГАВРЫГ БАГАСГАХ

Гамшгийн эрсдэлийг бууруулах хүрээнд зайлшгүй хийгдэх хоёр дахь зүйл бол хүн ам, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учрах аюулын нөлөөллийг буюу хор уршгийг багасгах явдал юм. Аюулын нөлөөллийг багасгах арга хэмжээ нь тодорхой хэмжээний эрч хүчтэй аюул тохиолдоход түүнийг ямар нэг сөрөг үр дагаваргүйгээр тэсвэрлэж гарч чадахаар хүн ам, эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авахад бүхэлдээ чиглэгдэнэ.

Ихэнх аюулын хувьд аюулын магадлалыг багасгахтай харьцуулахад аюулын үр дагаврыг багасгах хэд хэдэн сонголт байдаг. Байгалийн аюулт үзэгдлийн хувьд эдгээр арга хэмжээ хүний амь насыг хамгаалах, хийц бүтээцийг хүчитгэхэд чиглэсэн арга хэмжээнүүд бий. Технологийн аюулын тухайд бол аюулгүй байдлыг сайтар хангаснаар эрсдэлээс хүлээх үр дагаврыг багасгаж болно.

Одон орон, геофизикийн хүрээлэнгээс 2020 онд боловсруулан гаргасан газар хөдлөлтийн ерөнхий мужлалын зургаас харахад **МАНАЙ ОРНЫ НИЙТ НУТАГ ДЭВСГЭРИЙН 66.1 ХУВЬ НЬ ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН VII-X БАЛЛЫН ЭРЧМИЙН БҮСЭД БАЙНА.** Бид газар хөдлөлтийн аюул тохиолдох магадлалыг удирдаж чадахгүй тул түүнд өртөж эвдрэх, нурах магадлалтай барилга, дэд бүтцийг хүчитгэх, дахин сайжруулан барих нь үр дагаврыг бууруулах арга хэмжээ болно.

3. ЭРСДЭЛЭЭС ЗАЙЛСХИЙХ

Зарим эрсдэлүүд түүний магадлал ба үр дагаврын аль алиныг нь ямар нэг байдлаар багасгасан ч ноцтой байдал нь хэвээр хадгалагдаж үр дүн нь эрсдэлийг хүлээн авах түвшинд хүрэхгүй байдалтай байдаг. Эдгээр эрсдэлийн хувьд магадлал ба үр дагаврыг нь багасгах арга хэмжээ авах шаардлагагүй тул түүнээс зайлсхийх нь үр дүнтэй.

Байгалийн аюулт үзэгдлийн хувьд эрсдэлээс зайлсхийхийн тулд ихэвчлэн тухайн аюулын нөлөөлөлд өртөх газраас нүүх арга хэмжээ авдаг. Газар хөдлөлт зэрэг их хэмжээний газар нутгийг хамарсан аюулын хувьд эрсдэлээс зайлсхийх нь боломжгүй зүйл юм. Харин тодорхой газар нутгийг хамарч тохиолдох үер, хүчтэй салхи гэх мэт аюулын хувьд эрсдэлээс зайлсхийх боломжтой бөгөөд энэ тохиолдолд тухайн аюулд өртөх боломжтой бүх зүйлийг зайлуулж, дахиж тухайн газарт барилга, байгууламж барих, суурьшихыг хориглож болно.

Эрсдэлээс зайлсхийх стратегийг тухайн эрсдэлийг хүлээж авбал нийгэмд маш ноцтой аюул учруулж болохуйц технологийн ослын хувьд ихэвчлэн хэрэглэгддэг.



Төв, суурин газарт үерийн усанд өртөх байдлын зэрэг өндөр, цэвдэг, хөрсний ус нэвчилттэй газарт газар ашиглалтыг зөв төлөвлөж барилга байшин, орон сууцны хороолол барихгүй байх, үүний оронд цэцэрлэгт хүрээлэн байгуулах, байгаль экологийн танин мэдэхүйн төв болгох зэрэг арга хэмжээг авч болох юм. Улаанбаатар хот, аймаг, сумын төвийн шинэ төлөвлөлт, дахин төлөвлөлт хийхдээ эрсдэлийн мэдээлэлд суурилан эрсдэлээс зайлсхийх арга хэмжээг авах нь зүйтэй. Зудын эрсдэлээс зайлсхийж малчид цас багатай, газрын гарц сайтай нутагт отор нүүдэл хийж, өвөлжих монголын уламжлалт арга байна.

4. ЭРСДЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ

Зарим нэг төрлийн аюулын хувьд тухайн нийгэм ба хувь хүний зүгээс тодорхой эрсдэл байхыг хүлээн зөвшөөрдөг. Энэ тохиолдолд тухайн эрсдэлийг бууруулах шаардлагагүй эсвэл эрсдэлийг бууруулах зардал хэт өндөр байна. Энэ шийдвэрт хүргэх хэд хэдэн шалтгаан байж болно.

Нэгдүгээрт, улс орон, бүс нутаг ба орон нутаг бүрд тэмцэхээс өөр аргагүй эсвэл тухайн аюулыг бууруулах арга хэмжээ авахад шаардлагатай хөрөнгө, санхүү хангалтгүй байх аюулууд байдаг. Тодорхой эрсдэлийн хувьд зардал-ашигын шинжилгээ хийж түүнийг бууруулах арга хэмжээ авахгүйгээр үлдээж, түүний оронд бусад аюулын эрсдэлийг бууруулах арга хэмжээг авах нь ихээхэн үр ашигтай байж болно.

Хоёрдугаарт, зарим эрсдэлийг бууруулах арга хэмжээ нь олон хүсээгүй үр дагаварт хүргэж болно. Ийм хоёрдогч эрсдэл нь аюултай нөхцөлийг бий болгож хүсэж байсан үр дүнг бууруулдаг эсвэл хүсээгүй үр дагавар нь эрсдэлийг бууруулах арга хэмжээний шууд үр дүн байдлаар гарч ирэхээр байж болно. Аль ч тохиолдолд хоёрдогч үр дагавар одоогийн эрсдэлийн үр дагавраас илүү аюултай нөхцөлийг бий болгож, тодорхой бус байдлыг нэмэгдүүлнэ.

Аливаа гамшгийн үед барилга, дэд бүтцийн эвдрэл, гэмтэл нь хүний амь нас, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд шууд хохирол учруулдаг. Тиймээс газар хөдлөлт, гал түймэрт тэсвэртэй барилга, байгууламж, хүчтэй салхи шуурганд тэсвэртэй дэд бүтэц, үерийн усанд тэсвэртэй авто зам зэргээр гамшигт тэсвэртэй барилга, байгууламж, дэд бүтцийг бий болгох нь тухайн эрсдэлийг хүлээн авч, болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээний нэг болно.



Монгол Улсад газар хөдлөлтийн VIII баллд тэсвэртэй барилга, орон сууц баригдаж байгаа нь сайшаалтай хэдий ч угсралтын үед норм, стандартыг зөрчих асуудал хожим ихээхэн хэмжээний эрсдэлийг дагуулах тухай ойлголтыг холбогдох талуудад тогтмол өгөх, хянах, сайн туршлага, туршилт, техник технологийн ололт амжилтад суурилан барилгын норм, стандартыг цаашид хөгжүүлэх, сайжруулах нь зохилтой.

2023 оны 2 дугаар сард Бүгд Найрамдах Турк Улсын өмнөд хэсэг, Арабын Бүгд Найрамдах Сири Улсын хойд хэсэгт тохиолдсон 7.8 магнитудын хүчтэй газар хөдлөлтийн улмаас 50000 гаруй хүн амь насаа алдсаны ихэнх хувь нь барилга байгууламжийн нурангид дарагдсан. Турк Улсын Засгийн газраас барилгын норм, дүрэм, стандартыг хангаж ажиллаагүй гэсэн үндэслэлээр барилгын компанийн удирдлага, архитектор, инженерүүд зэрэг холбогдох хүмүүст хэрэг үүсгэн шалгах шийдвэрийг гаргасан байна. Турк Улсын Хатай хот хамгийн их хохирол амссан хотын нэг бөгөөд нийт барилга байгууламжийн 80 орчим хувь ашиглах боломжгүй нурсан байна.

5. ЭРСДЭЛИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, ХУВААХ ЭСВЭЛ ТАРХААХ

Гамшгийн эрсдэлийг бууруулах талаар хамгийн түгээмэл хэрэглэгддэг стратеги нь эрсдэлийг шилжүүлэх, хуваах, тархаах юм. Энэ стратегийн гол санаа нь эрсдэл буурахгүй, гэхдээ нэрвэгдэгч бүрт дундаж үр дагавартай байхаар том бүлгийн хүрээнд түүний магадлал, үр дагаврыг сулруулах явдал юм.

Эрсдэлийг шилжүүлэх хамгийн түгээмэл хэлбэр бол даатгал, олон улсын давхар даатгал юм. Даатгал нь эд хөрөнгийн мөнгөн хэмжээний хохирлыг арилгаж эрсдэлийн санхүүгийн үр дагаврыг бууруулдаг. Даатгуулагчид учирч болзошгүй аюулын магадлал, үр дагаварт үндэслэж тогтоосон даатгалын хураамжийг төлдөг. Энэ нь тухайн даатгуулсан аюул тохиолдсон үед хохирлоо нөхөн төлүүлэх баталгаа болно. Гамшгийн хохирол энэхүү даатгалын хураамжийг төлсөн бүх хэрэглэгчдэд хуваагдаж, нэрвэгдсэн, нэрвэгдээгүй ялгаагүйгээр ижил хураамж төлж гамшгийн үр дагаврыг цуглуулсан хамтын сангаараа даван туулах арга хэрэгслийг олон улс оронд хэрэглэж байна.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль 2014 оноос Монгол Улсад хэрэгжиж эхэлснээс 21 аймгийн 330 сум, нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд малын индексжүүлсэн даатгалын үйлчилгээг үзүүлж байна. 2016-2021 онд нийт малчин өрхийн 11.7-19.8 хувь буюу өссөн дүнгээр 172.2 мянган малчин өрх 39.6 сая малыг 18.8 тэрбум төгрөгөөр даатгуулан 4.7 тэрбум төгрөгийн нөхөн олговрыг авсан байна.

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛД ХАМРАГДСАН БАЙДАЛ

ОН	ХАМРАГДСАН МАЛЧИН ӨРХ	НИЙТ МАЛЧИН ӨРХӨД ЭЗЛЭХ ХУВЬ	ДААТГАГДСАН МАЛЫН ТОО	НИЙТ МАЛД ЭЗЛЭХ ХУВЬ	ХУРААМЖИЙН ОРЛОГО /ТЭРБУМ.ТӨГ/	НӨХӨН ТӨЛБӨР /САЯ. ТӨГ/
2016	18738	11.7	4.2	7.5	1.77	79.6
2017	24148	15.3	5.7	9.2	2.33	1091.9
2018	33719	19.8	7.8	11.8	3.46	323.3
2019	32337	18.8	7.4	11.2	3.85	600.9
2020	28527	16.6	7.1	10.2	3.48	2593.3
2021	34709	19.2	7.4	11.0	3.92	
НИЙТ	172178		39.6		18.81	4689.0

Малын индексжүүлсэн даатгалд хамрагдсан малын тоо, хураамжийн орлого, нөхөн олговор нь жил бүр харилцан адилгүй байгаа нь тухайн жилийн зуншлага, цаг агаарын нөхцөл байдлаас хамааралтай юм.

Эдгээр гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийн хүрээнд эрсдэлийг бууруулахад чиглэсэн олон төрлийн арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.



ГАМШГИЙН
ЭРСДЭЛИЙГ
БУУРУУЛАХ АРГА
ХЭМЖЭЭГ
БҮТЦИЙН БОЛОН
БҮТЦИЙН БУС
ГЭЖ 2 ЧИГЛЭЛД
ХУВААНА.



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ БҮТЦИЙН АРГА ХЭМЖЭЭ НЬ:

Инженерийн шийдлийг хэрэглэж барилга байгууламж, объект, зам, гүүр зэрэг дэд бүтэц, биет зүйлийн аюулгүй болон гамшигт тэсвэртэй байдлыг хангах арга хэмжээг ойлгоно. Тухайлбал,

- Гамшигт тэсвэртэй барилга, байгууламж барих;
- Барилга, байгууламжийн норм, дүрэм мөрдүүлэх;
- Нүүлгэн суурьшуулах;
- Барилга, байгууламжийн хийц, бүтээцийг хувиргах;
- Хаах, өөрчлөх, тогтоох системийг барих;
- Аюулыг илрүүлэх систем бий болгох;
- Аюулыг зайлуулах систем барих гэх мэт.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ БҮТЦИЙН БУС АРГА ХЭМЖЭЭ НЬ:

Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартыг мөрдөх, гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах болон бусад арга хэмжээг ойлгоно. Тухайлбал,

- Хууль эрхзүйн зохицуулалт бий болгох
- Сургалт явуулж гамшгийн талаар мэдлэг, боловсрол олгох
- Хүрээлэн буй орчинд хяналт тавих
- Хүмүүсийн зан төлөв, хандлагыг өөрчлөх гэх мэт.

ҮЛДЭГДЭЛ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА НЬ бууруулж болохгүй, мөн урьдчилан сэргийлэх боломжгүй эрсдэлд буюу үлдэгдэл эрсдэлд чиглэсэн бодлого, үйл ажиллагаагаар тодорхойлогдоно. Энэ төрлийн эрсдэлийг б0элэн байдлыг хангах, хор уршгийг арилгах арга хэмжээ авах, сэргээн босгох арга замаар удирддаг бөгөөд эдгээрээс бэлэн байдлыг хангах нь үлдэгдэл эрсдэлийг үр дүнтэй удирдах арга зам болно. Үлдэгдэл эрсдэлийн удирдлагад нь дараах арга хэмжээнүүд багтана. Үүнд:



- Бэлэн байдлын төлөвлөгөө гаргах
- Сургалт, дадлага хийх
- Эрт зарлан мэдээлэх системийг бий болгох
- Нүүлгэн шилжүүлэх
- Хор уршгийг арилгах арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх
- Нөөцийн хадгалалт, түгээлтийг бий болгох.

Гамшгийн эрсдэлийн удирдлагыг 3 үе шаттай арга замаар хэрэгжүүлнэ гэж үзэж болно. Үүнд: Эрсдэлийн тухай ойлголттой болох, дараа нь эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах, сүүлд нь үлдэгдэл эрсдэлийг удирдах (Кумар, 2014) юм.

 <p>ЭРСДЭЛИЙГ ОЙЛГОХ</p>	 <p>ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ</p>	 <p>ҮЛДЭГДЭЛ ЭРСДЭЛИЙГ УДИРДАХ</p>
<ul style="list-style-type: none"> ➤ АЮУЛ, ӨРТӨХ БАЙДАЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ ➤ БОЛЗОШГҮЙ ХОХИРОЛ /Гамшгийн эрсдэлийн тухай ойлголт, үнэлгээний асуудал/ 	<ul style="list-style-type: none"> ➤ АЮУЛГҮЙ БАРИЛГА ➤ ХҮЧИТГЭХ /Бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээ 	<ul style="list-style-type: none"> ➤ ЭРТ СЭРЭМЖЛҮҮЛЭГ ➤ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ/ХОР УРШГИЙГ АРИЛГАХ ➤ ДААТГАЛ /Бэлэн байдлыг хангах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох/

Эрт зарлан мэдээллийн системийг хөгжүүлэх нь үлдэгдэл эрсдэлийг удирдахад чухал үүрэгтэй. Урьдчилан сэргийлж, зайлсхийх боломжгүй нэгэнт тулгарч болзошгүй аюулыг эртнээс сэрэмжлүүлэх зарлан мэдээллийг иргэдэд хүргэснээр хүний амь насыг хамгаална.

Тухайлбал, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас цаг агаарын гэнэтийн хүчтэй аюулт үзэгдлийн тохиолдол нэмэгдэж буй нөхцөл байдалд хүчтэй салхи шуурга, гэнэтийн хүчтэй аадар борооны сэрэмжлүүлгийг иргэд эрт хүлээн авснаараа хүүхдээ малд явуулахгүй байх, алсын замд гарахгүй байх, ой хээрийн түймрийн нөхцөл байдлын мэдээллийг урьдчилан авснаар түймрийн бүсээс шилжиж нүүх, газар хөдлөлтийн амжиж анхааруулах мэдээг хүлээн авч богино хугацаанд аюулгүй газар байрлах зэрэг олон үйлдлийг хийх хугацаа олгодог. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаас дэвшүүлсэн “Хүн бүрт эрт зарлан мэдээллийг хүргэх” уриалгад 2027 он гэхэд дэлхийн хүн бүр аюулаас эрт сэрэмжлүүлэх мэдээг хүлээн авч гамшгаас хамгаалагдах болно гэж заажээ.

Монгол Улсын хувьд Гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх системийг хөгжүүлэхэд анхаарал хандуулж ирсэн хэдий ч гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх системийн бэлэн байдлыг хангахад хүндрэл бэрхшээлтэй хэвээр байна. ОБЕГ дэргэдэх Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн гамшгийн аюулыг зарлан мэдээлэх систем нь 2013 онд ашиглалтад орсон. Тус систем нь газар хөдлөлт болон бусад аюулт үзэгдлийн үед ШУА-ын Одон орон геофизикийн хүрээлэн, Цаг уур орчны шинжилгээний газраас мэдээ мэдээллийг хүлээн авч Улаанбаатар хотод суурилуулсан хэт богино долгионы дахин дамжуулах 4 бааз станцаар дамжуулан дуут дохиоллын 60 ширхэг цамхаг, өргөн нэвтрүүлгийн 3 телевиз, 10 FM радиогоор гамшгийн аюулыг анхааруулах, сэрэмжлүүлэх мэдээг иргэд, олон нийтэд дамжуулахаар зохион байгуулагдсан. Гэвч үүрэн холбооны оператор компаниудаар дамжуулан иргэд, олон нийтэд гамшиг, аюулт үзэгдлийн тухай багц мессеж, сэрэмжлүүлэг хүргэх үйлчилгээ технологийн дэвшлээс хамааран хоцрогдож байна.

1.4.УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨӨС ГАМШГИЙН ЭРСДЭЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Уур амьсгалын өөрчлөлт гэж уур амьсгал байгалийн жам ёсоороо хэлбэлзэх хугацааны туршид хүний шууд болон шууд бус үйл ажиллагааны улмаас дэлхийн хийн мандлын бүтцэд гарч байгаа өөрчлөлтийн дүнд бий болсон өөрчлөлтийг хэлнэ⁵.

Уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгаан нь байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөө, түүний дотор хүний үйл ажиллагааны улмаас агаар мандалд ялгарч байгаа хүлэмжийн хий юм.

Евроазийн эх газрын төвд сэрүүн уур амьсгалын бүсэд орших далайд гарцгүй Монгол Улсын хувьд газар зүйн байршил, эмзэг экосистем, байгаль цаг агаараас хараат эдийн засгийн тогтолцоо зэргээсээ шалтгаалан уур амьсгалын өөрчлөлтөд нэн өртөмтгий байдаг.

Уур амьсгалын хувьсал, өөрчлөлт манай орны нутаг дэвсгэрт мэдэгдэхүйц илэрч үүний нөлөөгөөр сүүлийн тавиад жилд Монгол оронд:

- бэлчээр доройтон цөлжих үйл явц идэвхжих;
- ургамлын зүйлийн бүрдэл цөөрөх;
- зэрлэг ан амьтдын тархцын бүс хумигдах, тоо толгой нь хорогдох;
- тал хээрийн бүсэд усны нөөц хомсдох;
- цаг агаарын гэнэтийн аюул үзэгдэл (аадар бороо, мөндөр, хүчтэй цасан болон шороон шуурга, уруйн үер) нэмэгдэх;
- хуурайшилтын улмаас ой, хээрийн түймрийн давтамж нэмэгдэх;
- ган, зудын давтамж ойртож, эрчим нь нэмэгдэж байна⁶.

- Монгол орны нутаг дэвсгэр уур амьсгалын хувьд агаарын температур эрс тэс, хур тунадасны хэлбэлзэл ихтэй байдгаараа онцлог юм. Агаарын жилийн дундаж температур нийт нутаг дэвсгэрт -8°C-аас +8°C, жилийн дундаж хур тунадасны хэмжээ говийн бүс нутгаар 50 мм, хойд уулархаг бүсдээ 400 мм хүрч харилцан адилгүй байдаг.
- **1940 ОНООС ХОЙШ МОНГОЛ ОРНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ЖИЛИЙН ДУНДАЖ АГААРЫН ТЕМПЕРАТУР 2.25°C-ААР ДУЛААРЧЭЭ.** Энэ нь дэлхийн агаарын дундаж температур 1906 оноос 0.74°C-аар нэмэгдсэн үзүүлэлттэй харьцуулахад манай оронд дулаарал илүү эрчимтэйгээр явагдаж байгааг харуулна. **ДУЛААРЛЫН УЛМААС ӨНДӨР УУЛЫН МӨС ХАЙЛЖ, МӨНХ ЦЭВДЭГ ЭЛЭГДЭЛД ОРЖ БАЙНА. ХАРХИРАА, ТҮРГЭН, МӨНХХАЙРХАН, ЦАМБАГАРАВ, САЙР УУЛСЫН МӨСӨН БҮРХҮҮЛИЙН ТАЛБАЙ 1992 ОНООС 2002 ОНЫ ХООРОНД 30 ОРЧИМ ХУВИАР БАГАССАН БАЙНА.**
- **1961 ОНООС ХОЙШ ГАЗРЫН ГАДАРГЫН УУРШИЛ 118.1 ММ-ЭЭР ИХЭССЭН,** ургамлын ургалтын хугацаанд ордог хур борооны хэмжээ

⁵ ЗГ, Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, 2011

⁶ БОАЖЯ, Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол Улсын оруулах хувь нэмэр, 2015, УБ, х.14 http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/10/INDC_Full-Documents_MON_2016.pdf

33.0 мм-ээр буурсан нь хуурайшилт, цөлжилтийн гол шалтгаан болж байна. Хавар цас ханзрах хугацаа бараг нэг сараар урагшилж, хөрс цасан бүрхүүлгүй болон ургамлын бүрхэвчгүй байх хугацаа уртассан нь салхинд газрын хөрс элэгдэх нөхцөлийг нэмэгдүүлж, **1960-ААД ОНООС ХОЙШ ШОРООН ШУУРГАТАЙ ӨДРИЙН ТОО НИЙТ НУТГИЙН ХЭМЖЭЭНД 3-4 ДАХИН ИХЭССЭН БАЙНА.**


- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр хуурайшилт эрчимтэй явагдаж, үүнээс шалтгаалан олон гол, горхи, булаг шанд, нуур, цөөрөм хатаж ширгэн, бэлчээрийн ургамлын ургац буурч, зүйлийн бүрдэл нь хомсдож, бэлчээр доройтож, хэт халуун өдрийн тоо нэмэгдсэнээс мал сүрэг зун, намар тарга хүчээ бүрэн авч чадахгүй давжаарч зудын гамшгийг тэсвэрлэх чадвар нь буурч байна.
- Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас гамшиг, аюулт үзэгдлийн давтамж, эрчим нэмэгдэж, хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээ өссөөр байна.
- Монгол оронд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ус, цаг уурын гаралтай **ГАМШИГ АЮУЛТ ҮЗЭГДЛИЙН ТОО 2015 ОНТОЙ ХАРЬЦУУЛАХАД 2021 ОНД 2.9 ДАХИН НЭМЭГДЭЖ**, байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн улмаас амь насаа алдсан хүний 40.8 хувь нь үер, усны аюулаас, хорогдсон малын 87 хувь нь уур амьсгалын гаралтай зудаас, нийт хохирлын 87.4 хувь нь цаг агаарын аюулт үзэгдлээс учирсан байна.

Цаг агаарын гаралтай аюулт үзэгдлийн давтамж нэмэгдэж байгаагийн нэг тод жишээ нь сүүлийн үед Монгол оронд тохиолдох шороон шуурганы давтамж тохиолдол, эрчим нэмэгдэж, улмаар түүнээс хохирлын хэмжээ өсөж, ялангуяа иргэд, малчид амь насаа алдаж байгаа явдал юм.

Монгол орны нутаг дэвсгэрийн 30-аас дээш хувийг хамарсан хүчтэй салхи шуурганы аюултай болон гамшигт үзэгдэл сүүлийн 20 жилийн байдлаар жил дунджаар 16 удаа тохиолдож, давтамж нь цаашид өсөх хандлагатай байна (Зураг 1.7).



ЗУРАГ 1.7. МОНГОЛ ОРОНД ТОХИОЛДСОН ХҮЧТЭЙ САЛХИ ШУУРГАНЫ ДАВТАМЖ /эх сурвалж: М.Должинсүрэн, 2020



ШИГТГЭЭ 3

ХҮЧТЭЙ САЛХИ, ШУУРГАНЫ ГАМШИГТ ҮЗЭГДЭЛ

НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол орны хэмжээнд 2021 оны 3 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд хүчтэй цасан болон шороон шуурга тохиолдсон. 3 дугаар сарын 13-ны өдөр Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн нутгаар салхины хурд 16-24 м/с, зарим үед 34 м/с, Завхан аймгийн нутгаар 13-наас 14-нд шилжих шөнө 0.2-5.0 мм цас орж, салхины хурд 15-24 м/с, зарим үед 28 м/с хүрч, хүчтэй цасан шуурга 7 цаг орчим үргэлжилсэн. Говь-Алтай аймгийн хойд хэсгээр 0.0-1.0 мм цас орж, салхины хурд 16-20 м/с хүрч, цасан шуурга 2-3 цаг үргэлжилсэн. 3 дугаар сарын 14-ний өдөр төв, зүүн, говийн аймгуудын нутгаар салхины хурд 20-24 м/с, зарим үед 28-32 м/с, Дундговь аймгийн Сайнцагаан, Эрдэнэдалай сумын нутгаар түр зуур 40 м/с хүртэл ширүүсэж шороон шуурга шуурч мөн Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Төв, Дорнод аймгийн нутгаар цас орж цасан болон шороон шуурга шуурч **цаг агаарын гамшигт үзэгдэл** болсон.

УЧИРСАН ХОХИРОЛ

Цаг агаарын гамшигт үзэгдлийн улмаас 12 аймгийн 51 суманд нийт 706 хүн төөрч, сураггүй болсон ба үүнээс 696 хүнийг эсэн мэнд олсон бол 10 хүн амь насаа алдсан байдаг. Нийт 16 аймгийн 154 суманд 531 гэр, 2244 хашаа саравч нурж, 283 байшингийн дээвэр хууларч, 94075 толгой мал хорогдсон бол эрчим хүчний 220В-ийн 128 шон унаж, 10 аймгийн 34 суманд цахилгаан эрчим хүч түр тасалдсан байна.

Эх сурвалж: ОБЕГ, Нөхцөл байдлын мэдээ, 2021 оны 03 сар

Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож амьдрах, амьдралын хэв маягаа өөрчлөх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдсэн гамшгийн эрсдэлийг бууруулах нь нэн чухал асуудал юм. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, түүнээс үүдсэн гамшгийн эрсдэл, эмзэг байдлын өөрчлөлтийг Хүснэгт 1.8-д үзүүлэв.

ХҮСНЭГТ 1.8. МОНГОЛ ОРОН ДАХЬ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНЭЭС ҮҮДСЭН ГАМШГИЙН ЭРСДЭЛ, ЭМЗЭГ БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТ

ЭРСДЭЛД ХҮРГЭЖ БҮЙ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТЭЙ ХОЛБООТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	ӨНӨӨГИЙН БАЙДЛААР ГАРСАН ГОЛ ӨӨРЧЛӨЛТ	ХАМААРАХ ГАМШГИЙН ЭРСДЭЛ	ЦААШИД ГАРАХ НӨЛӨӨЛӨЛ, ЭМЗЭГ БАЙДАЛ
<ul style="list-style-type: none"> ▪ Дулааны улирлын температур нэмэгдэж, ууршилт ихсэж, хур тунадас буурсан, ▪ Халуун өдрийн тоо нэмэгдэж, үргэлжлэх хугацаа уртассан, ▪ Өвлийн улирлын хур тунадасны хэмжээ нэмэгдэх ▪ Гангийн давтагдал, эрчим нэмэгдсэн, хуурайшилтай үеийн үргэлжлэх хугацаа уртассан. 	<ul style="list-style-type: none"> ▪ Бэлчээрийн 90 гаруй хувь өөрчлөлтөд орж, доройтсон, ▪ Монгол улсын нутаг дэвсгэрийн 77.8 хувь нь ямар нэг хэмжээгээр цөлжиж доройтсон. ▪ Ган, зудын давтагдал нэмэгдэх хандлагатай ба хамгийн эрчимтэй нь 2002/2003, 2009/2010 онд тохиолдож, ДНБ-ий 6 ба түүнээс дээш хувиар бууруулсан ▪ Ган, зудаас хамаарах том малын зүй бус хорогдол оны эхний малын тоотой харьцуулахад 2 хувь ба энэ утга 1991-2011 оны хооронд жилд 0.25 хувиар нэмэгдэнэ. 	<p>Ган, зуд, цөлжилт</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Бэлчээрийн ургамлын ургац байгалийн бүх бүсэд одоогийнхоос 10-40 хувиар буурах, муудах, ▪ Өвлийн улирлын цасны хэмжээ 40-50 хувь нэмэгдэх ▪ Ган, зудаас хамаарах малын зүй бус хорогдол 2050-аад оны үед 9.4 хувь болж нэмэгдэх
<ul style="list-style-type: none"> ▪ Дулааны улирлын хур борооны хэмжээ буурч, ууршилт ихэссэн, ▪ Хуурайшилтай үе, гангийн эрчим нэмэгдэж, үргэлжлэх хугацаа уртассан, ▪ Хөрсний гүний температур нэмэгдсэн, ▪ Өндөр уулын бүсийн уур амьсгал дулаарч байна. 	<ul style="list-style-type: none"> ▪ Ойгоор бүрхэгдсэн талбай 1999-2012 онд 4.1 хувиар хорогдсон, ▪ Ойн түймрийн давтагдал ихсэж, 1999-2012 онд шатсан талбай 13.3 хувиар нэмэгдсэн, ▪ Ойн хортон, хөнөөлт шавжийн тархалт нэмэгдэж байна. 	<p>Ой, хээрийн түймэр, Хортон шавж тархах</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Ойн хөнөөлт, шавжид өртөх талбай 2050 оны түвшинд 1.4-13 дахин нэмэгдэх магадлалтай, ▪ Ойн түймэрт өртөх талбай 2030 оны үед 512 мян. га-аар нэмэгдэх
<ul style="list-style-type: none"> ▪ Конвекцийн гаралтай үзэгдлийн эрч хүч нэмэгдсэн, ▪ Орчил урсгалын аномал нөхцөлийн тохиолдол олширсон. ▪ Хур борооны эрчим нэмэгдсэн. 	<ul style="list-style-type: none"> ▪ Гамшигт үзэгдлийн давтагдлыг сүүлийн хорин жилийн явцыг арав арван жилээр хувааж харьцуулахад эхний арван жилд 75 орчим гамшигт үзэгдэл ажиглагддаг байсан бол дараагийн 10 жилд энэ тоо даруй 2 дахин нэмэгдсэн, ▪ Богино хугацаанд үргэлжлэх аадар бороо, 	<p>Салхи шуурга, Үер, Аадар бороо, аянга</p>	<ul style="list-style-type: none"> ▪ Агаар мандлын гаралтай аюулт үзэгдлийн давтагдал энэ зууны дунд үе гэхэд одоогийнхоос 23-60 хувиар нэмэгдэх, ▪ Аюулт үзэгдлийн эрчим, давтамж ихэссэнээр дэд бүтэц, барилга байгууламж эвдэгдэх

	уруйн үер, нөөлөг салхи, мөндөр, аянга цахилгаан зэрэг үзэгдлийн давтагдал эрчимтэй нэмэгдэж нийгэм эдийн засагт учруулах хохирол 2 дахин нэмэгдсэн.		
<ul style="list-style-type: none"> Дулааны улирлын температур нэмэгдэж ууршилт ихсэж, хур тунадас буурсан, Хэт халуун, дулааны долгионы үргэлжлэх хугацаа уртассан. 	<ul style="list-style-type: none"> Сүүлийн жилүүдэд малын шинэ өвчин 26, дахин сэргэж байгаа 8, хүрээгээ тэлж байгаа 6 өвчин тогтоогдсон. 	Хүн, малын халдварт өвчин	<ul style="list-style-type: none"> Дамжуулагчийн орчны өөрчлөлтөөр дамжих халдварт өвчний тоо олшрох.

Эх сурвалж: Гамшгаас хамгаалах бодлого, стратеги 2020

Уур амьсгалын өөрчлөлт нь манай орны нутаг дэвсгэрт тохиолддог байгалийн аюулт үзэгдлийн 80 гаруй хувьд буюу геологийн гаралтай аюулт үзэгдлээс бусад төрлүүдэд нөлөөлж, байгаль, нийгмийн тогтолцоонд олон сөрөг үр дагаврууд бий болж эхэлсэн. Иймээс уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг хөгжлийн бодлого, төлөвлөлт, стратегийн баримт бичигтэй зайлшгүй уялдуулж авч үзэх шаардлагатай.



САЙН ТУРШЛАГА 1:



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨНД СУУРИЛЖ ЗУДЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ НЬ

Мал аж ахуйд үзүүлэх нөлөөллийг зудын эрсдэлийн зургаар, газар тариалан болон ХАА-н зориулалттай усан хангамжид үзүүлэх нөлөөллийг хуурайшлын индексээр 2030, 2050 он хүртэл тодорхойлж, уур амьсгалын эрсдэлийн индексийг Монгол Улсын хэмжээнд сум бүрээр гаргаж, хөдөө аж ахуйн салбарт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох ажиллагааг уур амьсгалын гаралтай гамшгийн эрсдэлийг бууруулахтай уялдуулан хэрэгжүүлэх, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох ажил хийгдсэн. Үүнд:

- Энэхүү гарын авлагын Зураг 1.5, Хүснэгт 1.6-д 2030, 2050 он гэхэд зудын эрсдэлийн төлөв байдал, өөрчлөлтийн хувийг үзүүлсэн. Уур амьсгалын эрсдэлийн индексээр 30 орчим жилийн дараа гэхэд зудын эрсдэл “Нэн их” зэрэгт хүрэх нутаг дэвсгэрийн хэмжээ 2020-2022 оны дундажтай харьцуулахад харьцангуй их буюу 0.5 хувь байсан нь 17.9 хувь болж өөрчлөлтийн зөрүү 17.4 хувьд хүрэх буюу даруй 35 дахин нэмэгдэх тооцоо гарсан.
- Уур амьсгалын хуурайшлын индексийн тархцын хувьд 2020 оны нөхцөл байдалтай харьцуулахад 2030 оны үед манай орны нутаг дэвсгэрийн 0.6 хувь нэн хуурай буюу өөрчлөлтгүй, 43.4 хувь нь хуурай бүс буюу өмнөхөөс 3.7 хувиар, 45.5 хувь хуурайвтар бүс буюу 5.9 хувиар тус тус тэлж хуурайших, харин чийглэгдүү бүс - 6.3 хувь, чийглэг бүс 3.2 хувиар тус тус багасаж хуурайших төлөвтэй байна. 2050 онд хуурайшлын индексийн өөрчлөлтөөр манай орны нутаг дэвсгэрийн 0.6 хувь нэн хуурай буюу өөрчлөлтгүй, 45.7 хувь нь хуурай бүс буюу одоогийнхоос 6.0 хувиар тус тэлж хуурайших, 39.6 хувь хуурайвтар бүс буюу өнөөгийн хэмжээнд байх, харин чийглэгдүү бүс -6.5 хувиар багасах, чийглэг бүс 0.6 хувиар нэмэгдэх төлөвтэй байна.

УУР АМЬСГАЛЫН БҮС	ХУР ТУНАДАС БА УУРШЛЫН ХАРЬЦАА	НИЙТ НУТАГ ДЭВСГЭРТ ЭЗЛЭХ ХУВЬ			ӨӨРЧЛӨЛТИЙН ХУВЬ	
		2020	2030 ОН	2050 ОН	2030 ОН	2050 ОН
Нэн хуурай	<0.5	0.6	0.56	0.56	-	-
Хуурай	0.05-0.20	39.7	43.38	45.71	3.7	0.6
Хуурайвтар	0.20-0.50	39.6	45.48	39.57	5.9	-
Чийглэгдүү	0.50-0.65	11.6	5.29	5.10	-6.3	-6.5
Чийглэг	>0.65	8.5	5.30	9.05	-3.2	0.6

- Зудын эрсдэлийн болон хуурайшлын индексийг дараах байдлаар ашиглах боломжтой. Үүнд: Эрсдэлийн зэргээс хамааруулан МАА, газар тариалан, хөдөө аж ахуйн усан хангамжид учрах эрсдэлийг бууруулах чиглэлээр зарцуулах хөрөнгийг зохистой хуваарилах. Сүүлийн 3 жилийн дунджаар зарцуулж байсан хөрөнгийн хэмжээг дараах байдлаар өөрчилж тооцох:

- Нэн их эрсдэлтэй бол хамгийн багадаа 20% өсгөх
- Их эрсдэлтэй бол хамгийн багадаа 10% өсгөх
- Дунд зэрэг эрсдэлтэй бол үл өөрчлөх
- Бага эрсдэлтэй бол 10% бууруулж тооцох
- Хамгийн бага эрсдэлтэй бол 20% бууруулж тооцох.

**Эх сурвалж: НҮБХХ, УНТС-ийн санхүүжилтэй "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь" 1-дүгэсний тайлан 2023*

1.5. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГ ХАНДЛАГА

Гамшигт хил хязгаар гэж үгүй юм. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас дэлхий дахинд тохиолдох аюулаас учрах хохирол жил бүр өсөн нэмэгдэж, гамшгийн хор уршиг тухайн улс оронд нөлөөлөөд зогсохгүй хил залгаа нутаг дэвсгэр, бүс нутаг, дэлхийн хэмжээнд хор уршиг дагуулсаар байна.

Дэлхий нийт гамшгаас хамгаалах чиглэлээр нэгдсэн стратегитай болоод 30 гаруй жил болж байгаа бөгөөд энэ хугацаанд 3 бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлсэн байна.

ЙОКОХАМАГИЙН СТРАТЕГИ (1994-2005)

НҮБ-аас хүн амын аюулгүй тайван байдлыг хангах, гамшгийн улмаас учирч буй хохирлыг бууруулах зорилгоор анх удаа **1989-1999 оныг "Байгалийн гамшгийн аюулыг бууруулах арван жил"** гэж зарласан. Энэ хүрээнд Байгалийн гамшгийн бууруулах дэлхийн бага хурлыг 1994 онд Япон Улсын Йокохама хотноо хийж **"Аюул багатай дэлхийн төлөө Йокохама стратеги: байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдал, гамшгийн аюулыг бууруулах заавар зөвлөмж, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"**-г батлан 2005 он хүртэл амжилттай хэрэгжүүлсэн.


Дэлхийн улс орнууд бидний амьдарч буй цаг үе, бүтээн бий болгосон нийгэм нь аливаа аюул, эрсдэлээс ангид орших боломжгүй тул бид эрсдэл дунд амьдрах шинэ арга замыг олох, байгалийн аюулын нөлөөллийг бууруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай, ингэж байж сая бидний хүсэж буй тогтвортой хөгжил хангагдана гэдгийг хүлээн зөвшөөрсөн нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны ач холбогдлыг улам бүр нэмэгдүүлж өгсөн юм.

Йокохамагийн стратегийг хэрэгжүүлэх явцдаа дэлхийн улс орнууд байгалийн гамшгийг зогсоож чадахгүй, харин түүний учруулах хор уршигийг багасгах, түүнд өөрсдийгөө бэлтгэх шаардлагатай гэдэг дүгнэлтэд хүрсэн. Улс орнуудын

анхаарлыг байгалийн гамшгийг бууруулахад хандуулсан Йокохамагийн стратеги нь байгалийн аюулын нөлөөллийг бууруулах болон урьдчилан сэргийлэхэд чиглэсэн гамшгаас хамгаалах стратегийг тодорхойлсон анхны баримт бичиг байв.

ХЁОГОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ (2005-2015)

НҮБ-ын Гамшгийн аюулыг бууруулах хоёрдугаар бага хурал 2005 онд Япон Улсын Хёого мужид зохион байгуулагдаж, өмнөх арван жилд хэрэгжүүлсэн Йокохамагийн стратегийг дүгнэн хэлэлцээд дараагийн арван жилд хэрэгжүүлэх **“2005-2015 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХЁОГОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ: УЛС ҮНДЭСТЭН, ОРОН НУТГИЙН ГАМШИГТАЙ ТЭМЦЭХ ЧАДАВХЫГ БИЙ БОЛГОХ НЬ”** баримт бичгийг батлан гаргасан.



Тус баримт бичгийг хэрэгжүүлснээр **“УЛС ОРОН, ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНД ГАМШГИЙН УЛМААС ХҮНИЙ АМЬ НАС, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИНД УЧРАХ ХОХИРЛЫГ ЭРС БУУРУУЛАХ”** гэсэн үр дүнд хүрнэ гэж тодорхойлоод дараах таван тэргүүлэх чиглэлийн хүрээнд гамшгийг аюулыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд:

Үндэсний болон орон нутгийн түвшинд хүчирхэгжиж, бэхэжсэн байгууллагад үндэслэн нэн тэргүүнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа бол гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаа юм.

1	АЮУЛГҮЙ АМЬДРАХ ОРЧИН, ГАМШИГТАЙ ТЭМЦЭХ ЧАДАВХЫГ БИЙ БОЛГОХОД БҮХ ШАТАНД ЭРДЭМ МЭДЛЭГ, АВЬЯАС ЧАДВАРАА АШИГЛАН БҮТЭЭЛЧ САНААЧИЛГАТАЙ АЖИЛЛАХ;
2	ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ, ҮНЭЛЭХ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ЭРТ ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ СИСТЕМИЙГ САЙЖРУУЛАХ;
3	АЮУЛГҮЙ АМЬДРАХ ОРЧИН, ГАМШИГТАЙ ТЭМЦЭХ ЧАДАВХЫГ БИЙ БОЛГОХОД БҮХ ШАТАНД ЭРДЭМ МЭДЛЭГ, АВЬЯАС ЧАДВАРАА АШИГЛАН БҮТЭЭЛЧ САНААЧИЛГАТАЙ АЖИЛЛАХ;
4	ЭРСДЭЛИЙГ БИЙ БОЛГОЖ БАЙГАА ДАЛД ХҮЧИН ЗҮЙЛИЙГ БАГАСГАХ;
5	ХОР УРШГИЙГ АРИЛГАХ АЖИЛЛАГААГ ҮР ДҮНТЭЙ АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙН ТУЛД ГАМШГИЙН БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ.

Энэхүү “Хөёгогийн үйл ажиллагааны хүрээ: **“УЛС ҮНДЭСТЭН, ОРОН НУТГИЙН ГАМШИГТАЙ ТЭМЦЭХ ЧАДАВХЫГ БИЙ БОЛГОХ НЬ”** баримт бичгийн хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг анх дэвшүүлэн тавьсан бөгөөд энэхүү баримт бичгийн хэрэгжилт Мянганы хөгжлийн зорилтыг биелүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан юм. Ялангуяа гамшгийн улмаас ядуурлын түвшнийг гүнзгийрүүлэхгүй байхыг чухалчилж үзсэн байдаг. Тус баримт бичиг хэрэгжих хугацаанд ч гамшиг тогтвортой хөгжлийг бий болгох хүчин чармайлтад саад учруулсаар байлаа. Үүний шалтгааныг нь авч үзээд, гамшгийн эрсдэлийг бий болгож буй далд хүчин зүйлс болох уур амьсгалын өөрчлөлт, ядуурал зэргийг шийдвэрлэхгүйгээр тогтвортой хөгжил хангагдах боломжгүй юм гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ (2015-2030)



НҮБ-аас Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн гуравдугаар бага хурал Японы Мияги мужийн Сендай хотноо 2015 оны 3 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд зохион байгуулж, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2005-2015 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ололт амжилт, туршлага, хүндрэл бэрхшээлийг дүгнэсэн.

Гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх, учрах хохирлыг багасгах талаар 2005-2015 онд тодорхой ахиц дэвшил гарсан хэдий ч бүхий л улс орны хүн ам, эд хөрөнгийн гамшигт өртөх байдал нь эмзэг байдлаа бууруулахаас илүү хурдтай нэмэгдэж, гамшгийн шинэ эрсдэлийг бий болгохоос гадна, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, соёл, хүрээлэн буй орчинд богино, дунд, урт хугацаанд ноцтой нөлөөлөн ялангуяа орон нутаг, олон нийтийн түвшинд гамшгийн хохирол улам бүр нэмэгдэж байгааг тоо баримт харуулж байна.

Цар хүрээ, эрчимжил багатай гамшиг олон давтан тохиолдож, иргэд, олон нийт, өрх гэр, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд илүүтэй нөлөөлж, нийт хохирлын ихэнх хувийг бүрдүүлж байна. Бүх улс орнууд, нэн ялангуяа гамшгийн улмаас амь насаа алдагсдын тоо, эдийн засгийн хохирлын хэмжээ нь харьцангуй өндөр байдаг хөгжиж буй орнууд санхүүгийн болон хүлээсэн бусад үүргээ биелүүлэхэд ихээхэн хүндрэл, санхүүгийн бэрхшээл, зардал учирч байгааг онцолсон байна.

Иймд гамшгийн эрсдэлийг бодитой бууруулахын тулд ард иргэдийн амь нас, эрүүл мэнд, амьжиргаанд илүүтэй анхаарч, ирэх 15 жилийн хугацаанд **“Гамшгийн эрсдэл, түүний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, ард иргэд, бизнес, олон нийт, улс орны эдийн засаг, нийгэм, биет болон соёлын үнэт зүйл, хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээг бодитой бууруулах”** үр дүнд хүрэх зорилго тавьж **“ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2015-2030 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ”** баримт бичгийг батлан гаргасан. Тус баримт бичгийн бүтцийг дараах зурагт тоймлон харууллаа.

ЗУРАГ 1.8. СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ БАРИМТ БИЧГИЙН БҮТЭЦ

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНИЙ БҮТЭЦ	
ҮР ДҮН	ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНИЙ ДОЛООН ЗОРИЛТ
<p>Гамшгийн эрсдэл, түүний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, ард иргэд, бизнес, олон нийт, улс орны эдийн засаг, нийгэм, биет болон соёлын үнэт зүйл, хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээг бодитой бууруулах</p>	<ol style="list-style-type: none"> 1. Гамшгийн улмаас амь насаа алдагсдын тоог бодитой бууруулах. 2. Гамшигт нэрвэгдэгсдийн тоог бодитой бууруулах⁷. 3. Эдийн засгийн шууд хохирлын хэмжээг дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүнтэй холбоотойгоор бууруулах. 4. Гамшгийн улмаас нэн чухал дэд бүтэц, суурь үйлчилгээ түүний дотор боловсрол, эрүүл мэндийн байгууламжид учрах хохирлыг бодитой бууруулах.
ЗОРИЛГО	
<p>Аюулд өртөх байдал, гамшигт эмзэг байдлаас урьдчилан сэргийлэх, бууруулах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох бэлэн байдлыг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх эдийн засгийн, бүтцийн, хууль, эрх зүйн, нийгмийн, эрүүл мэндийн, соёлын, боловсролын, байгаль орчны, технологийн, улс төрийн болон институцийн нэгдмэл, харилцан уялдаатай арга хэмжээг хэрэгжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулах, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх</p>	
4 ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	5. 2020 он гэхэд үндэсний болон орон нутгийн түвшний гамшгийн эрсдэлийг бууруулах стратегитай улс орны тоог бодитой нэмэгдүүлэх.
<ol style="list-style-type: none"> <li style="color: #e91e63;">1. Гамшгийн эрсдэлийг ойлгох <li style="color: #e91e63;">2. Гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэх <li style="color: #e91e63;">3. Гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулах <li style="color: #e91e63;">4. Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх үе шатанд "Сайжруулан барих" үйл ажиллагааг хэрэгжүүлэх 	<ol style="list-style-type: none"> 6. Тогтвортой дэмжлэгийг үзүүлэх олон улсын хамтын ажиллагааг бодитой сайжруулах. 7. Аюулын төрөл бүрийг эрт зарлан мэдээлэх систем, гамшгийн эрсдэлийн мэдээлэл, үнэлгээг ард иргэд хүртэх, ашиглах боломжийг бодитой нэмэгдүүлэх

⁷Нэрвэгдсэн хүмүүсийн ангиллыг Дэлхийн бага хурлаар шийдсэний дагуу Сендайн дараах үйл ажиллагааны явцад боловсруулна.

Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичиг нь бүтцийн хувьд дэвшүүлсэн зорилгодоо хүрэх 7 зорилт, 4 тэргүүлэх чиглэлийг гаргаж, тэргүүлэх чиглэл тус бүр олон улс болон бүс нутаг, үндэсний болон орон нутгийн хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тус тусад нь тодорхойлсон.

Эдгээр арга хэмжээг олон улсын хамтын ажиллагааны хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд оролцогч бүх талууд хэрэгжүүлэхээр тусгасан юм. Эдгээр 7 зорилтыг хангахын тулд зорилт тус бүрийн хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлтийг 2017 онд боловсруулан гаргаж, улс орнууд уг шалгуур үзүүлэлтийг хангахаар гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Шалгуур үзүүлэлтийг гарын авлагын 4 дүгээр бүлгээс дэлгэрүүлэн харж болно. Агуулгын хувьд товчлон үзвэл:

- Гамшгийн үед “ГАМШГИЙН ХОХИРОЛ”-ыг арилгах ажиллагаанаас гадна гамшгийн өмнөх үед “гамшгийн эрсдэл”-ийг бууруулах үйл ажиллагаанд агуулгыг илүү чиглүүлсэн,
- Гамшгийн удирдлагаас “гамшгийн эрсдэлийн удирдлага”-д шилжсэн;
- “ЮУ ХИЙХ ВЭ?” гэдгээс “ХЭРХЭН ХИЙХ ВЭ?” аргачлалд шилжсэн;
- Улс орны Засгийн газрын гамшгийн эрсдэлийг бууруулах үндсэн үүрэг, хариуцлагыг тодорхойлсон;
- Гамшгийн эрсдэлийг бууруулахад холбогдох талуудтай үүрэг хариуцлагаа хуваалцах, талуудын үүрэг, оролцоог тодорхойлсон;
- Дэлхийн хэмжээний хэрэгжүүлэх зорилтыг онцгойлон үзсэн;
- Баримтлах зарчмыг шинэчилсэн;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний платформын үүргийг нэмэгдүүлж, гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг тодорхой тусгасан;
- Гамшгийн эрсдэлийн хүчин зүйлсийг ойлгох, бууруулах асуудлыг тодотгосон;
- Гамшгийн өмнөхөөс илүү “сайжруулан барьж байгуулах”, бэлэн байдлыг хангах асуудлыг дэвшүүлсэн;
- Гамшгаас хамгаалах ажиллагаанд хүний амь нас, эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны асуудлаас гадна хүний эрүүл мэнд, амьжиргаа, биет болон соёлын үнэт зүйлийг гамшгаас хамгаалах шаардлагатайг тодорхойлсон;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг хүн төвтэй хэлбэрээр зохион байгуулах;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тогтвортой хөгжлийн зорилгод хүрэх арга зам, хөгжлийн төлөвлөлтэй уялдуулах зэрэг олон шинэлэг агуулгыг тусгасан баримт бичиг юм.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны олон улсын чиг хандлагыг тодорхойлж ирсэн эдгээр 3 баримт бичгийн агуулгаас харахад дараах ерөнхий хандлага тодорхойлогдож байна. Үүнд:

- 1989-2005 онд “Байгалийн гамшгийг бууруулах”
- 2005-2015 онд “Гамшгаас учрах хохирлыг бууруулах”
- 2015-2030 онд “Гамшгийн эрсдэлийг бууруулах”



Эдгээр бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх явцад гамшиг бол аюулт үзэгдэл, осол ба нийгэм, эдийн засгийн асуудлын нийлбэрийн үр дүн гэдгийг дэлхийн олон оронд тохиолдсон томоохон гамшгийн сургамжууд батлан харуулж, гамшгаас учрах хор уршгийг арилгахаас илүүтэйгээр гамшгийн эрсдэлийг бууруулах замаар улс орны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн арга хэмжээ авахын ач холбогдлыг хүн төрөлхтөнд ойлгуулсан юм. Иймээс дэлхийн улс орнууд нэгдэн гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг багасгах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, дэлхийн тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр үүрэг, хариуцлага хүлээж, дэлхий нийтээр хэрэгжүүлэх бодлогын баримт бичгүүдийг батлан, харилцан уялдаатай хэрэгжүүлэх болсон.



Дэлхийн улс орнууд 2015 онд **“ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ”** баримт бичгээс гадна гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагааг уялдуулан хэрэгжүүлэх **“УУР АМЬСГАЛЫН ЭСРЭГ ПАРИСЫН ХЭЛЭЛЦЭЭР”**, **“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР 2030”** баримт бичгийг мөн батлан гаргаж хэрэгжүүлж байна.




Дэлхий нийтийн хэмжээнд тэргүүлэх зэргийн, тулгамдсан асуудлын нэг болсон уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах замаар дэлхийн дулаарлыг Цельсийн 2 хэмд хязгаарлах зорилт бүхий НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын Парисын хэлэлцээрийг дэлхий нийт 2015 онд батлан гаргасан.

Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого хоёр үндсэн үзэл баримтлалтай. *Нэгд, уур амьсгалын өөрчлөлтөөс гарч байгаа ноцтой үр дагаврыг бууруулахын тулд энэ өөрчлөлтөд хүргээд байгаа хүний хүчин зүйл болох **хүлэмжийн хийн ялгаралтаа эрс бууруулах, шингээлтийг нь сайжруулах**; хоёрт, нэгэнтээ явагдаад эхэлчихсэн уур амьсгалын өөрчлөлтийн улмаас бий болсон шинэ нөхцөлд нийцэн амьдрах буюу уур амьсгалын өөрчлөлтийг хамгийн хохирол багатайгаар даван туулах замаар **дасан зохицох** юм.*

Уур амьсгалын эсрэг Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд гамшгийн эрсдэлийг нэмэгдүүлж буй нэгэн хүчин зүйл нь уур амьсгалын өөрчлөлт юм гэсэн ойлголтыг бататгаж, уур амьсгалын өөрчлөлтийг эсрэг авах арга хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах ажиллагаа орхигдуулахгүй байх шаардлагатай гэдгийг онцолсон.

ЗУРАГ 1.10. ГАМШГИЙН ЭРСДЭЛ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ХӨГЖИЛ ХООРОНДЫН ХАМААРАЛ



Гамшгийн эрсдэл, уур амьсгалын өөрчлөлт, хөгжил хоорондын хамаарлыг харуулсан зураг (Зураг 1.10)-т ус, цаг агаар, уур амьсгалын аюул үзэгдлүүд нь гамшгийн өртөх байдал, эмзэг байдал улмаар гамшгийн эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна, гамшиг нь улс орны хөгжлийг сааруулах үндсэн хүчин зүйл бөгөөд үүнийг гамшгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, хүлэмжийг хийг багасгах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагаагаар дамжуулан бууруулна гэж ойлгогдож байна.



Дэлхий ертөнц 2030 он гэхэд ямар нөхцөл байдалд хүрэхийг тодорхойлж өгсөн **“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР-2030”** баримт бичиг нь тогтвортой хөгжлийн **3 тулгуур болох эдийн засаг, нийгэм, байгаль орчныг тэнцвэртэйгээр хөгжүүлэх** үндсэн зорилгыг тодорхойлсон өнөө цагийн хамгийн чухал баримт бичиг юм. Гамшгийн эрсдэлүүд эдийн засаг, нийгмийн хөгжилд сөргөөр нөлөөлж байгаа өнөөгийн нөхцөлд тогтвортой хөгжилд хүрэх боломжгүй.

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас давтамж болон эрчим нь нэмэгдэж буй байгалийн гамшгийн сөрөг нөлөө нь аль ч улс орон аль ч салбарт хамааралтай. Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030-г хэрэгжүүлэх үндсэн нөхцөл нь гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал мөн гэж үзэж, Тогтвортой хөгжлийн хөтөлбөр 2030” баримт бичиг нийт 17 зорилгыг тодорхойлсон бөгөөд эдгээр зорилгын 11 нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаатай шууд хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт дэвшүүлсэн дэлхийн хэмжээний 7 зорилтын хэрэгжилтийг хангаснаар Тогтвортой хөгжлийн 1, 2, 3, 4, 6, 9, 11, 13, 14, 15, 17 дугаар зорилтод хүрэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

ЗУРАГ 1.11. СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНИЙ 7 ЗОРИЛТ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО ХООРОНДЫН ХАМААРАЛ ЭХ СУРВАЛЖ: НҮБ-ЫН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ГАЗАР



Гамшгийн эрсдэлийг бууруулахгүйгээр хөгжлийн тогтвортой байдлыг хадгалж чадахгүй юм. Гамшиг нь хөгжлийн явцыг сааруулах, ухраах нөхцөл гэдэг утгаараа гамшиг ба хөгжил нь хоорондоо урвуу хамааралтай харагдаж байгаа боловч хөгжлийн үйл явцыг сайн засаглалын хүрээнд удирдах нь гамшгийн эрсдэлийг бууруулах эерэг нөлөөтэй байдаг.

Үүнтэй холбоотойгоор тогтвортой хөгжлийг хангана гэдэг нь тухайн нийгэм гамшигийг даван туулах чадавхтай байх явдал бөгөөд энэхүү чадавхыг бий болгоход гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг хамтатган авч үзэх нь нэн чухал гэдэгтэй дэлхий нийт санал нэгдэж байна. Гамшигийг даван туулах чадавхыг нь аливаа нийгэм гамшигт өртсөн тохиолдолд маш богино хугацаанд, үр дүнтэйгээр сэргэн хөгжих чадвар илэрхийлнэ.



БҮЛЭГ 2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗАСАГЛАЛ

Гамшгийн эрсдэлийг бууруулах нь тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн цогц үйл ажиллагаа тул засгийн газар, түүний харьцангуй хязгаарлагдмал нөөцийн хүрээнд ажилладаг онцгой байдлын байгууллага дангаараа энэ бүхнийг хийх боломжгүй юм. Иймд засгийн газарт гамшгаас хамгаалах, иргэдийн аюулгүй байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, олон нийтийг оролцуулах шаардлага үүсдэг.

Ийм өргөн цар хүрээтэй, олон оролцогч талууд бүхий, тэдгээрийн оролцоо, хоорондын зохицуулалтыг хамгийн үр дүнтэй байхыг шаарддаг нарийн төвөгтэй асуудлыг шийдэх арга зам нь засаглалыг бэхжүүлэх гэж үздэг. Гамшгийн эрсдэлийг бууруулах засаглалд онцгой байдлын байгууллагын гүйцэтгэх үүрэг нь оролцогч талуудын нөөц, бололцоо, үйл ажиллагааг гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглүүлж тэдгээрийн харилцан ажиллагааг хангахад оршино.

2.1. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсад гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны эрх зүйн үндсийг Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэсэн иргэний аюулгүй амьдрах, аж төрөх үндсэн эрхийг тунхагласан заалтад нийцүүлэн баталсан Гамшгаас хамгаалах тухай хууль (2017), Галын аюулгүй байдлын тухай хууль (2015), Улсын нөөцийн тухай хууль (2007) болон бусад хууль тогтоомжууд бүрдүүлнэ.

2.1.1. ГАМШГААС ХАМГААЛАХ ХУУЛЬ ТОГТООМЖ

НЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурлаар 2017 онд баталсан.

ХУУЛИЙН ЗОРИЛГО

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд онцгой байдлын байгууллага, гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэний оролцоог уялдуулан зохицуулах, зохион байгуулах, гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх харилцаанд үйлчилнэ.

ХУУЛИЙН БҮТЭЦ

Энэхүү хууль нь нийтлэг үндэслэл, гамшгийн өмнөх үйл ажиллагаа, гамшгийн үеийн үйл ажиллагаа, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлага, гамшгаас хамгаалах удирдлагын бүрэн эрх, хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг, гамшгаас хамгаалах хүмүүнлэгийн тусламж, Онцгой байдлын байгууллага, түүний алба хаагчийн эрх зүйн байдал, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт, бусад зүйл гэсэн 11 бүлэг, 52 зүйлтэй.⁸

Шинэчлэн найруулсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн үзэл баримтлалыг тогтвортой хөгжлийг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр дэлхий нийтийн баримтлах бодлогын баримт бичигтэй уялдуулж боловсруулсан бөгөөд ингэснээр манай улс гамшгаас хамгаалах удирдлагаас гамшгийн эрсдэлийн удирдлагад шилжсэн юм. Энэ хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг тодорхойлон томъёолсон зарчмын шинжтэй дараах зохицуулалтыг хуульд тодорхойлж өгсөн.

Үүнд:



- Гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул, гамшгийн эрсдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа зэрэг хуулийн нэр томъёоны тайлбарыг олон улсын нэр томъёоны тайлбартай нийцүүлж, өөрийн орны онцлогт тохируулан шинээр томъёолсон.
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь *гамшгийн өмнөх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, гамшгийн үеийн эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа* гэсэн үе шатуудаас бүрдэхээр нарийвчлан зааж, зааг ялгааг тодорхойлсон.
- Гамшгийн эрсдэлийг үнэлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ болон гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтийн зохицуулалтыг тодорхой болгож гамшгийн эрсдэлийн удирдлагын эрх зүйн орчин бүрдсэн.
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрх бүхий субъектүүдийн бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх, зохион байгуулах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, Онцгой байдлын байгууллага, гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэний эрх, үүргийн зохицуулалтыг шинэчлэн тусгасан.

⁸ Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга, УБ хот, 2017 он.

ХОЁР. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурлаар 2015 онд баталсан.

ХУУЛИЙН ЗОРИЛГО

Галын аюулгүй байдлыг хангах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ

Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, галын аюулгүй байдлыг хангах болон гал түймэр унтраах арга хэмжээний удирдлага, зохион байгуулалтыг тогтоож, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн галын аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг тодорхойлсон.

ХУУЛИЙН БҮТЭЦ

Галын аюулгүй байдлыг хангах байгууллагын чиг үүрэг, тогтолцоо, галын аюулгүй байдлыг хангах шаардлагыг тогтоож, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлсон 6 бүлэг, 25 зүйлтэй.



- Галын аюулгүй байдлын тухай хууль батлагдсанаар нийгэм, эдийн засагт гал түймрийн улмаас учрах эрсдэлийг бууруулахад чиглэсэн дараах эерэг үр дагаврууд бий болсон. Үүнд:
- Гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэн, гал түймрээс үүдэлтэй хүн ам, нийгэм, эдийн засагт учрах хохирол багасах нөхцөл бүрдсэн;
- Аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлж, үүнтэй холбоотойгоор гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа сайжирсан;
- Гал унтраах чиглэлээр төрөөс үзүүлж буй үйлчилгээ орон нутагт хүрэлцэхгүй байгааг харгалзан хувийн хэвшлийн болон сайн дурын гал унтраах үүрэг бүхий нэгж ажиллах боломжтой болсон;
- Олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх зорилгоор галын аюулгүй байдлыг хангуулахтай холбоотой үйл ажиллагааны чанар, үр дүнг хөндлөнгөөс үнэлэх, төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн эрх, үүргийг тусгаж өгснөөр гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо сайжирч байна.

ГУРАВ.УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ хуулийг Монгол Улсын Их Хурлаар 2007 онд баталсан.

ХУУЛИЙН ЗОРИЛГО

Улсын нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэж хүргэх, шинэчлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХУУЛИЙН БҮТЭЦ

Улсын нөөц, түүний зохицуулалт, улсын нөөцийн талаарх төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрхийг тодорхойлсон 4 бүлэг, 19 зүйлтэй.

Энэ хуулиар улсын нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд тус хууль нь улсын нөөцийн бэлэн байдлыг дээшлүүлэх, гамшгийн хор уршгийг шуурхай арилгах, эдийн засгийн тогтвортой байдал, үндэсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх чухал ач холбогдолтой. Хуульд дараах онцлог зохицуулалтууд тусгагдсан.

Үүнд:

- Улсын нөөц нь стратегийн, дайчилгааны, гамшгийн болон орон нутгийн нөөцөөс бүрдэнэ;
- Стратегийн нөөцөд хамаарах бараа, материалын нэр төрлийг тогтоох бүрэн эрхийг Улсын Их Хурал хэрэгжүүлэх;
- Стратегийн нөөцөд хамаарах бараа, материалын тоо хэмжээ, байршил тогтоох, шаардлагатай үед бараа, материалыг захиран зэрцуулах, нөхөн бүрдүүлэх шийдвэр гаргах бүрэн эрхийг Засгийн газар хэрэгжүүлэх;
- Үндэсний аюулгүй байдлыг хангах, нийгэм, эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдал, зах зээл дэх зарим барааны эрэлт нийлүүлэлтийн харьцааг тэнцвэржүүлэх зориулалтаар улсын нөөцийг ашиглаж болно.
- Эдгээр хуулиудтай нийцүүлэн гаргасан гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой нийтлэг харилцааг зохицуулсан нийт 40 гаруй захиргааны хэм хэмжээний акт батлан гаргаж мөрдөж байна. Дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралт 1-д үзүүлэв.

Гамшгийн эрсдэлийг бууруулах нь олон талын оролцоотой хэрэгжих өргөн хүрээний асуудал гэдэг утгаараа Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2 дахь заалтад нийцсэн олон салбарын хууль тогтоомжоор мөн зохицуулагддаг онцлогтой. Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчин, хууль зүй, дотоод хэрэг, хөдөлмөр нийгэм хамгаалал, боловсрол, уул уурхай, хүнд үйлдвэр, эрүүл мэнд, барилга хот байгуулалт, зам тээвэр, хөдөө аж ахуй, эрчим хүч болон батлан хамгаалах салбарын нийт 60 гаруй хуульд тусгагдсан байна. Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос үзнэ үү.

2.1.2. ГАМШГААС ХАМГААЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлаар төрөөс баримтлах бодлогын үндсийг

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010),
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2020),
- “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (2017),
- “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр (2015) зэрэг баримт бичгүүд бүрдүүлнэ.

НЭГ. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ


УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4 дэх “Хүний аюулгүй байдал” бүрэлдэхүүн хэсэгт “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах...нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж тодорхойлж, энэ хүрээнд:

- 3.4.1.11-д Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед шаардлагатай эмнэлгийн тусламжийг хүн амд шуурхай хүргэх чадавхыг байнга дээшлүүлнэ;
- 3.4.2.3-т ...Гамшгийн үед хэрэглэх стратегийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц, хот, суурин газрын хүн амын хүнсний эрэлт нийлүүлэлтийг тогтвортой байлгах улирлын нөөцийг бүрдүүлэх замаар хүнсний хангамжийн баталгааг хангана;
- 3.4.3.1-д Иргэдийн амьдрах, ажиллах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний аюулгүй байдлыг баталгаажуулах чухал үндэс болно гэж;
- 3.4.3.5-д Орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний барилга, инженерийн байгууламжийн газар хөдлөлтийн тэсвэрлэлтэд үнэлгээ өгч, 8 баллын газар хөдлөлтийг тэсвэрлэх шаардлага хангахгүй барилга, байгууламжийг хүчитгэх, буулгаж шинээр барих зохицуулалт хийнэ гэж тодорхойлсон.

Мөн үзэл баримтлалын 3.5 дахь “Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал” бүрэлдэхүүн хэсэгт “... байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах нь хүний эрүүл оршин амьдрах, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж тодорхойлж, энэ хүрээнд:

- 3.5.5.1-д Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авна;
- 3.5.5.2-т Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, чадавхыг бэхжүүлнэ;
- 3.5.5.3-д Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх арга, технологи нэвтрүүлэх, хяналт-шинжилгээний сүлжээний тасралтгүй ажиллагааг хангах техник хэрэгсэл, хүний нөөцийг системтэйгээр бэлтгэж, мэдээллийг хэрэглэгчид шуурхай хүргэх арга замыг боловсронгуй болгон эртнээс сэрэмжлүүлэх чадавхыг бүрдүүлнэ гэж тусгасан.

ЗУРАГ 2.1. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ ДАХЬ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМ, ТЭДГЭЭРИЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ (Ш.БОЛДБААТАР, 2020)



ХОЁР. “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО



УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “**АЛСЫН ХАРАА-2050**” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго бүр монгол хүний сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд чиглэх бөгөөд нийт 9 зорилго, нийт 50 зорилттой ба 2021-2030 он, 2031-2040 он, 2041-2050 он гэсэн 3 үе шаттай⁹гаар хэрэгжих юм.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал нь аргазүйн хувьд **БАЙГАЛЬ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ** гэсэн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын гурвалсан холбоост тулгуурлан, улс орны

тогтвортой хөгжлийг хангах арга замыг тогтоосон, үндэсний онцлогийг хадгалж **ҮНДЭСНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, САЙН ЗАСАГЛАЛ** гэсэн дотоод тулгуур 3 хүчин зүйлийг агуулсан хөгжлийн загвараар илэрхийлэгдэнэ.


Гамшгаас хамгаалах асуудал энэхүү урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын 9 зорилгын 5 зорилгод тусаж эдгээрийг хэрэгжүүлэх 6 зорилтод хамаарах 9 үйл ажиллагааны чиглэлээр тодорхойлогдсон.

Эдгээр үйл ажиллагааг Монгол Улсын хөгжлийн загварын “Гол тулгуур гурвалжин”-д байрлуулж харвал гамшгийн эрсдэлийг бууруулах асуудал нь Монгол Улсын хөгжлийн загварын “эдийн засаг”, “үндэсний аюулгүй байдал”, “ногоон хөгжил” гэсэн суурь зорилгуудад хамаарч байгаа бөгөөд гамшгийн эрсдэлийг бууруулахад “сайн засаглал” ихээхэн чухал гэдгийг харуулж байна.



⁹ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЗУРАГ 2.2. МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН ЗАГВАРЫН “ГОЛ ТУЛГУУР ГУРВАЛЖИН¹⁰”-Д “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО”-Д ТУССАН ГАМШГААС ХАМГААЛАХ АСУУДАЛ



¹⁰ Монгол улсын Засгийн газар, Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал, УБ, 2019, х. 27

ГУРАВ. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭГ МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ

Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (2017-2030)” нь 2017-2020, 2020-2025, 2025-2030 он хүртэл 3 үе шаттайгаар Засгийн газар, яам, агентлаг, нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллага, шинжлэх ухаан, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, иргэд, олон нийт, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, түншлэлд суурилж хэрэгжүүлнэ.

ХҮСНЭГТ 2.1. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭГ МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИЙН ТОВЧ АГУУЛГА

ЗОРИЛГО: Гамшгийн аюул, өртөх байдал, эмзэг байдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг сайжруулж, гамшигтай тэмцэх чадавхыг бэхжүүлэх, холбогдох талуудын нэгдмэл, харилцан уялдаатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх замаар Монгол Улсад гамшгийн эрсдэлийг бууруулах, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх				
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ	1. Гамшгийн эрсдэлийг ойлгох	2. Гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэх	3. Эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулах	4. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх үе шатанд Сайжруулан барьж байгуулах
ЗОРИЛТ 1	1.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх - 3 үйл ажиллагаа	2.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох - 2 үйл ажиллагаа	3.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд санхүүгийн хамгаалалт, шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх - 2 үйл ажиллагаа	4.1. Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг дээшлүүлж, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх - 2 үйл ажиллагаа
ЗОРИЛТ 2	1.2. Гамшгийн эрсдэлийг үнэлэх тогтолцоог бүрдүүлж, мэдээллийн санг боловсронгуй болгох - 2 үйл ажиллагаа	2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулахад түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх - 2 үйл ажиллагаа	3.2. Гамшгийн эрсдэлийг бууруулахад дэвшилтэт техник, технологи, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх - 2 үйл ажиллагаа	4.2. Сайжруулан барьж байгуулах - 2 үйл ажиллагаа
ЗОРИЛТ 3		2.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр үндэсний стандартыг хөгжүүлэх - 2 үйл ажиллагаа		

ДӨРӨВ. "ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТОЙ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг 2015-2025 онд хэрэгжүүлнэ.

ЗОРИЛГО: Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сургалт, сурталчилгаа, үйл ажиллагаанд иргэдийг оролцуулан, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, аюулгүй амьдрах ухамсарт соёл болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулах

ЗОРИЛТ	1. олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн орчин, тогтолцоог бүрдүүлэх;	2. гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн сургалт, сурталчилгааг бүх түвшинд шат дараалан зохион байгуулах;	3. олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх.	4. уур амьсгал, ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг шуурхай мэдээлэх тогтолцоог бэхжүүлэх;
	5. уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоо, идэвх, санаачилгыг дэмжих;		6. уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх	




2.2. МОНГОЛ УЛСЫН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТОГТОЛЦОО

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.1-д “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өмчийн хэлбэр үл харгалзан зохион байгуулна” гэж зааж гамшгийн эрсдэлийг бууруулах тогтолцооны оролцогч талуудыг Засгийн газраас иргэнийг хүртэл тогтоож өгсөн.

Гамшгийн эрсдэлийг бууруулах тогтолцооны оролцогч талууд нь:

- Ерөнхий сайдын удирдлагад ажиллах гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий үндэсний болон орон нутгийн **ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗӨВЛӨЛ**;
- Монгол Улсын Шадар сайд чиглүүлж, гамшгаас хамгаалах төрийн бодлого, гамшгаас хамгаалах талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй төв, орон нутгийн **ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГА**;
- Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажлыг шуурхай зохион байгуулах чиг үүрэг бүхий улсын болон орон нутгийн **ОНЦГОЙ КОМИСС**;
- Мэргэжлийн дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй төрийн захиргааны холбогдох яам, агентлагийг түшиглэсэн улсын болон орон нутгийн **ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА**;
- Бүх шатны ИТХ, Засаг дарга;
- Аж ахуйн нэгж, байгууллага;
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага
- Олон нийт, иргэд байна.

ЗУРАГ 2.3. МОНГОЛ УЛСЫН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО



2.3. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗӨВЛӨЛ

Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг хангах, бодлогын зөвлөмж гаргах үндсэн чиг үүрэгтэй. Энэ нь гамшгийн эрсдэлийг бууруулахад олон талын оролцоог хангах тодруулбал, төр засгийн байгууллага (холбогдох салбарын яамд болон онцгой байдлын байгууллага), төрийн бус байгууллага, шинжлэх ухааны байгууллага, мэргэжлийн холбоод, сайн дурын байгууллага, хувийн хэвшил болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг оролцуулж, тэдний чадавх боломжийг уялдуулан нэгтгэх замаар Монгол Улсын гамшгийг даван туулах үндэсний чадавхыг нэмэгдүүлэх, улс орны тогтвортой хөгжлийг хангах нөхцөл бүрдүүлэхэд үйл ажиллагаа чиглүүлж ажиллана.

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

22.2. Улсын хэмжээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд орон нутгийн зөвлөлийг байгуулна.

22.5. Үндэсний болон орон нутгийн зөвлөл нь хөгжлийн бодлого төлөвлөлтөд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг тусгах, бодлогын зөвлөмж, чиглэл гаргах чиг үүрэгтэй, орон тооны бус байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 189 дугаар тогтоолоор батлагдсан "Гамшгийн эрсдэлийг бууруулах Үндэсний зөвлөлийн ажиллах журам"–аар зохицуулагдана. Эдгээр эрх зүйн баримт бичигт Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл нь гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тодорхойлсон.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23.2-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлдэг бөгөөд бүрэлдэхүүнийг нь Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтад холбогдох яам, төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, судалгаа, боловсрол, соёл урлаг, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг оролцуулан дор дурдсанаар тогтоосон.

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН 27 ДУГААР ЗҮЙЛ

27.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл дараах бүрэн эрхтэй:

27.1.1. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийн зорилт болон шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгуулах талаар бодлогын зөвлөмж өгөх

27.1.2. Гамшгийн дараах сэргээн босгох арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх, улс орны тогтвортой хөгжлийн бодлого, зорилтод уялдуулах бодлогын зөвлөмж гаргах

27.1.3. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах

27.1.4. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, техник, технологийн шинэ ололт, инновацыг нэвтрүүлэх талаар чиглэл өгөх

27.1.5. Орон нутгийн зөвлөлийг бодлого, зөвлөмжөөр хангах

ХҮСНЭГТ 2.2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:	Монгол Улсын Ерөнхий сайд	
ОРЛОГЧ ДАРГА:	Монгол Улсын Шадар сайд	
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА	Онцгой байдлын ерөнхий газрын дарга (Гамшгийн эрсдэлийн удирдлагын газар)	
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:	Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газрын дарга	
ДЭД ЗӨВЛӨЛ:	Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөл	
ГИШҮҮД: (19 ГИШҮҮН)	<ul style="list-style-type: none"> ▪ Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга; ▪ Хууль зүй, дотоод хэргийн сайд; ▪ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд ▪ Батлан хамгаалахын сайд; ▪ Барилга, хот байгуулалтын сайд; ▪ Зам, тээврийн хөгжлийн сайд; ▪ Эрчим хүчний сайд; ▪ Эрүүл мэндийн сайд; ▪ Цахим хөгжил, харилцаа холбооны сайд; ▪ Эдийн засаг, хөгжлийн дэд сайд; ▪ Гадаад харилцааны дэд сайд; ▪ Сангийн дэд сайд; 	<ul style="list-style-type: none"> ▪ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд; ▪ Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд; ▪ Монгол Улсын Шадар сайдын ахлах зөвлөх; ▪ Онцгой байдлын ерөнхий газрын дарга ▪ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратегийн судалгааны хүрээлэнгийн захирал; ▪ Засгийн газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга; ▪ Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч; ▪ Монголын улаан загалмайн нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга;

Засгийн газрын 2020 оны 189 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажиллах журам”-д зөвлөлийн дарга, гишүүдийн эрх, үүргийг дараах байдлаар тодорхойлж өгсөн.

ХҮСНЭГТ 2.3. "ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН БҮРЭН ЭРХ	ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ
<p><i>5.1. Үндэсний зөвлөлийн дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:</i></p> <p>5.1.1. Үндэсний зөвлөлөөс гаргасан шийдвэрийн хэрэгжилт, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шаардагдах судалгаа, мэдээ, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах;</p> <p>5.1.2. гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлж шийдвэрлүүлэх;</p> <p>5.1.3. гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд шаардлагатай төсөв, хөрөнгө оруулалтын асуудлаар холбогдох байгууллага, аймаг, нийслэлийн удирдлагуудад зөвлөмж, чиглэл хүргүүлэх;</p> <p>5.1.4. хуралдааныг товлох, хуралдааны дэг, хэлэлцэх асуудлыг тогтоох; гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлаар гишүүдэд чиглэл өгөх;</p> <p>5.1.5. гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлаар өөрийн эрх мэдлийн хүрээнд захирамж гаргах.</p> <p>5.2.5. үндэсний зөвлөлөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвтөө тусгаж хэрэгжилтийг хангах.</p>	<p><i>5.2. Үндэсний зөвлөлийн гишүүн дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:</i></p> <p>5.2.1. шаардлагатай тохиолдолд үндэсний зөвлөлийн ээлжит бус хуралдааныг хуралдуулах санал гаргах;</p> <p>5.2.2. гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хариуцсан салбарт хэрэгжүүлэх арга хэмжээ, салбар хоорондын зохицуулалтыг хангах асуудлыг Үндэсний зөвлөлийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх;</p> <p>5.2.3. гамшгийн эрсдэлийг бууруулах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлсэн ажлаа Үндэсний зөвлөлийн хуралдаанд тайлагнах;</p> <p>5.2.4. гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой бодлогын зөвлөмж боловсруулах, бусад гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж салбар дундын зохицуулалтыг хангах;</p> <p>5.2.5. үндэсний зөвлөлөөс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвтөө тусгаж хэрэгжилтийг хангах.</p>

Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл нь Нийслэл хот, 9 дүүрэг, 21 аймагт байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд эдгээр орон нутгийн зөвлөлийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23.2-д заасны дагуу тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга тэргүүлнэ. Орон нутгийн зөвлөлийн орлогч дарга, нарийн бичгийн дарга нь Засаг дарга, засаг даргын орлогч, онцгой байдлын байгууллагын дарга байх ба нэг зөвлөл дунджаар 20 орчим гишүүнтэй байдаг.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд жилд нэг удаа, шаардлагатай тохиолдолд ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна. Хуралдааны шийдвэр нь гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг тусгасан зөвлөмж, чиглэл байна. Зөвлөл нь хуралдаанаас гаргасан зөвлөл, чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж болно.

Улсын онцгой комисс, гамшгаас хамгаалах улсын албад нь чиг үүргийн хүрээнд Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлтэй үйл ажиллагаагаа уялдуулж ажиллана.


ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

6. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл дараах бүрэн эрхтэй:

6.1. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27.2-т заасан бүрэн эрхээс гадна энэ журмыг өөрийн эрх мэдлийн хүрээнд хэрэгжүүлнэ;

6.2. Орон нутгийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах, холбогдох зардлыг шийдвэрлэж хэрэгжилтийг хангах;

6.3. Үндэсний зөвлөлийн шийдвэрийн биелэлт, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, түүний үр дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг Үндэсний зөвлөлд улирал тутам тайлагнана.



ШИГТГЭЭ 4:

ОЛОН УЛСЫН БОЛОН ҮНДЭСНИЙ ТҮВШНИЙ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗӨВЛӨЛ

Манай улс нь Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг соёрхон баталсан НҮБ-д бүртгэлтэй дэлхийн 187 улсаас гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлөө байгуулсан 94 дэх улс болсон ба одоогоор улсын хэмжээнд Үндэсний зөвлөл, Нийслэл, 9 дүүрэг, 21 аймгийн нийт 32 зөвлөл байгуулагдан ажиллаж байна.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ПЛАТФОРМ БУЮУ ЗӨВЛӨЛИЙН ТҮВШИН

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ПЛАТФОРМ БУЮУ ЧУУЛГАН		
Дэлхийн түвшин	 UNDRR UN Office for Disaster Risk Reduction	Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн чуулган/платформ
Бүс нутгийн түвшин	 UNDRR UN Office for Disaster Risk Reduction	Ази, Номхон далайн улс орнуудын сайд нарын бага хурал
Үндэсний түвшин		Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл
Орон нутгийн түвшин		Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл

Улс орнууд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр бүс нутаг, улс орон, байгууллага, салбаруудын хооронд харилцан уялдааг сайжруулах, гамшгийн эрсдэлийг бууруулахад гарсан тэргүүн туршлага, технологийн шинэчлэл, мэдлэг, мэдээллийг солилцох, учирч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох, даван туулах шийдлийг олох, цаашид эрсдэлийг бууруулах чиг хандлагыг хамтран тодорхойлох зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас 2005 оноос хойш хоёр жилд нэг удаа зохион байгуулж ирсэн Ази, Номхон далайн бүсийн платформ нь Ази, Номхон далайн улс орнуудын сайд нарын бага хурал юм. 2015 онд батлагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг хэрэгжүүлэх хугацаанд зохион байгуулагдсан дэлхийн болон Ази, Номхон далайн бүсийн платформыг үзүүлбэл:

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ДЭЛХИЙН ЧУУЛГАН	ДЭВШҮҮЛСЭН УРИА, СЭДЭВ
 <p>22-26 MAY, 2017 CANCUN, MEXICO 2017 GLOBAL PLATFORM FOR DISASTER RISK REDUCTION</p> <p>— FROM COMMITMENT TO ACTION —</p> <p>Мексикийн Холбооны Улсын Канкун хот 2017.05.22-26</p>	<p>Амлалтаас үйл ажиллагаанд</p>
 <p>global platform for disaster risk reduction Geneva, Switzerland, 13-17 May 2019</p> <p>Швейцарын Холбооны Улсын Женев хот 2019.05.15-17</p>	<p>Даван туулах чадавхыг хуваарилах: Тогтвортой, хүртээмжтэй нийгмийн төлөө</p>
 <p>INDONESIA 23-28 MAY 2022</p> <p>Индонез Улсын Бали арал 2023.05.22-28</p>	<p>Эрсдэлээс гамшгийг даван туулах, гамшигт тэсвэртэй байх чадавх руу: КОВИД-19 улмаас өөрчлөгдсөн дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн төлөө</p>
 <p>Asian Ministerial Conference on Disaster Risk Reduction 2016 New Delhi, India</p> <p>Ази, Номхон далайн улс орнуудын сайд нарын бага хурал</p>	<p>Энэтхэг Улсын Шинэ Дели хот 2016.11.02-05</p>
 <p>ASIAN MINISTERIAL CONFERENCE ON DISASTER RISK REDUCTION 2018 AMCDRR DILI, TIMOR-LESTE</p> <p>Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот 2018.07.03-06</p>	<p>Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлснээр тогтвортой хөгжлийг хамгаалах нь</p>
 <p>ASIA-PACIFIC MINISTERIAL CONFERENCE ON Disaster Risk Reduction Brisbane, Queensland, Australia 19-22 September 2022</p> <p>Австралийн Холбооны Улсын Брисбен хот 2022.09.19-22</p>	<p>Хямралаас гамшгийг даван туулах чадавх өөд</p>

2018 онд Улаанбаатар хотноо бүс нутгийн платформ болох Ази, Номхон далайн улс орнуудын сайд нарын бага хурлыг зохион байгуулсан нь Монгол Улсын гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны цар хүрээ бүс нутгийн хэмжээнд хүрч өргөжин тэлснийг харуулж байна.

2.4.ОНЦГОЙ КОМИСС

Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, үүссэн цагийн байдалтай холбогдуулан хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулах, шуурхай удирдан зохион байгуулах, хяналт тавих, шаардлагатай санхүүжилт, нөөцийн асуудлыг шийдвэрлэх чиг үүрэгтэй Улсын болон орон нутгийн онцгой комисс нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшиг, онцгой нөхцөл байдлын үед удирдлага, зохицуулалтаар хангах хамгийн дээд удирдлагын бүтэц юм.

Онцгой комиссын үйл ажиллагаа нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйл, Засгийн газрын 2008 оны 11 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын онцгой комиссын ажиллах журам”-аар зохицуулагдана. Эдгээр эрх зүйн баримт бичигт Улсын болон орон нутгийн онцгой комисс нь гамшгаас хамгаалах асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тодорхойлсон.

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

22.3.Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих эрх бүхий Улсын онцгой комиссыг Засгийн газар, аймаг, сум, нийслэл, дүүргийн онцгой комиссыг тухайн шатны Засаг дарга байгуулна.

ХҮСНЭГТ 2.4. ОНЦГОЙ КОМИССЫН ЭРХ, ҮҮРЭГ

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ	БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ, ЭРЭН ХАЙХ, АВРАХ,	ХОР УРШГИЙГ АРИЛГАХ СЭРГЭЭН БОСГОХ
ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД:		
27 ¹ .1.1.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах, хяналт тавих;		
27 ¹ .1.3.гамшгаас хамгаалах алба, орон нутгийн онцгой комисс, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах асуудлаар хүлээсэн эрх, үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох;		
27 ¹ .1.4.гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар тогтоол, албан даалгавар, тушаал гаргах;		

27¹.1.8.гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн эд хөрөнгө, барилга байгууламжийг нөхөн олговортойгоор дайчлан гаргах.

27¹.1.9.гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг батлах.

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМД:

Комисс нь дараах үүрэгтэй байна:

- 2.1.1. гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний бэлтгэлийг хангуулах ажлыг төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагаар гүйцэтгүүлэх, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын Ерөнхий сайдаас энэ чиглэлээр тусгайлан өгсөн үүргийг хэрэгжүүлэх;
- 2.1.3. гамшигтай тэмцэх асуудлаар гадаад орон, олон улсын байгууллагатай хамтран ажиллах, арга туршлагаа харилцан солилцох;
- 2.1.9. комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнийхээ талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж байх;
- 2.1.10. аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комиссын ажиллах үлгэрчилсэн журмыг батлах.

КОМИСС НЬ ДАРААХ ЭРХТЭЙ БАЙНА:

- 2.2.1. гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын удирдлагад үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих;
- 2.2.2. гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд холбогдох төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, албан тушаалтан, гадаадын хөрөнгө оруулалттай болон дотоодын аж ахуйн нэгж, иргэдийг хууль тогтоомжийн дагуу өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан татан оролцуулах;
- 2.2.3. холбогдох байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай тайлан, мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулан авах, мэдээлэл, илтгэлийг хэлэлцэж, шийдвэр гарган биелүүлэхийг шаардах;
- 2.2.6. гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажилд шаардагдах нэмэлт зардал болон бараа материал, тоног төхөөрөмж гаргах, яаралтай авах арга хэмжээний талаарх асуудлыг зөвхөн Сангийн яам болон Хууль зүй дотоод хэргийн яамны саналыг нэн даруй авч Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх;



<p>2.2.7.комиссоос олон нийтэд хүргэх анхааруулга, санамж болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийхдээ хэвлэл, мэдээллийн хэрэгслийг холбогдох журмын дагуу оролцуулах.</p>	<p>ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД:</p> <p>27¹.1.2.гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед Засгийн газраас тогтоосон чиглэлийн хүрээнд энэ хуулийн 10.4, 10.7-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих;</p> <p>27¹.1.5.гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын талаар болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг Засгийн газарт танилцуулах;</p> <p>27¹.1.6.шаардлагатай тохиолдолд гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах шуурхай штабыг, орон нутагт шуурхай бүлгийг байгуулж, ажиллуулах;</p> <p>27¹.1.7.шаардлагатай тохиолдолд төрийн байгууллага, хуулийн этгээдийн мэдээллийг сонсох.</p> <p>УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМД:</p> <p>КОМИСС НЬ ДАРААХ ҮҮРЭГТЭЙ БАЙНА:</p> <ul style="list-style-type: none"> ▪ 2.1.2. гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах; ▪ 2.1.4. гамшгийн цагийн байдалд өгсөн дүгнэлт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай яам, Засгийн газрын агентлагийн илтгэл мэдээллийг хэлэлцэж шийдвэр гаргах; ▪ 2.1.5. гамшиг бүхий нутаг дэвсгэр, бүс нутгийн холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, хорио цээрийн дэглэм тогтоох, гамшгийн үед иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас дайчлан гаргасан эд хөрөнгийн нөхөн төлбөрийн асуудлаар гамшиг үүссэн тухайн аймаг болон яамны гаргасан тооцоог үндэслэн санал боловсруулж Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх;
---	--

	<ul style="list-style-type: none"> ▪ 2.1.6. гамшгийн цагийн байдлын үнэлгээг мэргэжлийн байгууллага, шинжээчдээр хийлгэх, бий болсон нөхцөл байдал, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлагуудын шуурхай албад, аймаг нийслэл, орон нутгаас ирсэн мэдээллийг нэгтгэн дүгнэж, эрх бүхий байгууллага болон холбогдох албан тушаалтанд танилцуулж тэдгээрийг бодит мэдээллээр хангах. Үүнд: <p>Ердийн үед Засгийн газрын шуурхай мэдээллийн алба өдөр тутмын мэдээллийг яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн шуурхай албад, жижүүрээс хүлээн авч нэгтгэн Улсын онцгой комиссын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шуурхай мэдээллийн албанд холбоо, мэдээллийн техник хэрэгслээр болон бичгээр танилцуулна. Засгийн газрын бусад гишүүдэд цахим сүлжээгээр дамжуулан хүргэнэ. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шуурхай мэдээллийн алба нь дагаж мөрдөж байгаа журам, зааврын дагуу Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд болон ажлын албанд танилцуулна;</p> <p>Онцгой нөхцөл байдал үүссэн үед бүх мэдээллийг Улсын онцгой комиссын ажлын алба нэгтгэн дүгнэж, удирдлагыг нэг цэгийн шуурхай мэдээллээр тухай бүр хангаж нөхцөл байдлын талаар хэвлэл, мэдээллийн байгууллага, иргэдэд мэдээлэх ажлыг хариуцна.</p> <ul style="list-style-type: none"> ▪ 2.1.7. гамшгийн голомтод Засгийн газраас олгосон бараа, материал болон олон улс, хүмүүнлэгийн тусламж хүргэх тээвэрлэх явцад хяналт тавих; ▪ 2.1.8. гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, нэрвэгдэгсдэд шуурхай тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх ажилд шаардагдах хүн хүч, техник хэрэгслийг зохих журмын дагуу дайчлан гаргах асуудлыг төрийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтантай хамтран шийдвэрлэж зохицуулах, шаардлагатай нэмэгдэл хүн хүч, техник хэрэгсэл дайчлан гаргах санал боловсруулан зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх; <p>КОМИСС НЬ ДАРААХ ЭРХТЭЙ БАЙНА:</p> <ul style="list-style-type: none"> ▪ 2.2.4. гамшгийн голомтод хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шалгаж дүгнэлт гаргах,
--	---

	<p>илэрсэн эерчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;</p> <ul style="list-style-type: none"> ▪ 2.2.5. гамшгийн аюулаас аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээнд шаардлагатай тохиолдолд Зэвсэгт хүчин болон бусад хүчний байгууллагуудын анги, салбарын бие бүрэлдэхүүн, тусгай зориулалтын техник хэрэгслийг холбогдох хууль тогтоомжийн дагуу дайчлан ажиллуулах; ▪ 2.2.8.гамшгийн голомтод аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг удирдан зохион байгуулах, эдгээр арга хэмжээнд оролцож байгаа байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий шуурхай бүлгийг томилон ажиллуулах.
--	--

Орон нутгийн онцгой комиссын хувьд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹.2-д зааснаар нь Улсын онцгой комиссын бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. “Улсын онцгой комиссын ажиллах журам”-ын 3.4-т Аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комисс нь энэ дүрмийн 2.1.1, 2.1.2, 2.1.4, 2.1.7, 2.1.8-д заасан үүргийг биелүүлэн, 2.2.2, 2.2.3, 2.2.4, 2.2.7-д заасан эрхийг эдлэхээр заасан.

“Улсын онцгой комиссын ажиллах журам”-ын 1.4-т Улсын онцгой комиссыг онцгой байдлын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн тэргүүлэхээр заасны дагуу Онцгой комиссыг Шадар сайд ахалдаг бөгөөд бүрэлдэхүүнийг нь Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолын 14 дүгээр хавсралтад холбогдох яам, агентлаг, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан дор дурдсанаар тогтоосон.



ХҮСНЭГТ 2.5. УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	
ОРЛОГЧ ДАРГА:	Батлан хамгаалахын сайд болон Онцгой байдлын ерөнхий газрын дарга	
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:	Орон тооны дарга (“Улсын онцгой комиссын ажиллах журам”-ын 1.10-т зааснаар онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан, хурандаа буюу түүнээс дээш цолтой алба хаагч)	
АЖЛЫН АЛБА:	Онцгой байдлын ерөнхий газар (“Улсын онцгой комиссын ажиллах журам”-ын 1.11-т зааснаар орон тооны 5 гишүүн)	
ГИШҮҮД: (34 ГИШҮҮН)	<ul style="list-style-type: none"> ▪ Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга; ▪ Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга; ▪ Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга; ▪ Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны дарга; ▪ Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд; ▪ Сангийн сайд; ▪ Хууль зүй, дотоод хэргийн сайд; ▪ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд ▪ Барилга, хот байгуулалтын сайд; ▪ Зам, тээврийн хөгжлийн сайд; ▪ Соёлын сайд ▪ Эрчим хүчний сайд; ▪ Эрүүл мэндийн сайд; ▪ Цахим хөгжил, харилцаа холбооны сайд ▪ Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга ▪ Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга ▪ Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга 	<ul style="list-style-type: none"> ▪ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд; ▪ Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд ▪ Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч ▪ Гадаад харилцааны яамны төрийн нарийн бичгийн дарга; ▪ Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга ▪ Хил хамгаалах ерөнхий газрын дарга ▪ Тагнуулын ерөнхий газрын дарга ▪ Цагдаагийн ерөнхий газрын дарга ▪ Гаалийн ерөнхий газрын дарга ▪ Гадаадын иргэн, харьяатын ерөнхий газрын дарга ▪ Стандарт, хэмжилзүйн газрын дарга ▪ Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга ▪ Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын дарга ▪ Цөмийн энергийн комиссын Нарийн бичгийн дарга ▪ Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал ▪ Монголын улаан загалмайн нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.3-т зааснаар аймаг, сум, нийслэл, дүүргийн онцгой комиссын тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулах ба “Улсын

онцгой комиссын ажиллах журам”-ын 3.2-т зааснаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн онцгой комиссын дарга нь тухайн шатны Засаг дарга, уг комиссын орлогч дарга нь аймаг, нийслэл, дүүргийн онцгой байдлын газар, хэлтсийн дарга, суманд холбогдох ажилтан нь байна.

“Улсын онцгой комиссын ажиллах журам”-ын 1.3-т аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн шатны Засаг дарга батална гэж зааж, 2.3-т онцгой комиссын гишүүний үүргийг, 2.4-т онцгой комиссын гишүүний эрхийг дараахь байдлаар тогтоож өгсөн.

Онцгой комиссын хурал нийт гишүүдийн 50-аас доошгүй хувийн ирцтэй бол хүчин төгөлдөр болох бөгөөд хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Хурлын шийдвэр нь хууль тогтоомжид заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой тогтоол, албан даалгавар, тушаал байна. Комиссоос гаргасан шийдвэрийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан дагаж мөрдөнө.

2.3. КОМИССЫН ГИШҮҮН ДАРААХЬ ҮҮРЭГТЭЙ БАЙНА:

- 2.3.1. хуралд биечлэн оролцож бий болсон нөхцөл байдалтай холбогдуулан өөрийн эрхлэх ажлын хүрээнд шийдвэрлэх асуудлаар санал оруулах, гамшгийн голомт буюу хорио цээрийн дэглэм тогтоосон газарт зохих журмын дагуу нэвтэрч үйл ажиллагааг нь шалгаж, заавар зөвлөгөө өгөх;
- 2.3.2. гамшгаас хамгаалах хууль тогтоомж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журам Улсын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хянаж шалгах;
- 2.3.3. орон нутагт ажиллахдаа тухайн аймаг, сумын Онцгой комиссын ажлыг шалган танилцаж, заавар зөвлөгөө өгөх, тавьсан санал хүсэлтийг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, Онцгой комиссын чиглэлээр гүйцэтгэсэн ажлынхаа талаар комиссын даргад албан ёсоор танилцуулах.

2.4. КОМИССЫН ГИШҮҮН ДАРААХЬ ЭРХТЭЙ БАЙНА:

- 2.4.1. улсын болон аймаг, нийслэлийн гамшгийн нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, зайлшгүй сэргээн босгох арга хэмжээнд ашиглах техник хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, шаардлагатай бол комиссын хуралд асуудал танилцуулж авах арга хэмжээний талаар санал оруулж шийдвэрлүүлэх;
- 2.4.2. гамшгаас хамгаалах хууль тогтоомж түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гаргасан дүрэм журам, Онцгой комиссын шийдвэр, албан даалгаврыг хэрэгжүүлэх асуудлаар Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэх.

ШИГТГЭЭ 5:

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-Т ЦАР ТАХЛЫН ҮЕД УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Коронавируст халдвар (КОВИД-19)-т цар тахлын үед авах хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах зорилгоор УОК-ын даргын шийдвэрээр Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах үүрэгтэй УОК, Гамшгаас хамгаалах улсын албад болон холбогдох бусад байгууллагын төлөөллөөс бүрдсэн “Улсын онцгой комиссын шуурхай штаб”, орон нутгийн онцгой комиссын дэргэд “Орон нутгийн онцгой комиссын шуурхай штаб” байгуулж ажилласан.

Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын улмаас хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдал үүссэний улмаас Засгийн газрын 2020.02.12-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол гарч улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн байдаг. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах асуудлаар Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар 36 удаа, Улсын онцгой комиссын хуралдаанаар 40 удаа, тус комиссын шуурхай хуралдааныг 47 удаа хийж холбогдох шийдвэрийг гаргаж байсан.

ТОГТООЛ 12
ТУШААЛ 50

АЛБАН ДААЛГАВАР 5
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ 40



УЛСЫН ОНЦГОЙ КОМИСС

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед Улсын онцгой комиссоос гаргасан шийдвэрийн тоо (2020.02.12-оос 2020.12.31-ний өдрийн байдлаар)

УОК нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн үед авч хэрэгжүүлэх 17 үйл ажиллагааны чиглэлээр холбогдох шийдвэрийг гаргаж ирсэн.

Коронавируст халдварт цар тахлын үед зарласан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах үед УОК-ын гаргасан шийдвэрийн агуулга

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН 10 ДУГААР ЗҮЙЛИЙН 4 ДЭХ ХЭСЭГТ ЗААСАН ГАМШГААС ХАМГААЛАХ ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛСЭН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	АРГА ХЭМЖЭЭНИЙ ТОО
10.4.1.гамшгийн зарлан мэдээллийн дохиог хүн амд хүргэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, хэрэгжүүлэх;	12
10.4.2.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх;	4
10.4.3.гамшгийн зарлан мэдээллийг хүн амд шуурхай, хүртээмжтэй хүргэх;	12
10.4.4.хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, хүч хэрэгсэл, гамшгийн болон орон нутгийн нөөцийг дайчлах;	37

10.4.5.гамшгийн нөөцийг улсын хэмжээнд Засгийн газрын шийдвэрээр, орон нутагт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр нэмэгдүүлэх.	13
10.4.6.соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарлах, цуцлах, хориглох;	9
10.4.7.харилцаа холбоо, эрчим хүч, хүнс хангамж, шатахуун түгээх газар болон стратегийн зориулалттайгаас бусад худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газар, боловсролын байгууллагын үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар түр зогсоох, хилийн боомтыг түр хаах, эсхүл түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах;	29
10.4.8.голомтын бүсээс хүн, мал, амьтан, эд хөрөнгийг түр нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, түр орон байр, хүнс тэжээлээр хангах арга хэмжээг зохион байгуулах;	31
10.4.9.нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад чухал үүрэг бүхий хуулийн этгээдэд тусгай дэглэм тогтоож мөрдүүлэх;	43
10.4.10.төрийн болон төрийн өмчит байгууллагын үүрэг, зориулалт, хөдөлмөрийн нөхцөл, ажлын цагийн хуваарийг тогтоосон хугацаагаар өөрчлөх;	6
10.4.11.улсын онц чухал, төрийн тусгай хамгаалалтад байгаа болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг авах;	14
10.4.12.стратегийн хүнс, бараа, бүтээгдэхүүний хомсдол, үнийн хөөрөгдөл болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагад чиглэл болгох, хяналт тавих;	2
10.4.13.олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээн дэх гамшгийн тухай илт худал мэдээллийн тархалтыг бууруулах, зогсоох арга хэмжээг тухайн нөхцөлийн хэр хэмжээнд тохируулан тодорхой хүрээ, хугацаатайгаар авч хэрэгжүүлэх;	4
10.4.14.эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангуулах;	31
10.4.15.гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед улсын хил хамгаалах байгууллага холбогдох байгууллагатай хамтран хилийн боомтод тусгай дэглэм тогтоож, мөрдүүлэх;	18
10.4.16.химийн хорт болон аюултай бодис, ачаа тээвэрлэлтийг хязгаарлах, шаардлагатай тохиолдолд түр хугацаагаар зогсоох;	-
10.4.17.зайлшгүй шаардлагатай тохиолдолд иргэн, байгууллага, хуулийн этгээдээс холбогдох мэдээллийг авах бөгөөд тухайн мэдээллийн нууцлалыг хадгалах, түүнчлэн гамшгаас хамгаалахаас бусад зорилгоор урвуулан ашиглахгүй байх.	2

УОК нь гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн үед дараах нийтлэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад чухал үүрэг бүхий хуулийн этгээдэд тусгай дэглэм тогтоож мөрдүүлэх;
- Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, хүч хэрэгсэл, гамшгийн болон орон нутгийн нөөцийг дайчлах;
- Голомтын бүсээс хүн, мал, амьтан, эд хөрөнгийг түр нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, түр орон байр, хүнс тэжээлээр хангах арга хэмжээг зохион байгуулах;
- Эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангуулах;
- Харилцаа холбоо, эрчим хүч, хүнс хангамж, шатахуун түгээх газар болон стратегийн зориулалттайгаас бусад худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газар, боловсролын байгууллагын үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар түр зогсоох, хилийн боомтыг түр хаах, эсхүл түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах.

2.5. ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА

Гамшгийн эрсдэлийн засаглалд тухайн мэргэжлийн дагуу гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй төрийн захиргааны холбогдох яам, агентлагийг түшиглэсэн улс, аймаг нийслэлийн болон сум, дүүргийн гамшгаас хамгаалах орон тооны бус албад нь онцгой чухал байр суурь эзэлнэ.

Энэхүү гамшгаас хамгаалах албыг анх БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1967 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 42 дугаар тогтоолоор “Иргэний хамгаалалтын албадыг байгуулах тогтоол”-оор байгуулж байжээ¹¹. Энэ цаг үеэс хойш тус алба нь эрхэлсэн салбарынхаа аюулгүй байдлыг хангах, гамшгаас хамгаалах чиг үүргээ биелүүлж ирсэн байна. Гамшгаас хамгаалах албаны үйл ажиллагаа нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 347 дугаар тогтоолоор зохицуулагдана. Эдгээр эрх зүйн баримт бичигт Гамшгаас хамгаалах алба нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үе шат бүрд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэхээр тодорхойлсон.

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

22.6. Салбар дундын гамшгаас хамгаалах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, уялдуулан зохицуулах, мэдээ, мэдээлэл солилцох, хүч хэрэгсэл, нөөцийг оновчтой хуваарилах зорилгоор төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, холбогдох бусад бэйгууллагыг түшиглэн гамшгаас хамгаалах орон тооны бус Улсын албыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, аймаг, сум, нийслэл, дүүрэгт орон нутгийн албыг тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулна.

¹¹Монгол Улсын Иргэний хамгаалалтын түүхэн замнал, 2017

ХҮСНЭГТ 2.6. ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБАНЫ ЧИГ ҮҮРЭГ

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ	БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ, ЭРЭН ХАЙХ, АВРАХ,	ХОР УРШГИЙГ АРИЛГАХ СЭРГЭЭН БОСГОХ
<p>ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах (33.1.1); ➤ Хууль тогтоомж, дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах (33.1.3); ➤ Орон нутгийн гамшгаас хамгаалах албыг мэргэжлийн удирдлагаар хангах (33.1.8); ➤ Хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах (33.1.11); ➤ Хариуцсан салбарын хүрээнд холбогдох дүрэм, журам, удирдамж, заавар, стандартыг боловсруулж батлуулах (33.1.14) 		
<p>ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ НИЙТЛЭГ ЖУРАМД:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Улсын албаны бүрэлдэхүүн, техник, хэрэгслийн бэлэн байдлыг хангах (2.1.1); ➤ Шаардлагатай бол Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, бусад албадтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах (2.1.2); ➤ Гамшгаас хамгаалах чиглэлээр тушаал, албан даалгавар, удирдамж гаргах, биелэлтийг шалгах, салбарын хүрээнд баримтлах дүрэм, журам, заавар боловсруулж батлах, хэрэгжүүлэх (2.1.4); ➤ Засгийн газар, Улсын онцгой комисс, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг мэргэжлийн зөвлөгөө, заавар, мэдээ мэдээллээр шуурхай хангах (2.1.5); 		
<p>ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, бууруулах арга хэмжээг тусгах, хэрэгжүүлэх (33.1.2); ➤ Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны талаарх мэдээ, тайлан гаргах (33.1.13); <p>ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ НИЙТЛЭГ ЖУРАМД:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Гамшгийн эрсдэлийн үнэлгээг эрх бүхий байгууллагаар хийлгэх, үнэлгээнд үндэслэн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, 	<p>ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Салбарын онцлогт нийцүүлэн гамшгаас хамгаалах албаны бүрэлдэхүүнийг тогтоох, мэргэжлийн ангийг байгуулах, тэдгээрийн сургалт, бэлтгэл, бэлэн байдлыг хангах (33.1.4); ➤ Гамшиг болон аюулын үед салбарын тогтвортой ажиллагааг хангах (33.1.5); ➤ Салбарын зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангах (33.1.6); ➤ Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах хүч хэрэгсэл, гамшгийн нөөцийг бүрдүүлэх (33.1.7); ➤ Гамшиг болон аюулын нөхцөл байдлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн 	<p>ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийлгэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах (33.1.12);

<p>мэдээ, тайлан гаргах (2.1.3);</p>	<p>захиргааны байгууллагад шуурхай мэдээлэх, хамтран ажиллах (33.1.9);</p> <ul style="list-style-type: none"> ➤ Голомтын бүсэд ажиллах мэргэжлийн бие бүрэлдэхүүнийг шаардагдах техник, материал хэрэгслийн хамт оролцуулах (33.1.10); <p>ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ НИЙТЛЭГ ЖУРАМД:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Гамшиг болон аюулт үзэгдэл, ослын үед салбарыг ажлын тусгай горим болон гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, гамшгийн голомтын бүсэд хүч хэрэгслийг шуурхай томилон ажиллуулах (2.1.6); ➤ Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдыг шаардагдах техник, материал хэрэгслээр хангах, ажиллах нөхцөлийг бүрдүүлэх (2.1.7) 	
--------------------------------------	--	--

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд гамшгаас хамгаалах улсын албаны эдгээр чиг үүргийг эрхэлсэн салбарынхаа хэмжээнд хариуцах, хэрэгжилтийг хангуулах, зохион байгуулах, холбогдох талуудтай мэдээ, мэдээлэл шуурхай солилцох нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Гамшгаас хамгаалах улсын алба нь гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны албан хаагчтай байх (33.2)-аар түүнчлэн, орон нутгийн гамшгаас хамгаалах алба эдгээр чиг үүргээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах чиг үүргийг хэрэгжүүлэх (33.3)-ээр заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 347 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад гамшгаас хамгаалах улсын 12 албад ажиллахаар зааж, улсын албаны дарга, тэдгээрийн түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллагын жагсаалтыг дор дурдсанаар тогтоосон.

ХҮСНЭГТ 2.7. ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАД

Д/Д	УЛСЫН АЛБАНЫ НЭР	УЛСЫН АЛБАНЫ ДАРГА	ТҮШИГЛЭН АЖИЛЛАХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА
1.	БАЙГАЛИЙН БОЛОН ХИМИЙН АЮУЛЫГ ҮНЭЛЖ, МЭДЭЭЛЭХ АЛБА	Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
2.	БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН АЛБА	Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
3.	ЗАМ, ТЭЭВРИЙН АЛБА	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
4.	УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН АЛБА	Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.	ХҮН АМ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН АЛБА	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
6.	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН АЛБА	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
7.	ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ АЛБА	Эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
8.	ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБА	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
9.	МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ АЛБА	Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
10.	МЭРГЭЖЛИЙН БОЛОН ЦАЦРАГИЙН ХЯНАЛТЫН АЛБА	Мэргэжлийн хяналтын төв байгууллагын дарга	Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
11.	ХЭВ ЖУРАМ САХИУЛАХ АЛБА	Цагдаагийн төв байгууллагын дарга	Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага
12.	СУРТАЛЧИЛГААНЫ АЛБА	Засгийн газар хэрэг эрхлэх газрын дэд дарга	Засгийн газар хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах нэгж

Энэхүү Засгийн газрын 2018 оны 347 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”-д, гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус удирдлагын бүрэлдэхүүн буюу штабтай байхаар зааж, түүний эрх, үүргийг тодорхойлж өгсөн.

“Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”-д түүний штабын бүрэлдэхүүнийг дор дурдсан хэлбэрээр тогтоож өгсөн байна.



“ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ АЖИЛЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ”-ЫН 3.1 ДЭХ ЗҮЙЛ ШТАБ НЬ ДАРААХ ЭРХ, ҮҮРЭГТЭЙ

- 3.1.1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, улсын албаны даргаар батлуулах;
- 3.1.2. Улсын албаны удирдлагын баримт бичгийг төлөвлөх, хүч хэрэгслийг томилж ажиллуулах;
- 3.1.3. Гамшгийн аюулын зарлан мэдээлэл дамжуулах тогтолцоог бүрдүүлж, дохиогоор ажиллах дадлага сургууль зохион байгуулах;
- 3.1.4. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай мэдээ, мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, бусад улсын болон орон нутгийн албанаас гаргуулан авч, мэдээллийн сан бүрдүүлэх;
- 3.1.5. Гамшиг, ослын нөхцөл байдлыг үнэлж, дүгнэн хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 3.1.6. Орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг удирдлага арга зүйгээр хангаж, шаардлагатай тохиолдолд гамшгийн голомтын бүсэд ажиллах;
- 3.1.7. Гамшгаас хамгаалах чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулж, сургалтын материал, гарын авлага боловсруулах;
- 3.1.8. Гамшгийн нөхцөл байдлын мэдээ, мэдээлэл, улсын албаны шийдвэрийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага холбогдох улсын болон орон нутгийн алба, байгууллага, иргэдэд шуурхай хүргэх;
- 3.1.9. Орон нутгийн алба, мэргэжлийн ангиас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан мэдээг хүлээн авч нэгтгэн, гамшгаас хамгаалах чиглэлээр улсын албанаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, мэдээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хагас, бүтэн жилээр гаргаж хүргүүлэх.

ЗУРАГ 2.4. УЛСЫН АЛБАДЫН ШТАБЫН БҮТЭЦ



Гамшгаас хамгаалах улсын албад нь салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг гамшгийн 3 үе шатанд зохион байгуулж, гамшгаас хамгаалах асуудлаар Засгийн газар, Улсын онцгой комисс, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг мэргэжлийн зөвлөгөө, заавар, мэдээ мэдээллээр хангах чиг үүрэгтэй, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, Онцгой комисст төлөөлөл бүхий гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бүтэц юм.

ГАМШГААС ХАМГААЛАХ МЭРГЭЖЛИЙН АНГИ

Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дүрэмд “Мэргэжлийн анги гэж төрийн өмчит болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагыг түшиглэсэн, аврах ажлын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан, гамшгийн аюулаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг урьдчилан сэргийлэх, эрэн хайх, авран хамгаалах, хойшуулшгүй сэргээн босгох ажлыг гүйцэтгэхээр сургаж бэлтгэгдсэн орон тооны бус томилгоот нэгжийг хэлнэ” гэж тодорхойлсон.

Мэргэжлийн ангийг зориулалтаар нь ерөнхий болон тусгай зориулалтын гэж ангилна. Манай улсад дараах төрлөөр гамшгаас хамгаалах мэргэжлийн ангиуд байгуулагдан ажиллаж байна. Үүнд:

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

22.8. Аймаг, сум, нийслэл, дүүрэг, хуулийн этгээд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн ангитай байна.

<ul style="list-style-type: none"> ➤ Ерөнхий зориулалт ➤ Эмнэлгийн яаралтай тусламж ➤ Хээрийн эмнэлэг ➤ Цус сэлбэх хөдөлгөөнт ➤ Хөдөлгөөнт эмийн сан ➤ Эмнэлэг эрүүл ахуй, сэтгэл зүйн дэмжлэг ➤ Хүүхэд хамгаалал ➤ Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах ➤ Гал унтраах ➤ Дулааны шугам сүлжээний засвар ➤ Цэвэр, бохир усны засвар ➤ Цахилгааны шугам сүлжээний засвар ➤ Зам, гүүрний засвар ➤ Инженер тэсэлгээний ажил ➤ Хэв журам сахиулах, харуул хамгаалалт ➤ Цацраг, химийн хяналт 	<ul style="list-style-type: none"> ➤ Ургамал, газар тариалан хамгаалах ➤ Мал эмнэлгийн нарийн мэргэжлийн хөдөлгөөнт ➤ Санхүү, нийгмийн хамгаалал Хүнсний хангалт ➤ Нөөцийн материал, орон сууцны хангалт ➤ Уст цэг хамгаалах ➤ Цугларах байр ➤ Шатахуун хангамж Тээвэр ➤ Ариутгал, халдваргүйжүүлэлт ➤ Холбоо, зарлан мэдээлэл ➤ Сурталчилгаа, мэдээлэл ➤ Иргэний бүртгэл, мэдээлэл ➤ Төмөр замын техникийн засвар ➤ Нисэх буудлын авран туслах
--	--

ШИГТГЭЭ 6:

ЗАМ ТЭЭВРИЙН АЛБАНААС ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨМӨР ЗАМД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ҮЕРИЙН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлөөс төмөр зам болон авто замыг цаг агаарын аливаа аюулт үзэгдэлд өртөж эвдэрч гэмтэхээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, түүнд үндэслэн шинээр барих, хүчитгэн сайжруулах төмөр зам, авто замын нарийвчилсан тооцоо, судалгааг боловсруулах чиглэлийг 2020 онд Зам, тээврийн албанд өгсний дагуу “Төмөр замд учирч болзошгүй үерийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ”-г авч хэрэгжүүлсэн байна.

Энэ хүрээнд гамшгаас хамгаалах улсын албад, тухайн салбарын мэргэжилтнүүдийн төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг төмөр замд учирч болзошгүй үерийн гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрсдэлийн үнэлгээ хийхэд мэргэжил аргагүйн зөвлөмжөөр хангаж ажиллажээ.

Өндрийн тоон загвар болон өмнө тохиолдсон гамшиг, ослын мэдээлэл, дэлхийн дулааралтай холбоотой хур тунадасны хэмжээ нэмэгдэж, олон цагаар орох, авто замын хөгжилтэй холбоотой, төмөр замын харалдаа байрлах цэгүүдэд чиглүүлэгч даланг сэтлэх, хиймэл төхөөрөмж байгууламжийн уялдаа холбоо алдагдах, ус зүйн судалгаа шинжилгээг шинэчилж хийгээгүй зэргээс шалтгаалж төмөр зам үерт өртөх байдал нэмэгдэж байгаад үндэслэн Улаанбаатар төмөр замын усанд автах үерийн эрсдэлийн зураглалыг боловсруулж энэ хүрээнд 1115 км төмөр зам дагуу 52 хэсэг усанд автах магадлалтайг тогтоосон.

Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээгээр аюулд өртөх магадлал, хохирол тохиолдож болзошгүй нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, үерийн аюулыг даван туулах чадавхыг тодорхойлон үнэлгээ өгч тооцсоны үндсэн дээр төмөр замын зам, байгууламж нь үерийн гамшигт өртөх “өндөр эрсдэлтэй” гэж дүгнэжээ. Эрсдэлийн үнэлгээнээс үерийн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд дараах зөвлөмжийг гаргасан байна. Үүнд:

- Эрсдэл өндөртэй цэгүүдэд төлөвлөгөө гарган эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах;
- Ус зүйн нарийвчилсан судалгаа, шинжилгээг хийлгэх, ус зүйн судалгаанд үндэслэн ус нэвтрүүлэх чадвар хүрэлцэхгүй хоолойнуудыг үе шаттай томсгож, солих;
- Замын хажуугийн болон уулын суваг шуудуу, голдирол сэргээх ажлын их засварын төлөвлөгөө гаргаж, санхүүжилтийг нэмэгдүүлэх;
- Экскаватор, бульдозер гэх мэт хүнд машин механизм шинээр худалдан авч техникийн хүрэлцээтэй байдлыг нэмэгдүүлэх;
- Эрсдэл өндөртэй цэгүүдэд сүүлийн үеийн усны түвшин мэдрэгч төхөөрөмжийг байрлуулах;
- Төмөр замын трассын дагуу цаг агаарын нарийвчилсан мэдээг тогтмол авч, урьдчилан арга хэмжээ авч хэвших.

Үерийн эрсдэлийн үнэлгээний үр дүнд тулгуурлан төмөр замд учирч болзошгүй үерийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж байна.

Тодруулбал, 2020 оны 09 сард Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалын дагуу Авто замын хөгжлийн газартай хамтарсан комисс үерийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний мөрөөр газар дээр нь төмөр замын дагуух авто зам байрлах километрүүдэд үзлэг шалгалт хийж үерийн усанд угаагдах өндөр эрсдэлтэй 17 цэгийг тодорхойлж, эдгээр цэгүүдийн эрсдэлийг бууруулах, төлөвлөгөө гарган 2020 оны 10 сарын 01-ны байдлаар шинээр 5 цэгт ус зайлуулах хоолой барих ажлыг хийж гүйцэтгэж эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсан байна. 2021 оны 2 дугаар сард Зам тээврийн хөгжлийн яам, Улаанбаатар төмөр зам ХНН, Онцгой байдлын ерөнхий газрын хамтарсан ажлын хэсэг гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээгээр өндөр эрсдэлтэй гэж тодорхойлогдсон төмөр замын хэсгүүдэд нэгдсэн хяналт үзлэг зохион байгуулсан.

2.6. ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГА

Онцгой байдлын байгууллага нь улс, орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хуулийн этгээдийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулан ажилладаг¹². Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу (22.1.) гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өмчийн хэлбэр үл харгалзан зохион байгуулж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2003 онд “**ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**”-ийг анх баталснаар тус улсад Онцгой байдлын байгууллага байгуулах эрх зүйн орчин бүрдсэн. Засгийн газрын 2004 оны 8 дугаар тогтоолоор гамшгаас хамгаалах чиг үүрэг бүхий Улсын Иргэний хамгаалалтын газар, Галын аюулаас хамгаалах газар, Улсын нөөцийн газар гэсэн гурван агентлагаас бүрдсэн Гамшгаас хамгаалах ерөнхий газар байгуулагдсан. Засгийн газрын 2005 оны 48 дугаар тогтоолоор Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) болгон нэрлэсэн байдаг.

Гамшгаас хамгаалах тухай хуульд улс, орон нутгийн хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах, нутгийн захиргааны байгууллага болон хуулийн этгээдийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй Онцгой байдлын байгууллагын тогтолцоог дараах байдлаар шийдвэрлэсэн байна.

¹² Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017, 22.4

Үүнд:

- улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бодлого, үйл ажиллагааг чиглүүлэх үүрэгтэй Монгол Улсын Шадар сайд,
- гамшгаас хамгаалах төрийн бодлого, гамшгаас хамгаалах талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, штаб,
- бүсийн төв, аймаг, нийслэл, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбар, бүлэг,
- олон улсын болон агаарын эрэн хайх, аврах баг, эрэлч нохойн алба,
- шуурхай удирдлага-зарлан мэдээллийн төв,
- ар тал, тээвэр-логистик, бүтээн байгуулалт-барилга байгууламж, техник засвар, үйлчилгээ, дүрэмт хувцас, тусгай хэрэгслийн үйлдвэр,
- эмнэлэг-сувилал,
- судалгаа шинжилгээ, сургалт, туршилт үйлдвэрлэл,
- архив, спорт, соёл урлаг болон
- бусад нэгжтэй байна¹³.

Засгийн газрын 2016 оны 66 дугаар тогтоолоор орон нутгийн Онцгой байдлын хэлтсүүдийг газар болгон өргөтгөж, Баруун бүс, Зүүн бүс, Хойд бүс, Өмнөд бүс, Улаанбаатар бүс гэсэн 5 бүсийн төвд хувааж томоохон бүтцийн өөрчлөлт хийснээр Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны хүрээ томрон, бүтэц өргөжиж бүх аймаг, нийслэлд Онцгой байдлын газар, дүүрэг, зарим сумдад Онцгой байдлын хэлтэстэй, харин аймаг, нийслэл, сум дүүрэгт гал унтраах, эрэн хайх аврах анги, салбар, улсын нөөцийн салбар нэгжтэй (Зураг 2.3) болсон.

ОБЕГ-ын харьяанд дараах газар, анги, салбарууд хуулиар хүлээсэн тусгайлсан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Үндэсний аврах бригад,
- Уул уурхайн аврах анги,
- Гамшиг судлалын үндэсний хүрээлэн,
- Аврагч биеийн тамир, техник спортын хороо,
- Улсын нөөцийн хүнс, өвс тэжээл, шатахууны салбар
- Эрэлч нохойн алба
- Давтан сургалт, сэргээн заслын төв

¹³ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 42.3 дахь заалт

БҮЛЭГ 3. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ

3.1. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг Гамшгаас хамгаалах хууль, тогтоомж болон бодлогын баримт бичигт дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:



1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна”, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар баталсан Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааварт энэ төлөвлөгөөний 3 дугаар бүлэг нь Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө байх;
2. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22.5-д “Үндэсний болон орон нутгийн зөвлөл нь хөгжлийн бодлого, төлөвлөлтөд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг тусгах...”;
3. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл дэх Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийн 31.1.1-д “аймаг, сум, нийслэл, дүүргийн гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөр болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг баталж, гүйцэтгэлд хяналт тавих;
4. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйл дэх Гамшгаас хамгаалах улсын албаны чиг үүргийн 33.1.2-д салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, бууруулах арга хэмжээг тусгах, хэрэгжүүлэх зэрэг болно.

Мөн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн 3.3.2-д “гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг салбарын бодлогын баримт бичигт тусгаж хэрэгжүүлэх” гэж тусгасан.

Эндээс харахад гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд нь **нэгд**, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгаж, **хоёрт**, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний гуравдугаар бүлэгт “Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө” боловсруулах гэсэн 2 хэлбэрээр төлөвлөж, хэрэгжүүлэхээр байна.

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОДОРХОЙЛОХ

Гарын авлагын 1 дүгээр бүлгийн 1.2 дахь Гамшгийн эрсдэлийн удирдлагын үйл явцаас харахад гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөлт нь гамшгийн эрсдэлийн үнэлгээнд суурилж хийгдэнэ. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ нь тохиолдож болох аюулт үзэгдэл, осол, өртөх эд зүйл, хамгаалах чадавхын талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгөхийн зэрэгцээ эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж өгдөг.

Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг тодорхойлохдоо гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнгээс гарсан зөвлөмжид үндэслэхээс гадна тухайн орон нутгийн болон салбарын нийгэм, эдийн засгийн үзүүлэлт, байгаль орчны суурь нөхцөл байдал, хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтууд, гамшигтай холбоотой туршлага, сургамж, гамшгийн эрсдэлийн талаарх судалгааны ажлын тайлан, мэдээ, мэдээлэлд тулгуурлахаас гадна дараах зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай юм.

Үүнд:



- Хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилтууд, тодруулбал Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.4-4.1.14- заасан Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд, нэн ялангуяа эдгээрт туссан гамшгийг эрсдэлийг бууруулахтай холбоотой зорилтуудтай уялдуулах;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн зорилго, зорилтууд болон Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, энэ стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нийцэх;
- Олон нийт, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил зэрэг олон талуудын санал, санаачилгыг нэгтгэх;
- Хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагыг тусгах;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах бусад ижил төстэй нөхцөлд хэрэгжиж амжилтад хүрсэн, үр дүнтэй болохоо харуулсан сайн туршлага, эсвэл үр дүнд хүрээгүй сургамжийг харгалзах.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөхийн тулд байгаа нөөцийнхөө хүрээнд эрсдэлийг бууруулах хамгийн тохирсон арга хэмжээг олох шаардлагатай. Тохиолдож болзошгүй хор уршиг өндөртэй аюулын тохиолдох магадлал, эмзэг байдлыг бууруулах, түүнчлэн гамшгаас хамгаалах чадавхыг

бэхжүүлэхийн тулд гамшгийн эрсдэлийг бууруулах болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлд авч хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг тодорхойлж, эрэмбэлнэ. Ингэж эрэмбэлэх нь орон нутгийн болон салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт гамшгийн эрсдэлийг бууруулах ямар арга хэмжээг тусгах, түүнчлэн ямар арга хэмжээг нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөний гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөнд оруулж хэрэгжүүлэхийг тогтоож өгөх ач холбогдолтой.

3.2. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТӨД ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ТУСГАХ

Аливаа хөгжлийн үйл ажиллагааг төлөвлөхдөө болзошгүй гамшгийн эрсдэлийг харгалзах шаардлага байгааг Гарын авлагын 1 дүгээр бүлгийн 1.4-д авч үзсэн бол мөн манай улсын хувьд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд нь хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгаж хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалттай болохыг гарын авлагын 3.1-д тодорхойлсон.

Олон улсад гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг хөгжлийн үйл явцад харгалзаж үзэхийг **"уялдуулан тусгах"** гэсэн ойлголтоор илэрхийлнэ. "Уялдуулан тусгах" хэмээх нэр томъёо нь нэг үйл явцыг өөр нэг бүтэц, үйл явцын салшгүй нэг хэсэг болгон нэгтгэх, институцилах тухай асуудал. Өөрөөр хэлбэл, гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд уялдуулан тусгах үйл явцын зорилго нь шинэ бүтэц, үйл явцыг бий болгох биш, харин хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл явцын салшгүй нэг хэсэг болгон нэгтгэх, институцилах явдал юм.

Гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг бүх түвшний буюу үндэсний, бүс нутгийн, орон нутгийн болон салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл явцад уялдуулан тусгах нь дараах ач холбогдолтой. Үүнд:



- хөгжлийн бүх бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд болзошгүй гамшиг, уур амьсгалын эрсдэлийг тооцсон, учирч болох нөлөөллийг нь даван туулах чадвартай байх явдлыг баталгаажуулах;
- хөгжлийн бүх бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүд санаандгүй байдлаар хүний хөгжил, нийгэм, байгаль орчин, эдийн засаг, дэд бүтцийн гамшгийн эрсдэлд өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлэхгүй байх явдлыг баталгаажуулах;
- Тогтвортой хөгжлийн зорилгод хувь нэмэр оруулж, болзошгүй гамшиг, уур амьсгалын эрсдэлийг бууруулах явдлыг баталгаажуулах.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг уялдуулан тусгах гэдэг нь эрсдэлийн асуудлыг үндэсний ба салбарын хөгжлийн үйл ажиллагааны хүрээнд онцгойлон анхаарахын зэрэгцээ тогтмол явагддаг үйл ажиллагааныхаа нэгэн хэсэг болгох, бүтэцжүүлэх явдал юм. Тухайлбал, уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан бий болж болзошгүй аюулаас хөгжлийн ололт амжилтуудыг хамгаалах асуудлыг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах замаар хангах нь чухал. Монгол Улс нь уур амьсгалын өөрчлөлтөд маш их өртөж байгаа орны нэг. Тиймээс уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг

хөгжлийн бодлого төлөвлөлтөд тусгах нь Монгол Улсын хувьд чухал асуудал билээ. Гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг хөгжлийн бодлого төлөвлөлтөд уялдуулан тусгахын тулд, нэн тэргүүнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн талаар болон эдгээрийг боловсруулах үйл явц, үе шатыг ойлгох шаардлагатай юм.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.4-4.1.12-д заасан Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдийн талаарх тойм мэдээллийг хүснэгт 3.1-д нэгтгэн харуулав.



Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах үйл явц янз бүр байдаг ч манай улсын хувьд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4.1.4-4.1.12-д заасан бодлогын баримт бичгийг боловсруулах журам, зааврыг тогтоосон Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам”, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 42 дугаар тушаалаар батлагдсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах аргачлал”-д хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах үе шатыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:



- Нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх;
- Бодлогын хувилбарыг боловсруулах;
- Бодлогын баримт бичгийн зорилго, зорилт хүрэх үр дүн, үйл ажиллагаа, арга хэмжээг тодорхойлох;
- Бодлогын баримт бичгийн зорилго, зорилт хүрэх үр дүн, үйл ажиллагаа, арга хэмжээний шалгуур үзүүлэлт тодорхойлох;
- Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхойлох.

ХҮСНЭГТ 3.1.МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ
БИЧГИЙН ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

ТӨРӨЛ	БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН НЭР	ХЭРЭГЖИХ ХУГАЦАА /ЖИЛ/	БОЛОВСРУУЛАХ	БАТЛАХ	
УРТ ХУГАЦАА	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	10-30	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	УИХ	
ДУНД ХУГАЦАА	Хөгжлийн зорилтот хөтөлбөр	10			
	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,	5	Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн аймаг, нийслэл, хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан захиргааны байгууллага	ИТХ	
	Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл				
	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	4	Засгийн газар	УИХ	
БОГИНО ХУГАЦАА	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр	1	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	ИТХ	
	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө			Засгийн газар	
	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө			Засаг дарга	
	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр			Засгийн газар	
	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө,			УИХ	
	Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө,			ИТХ	
	Улсын төсөв Орон нутгийн төсөв			Сангийн яам	УИХ

**ХҮСНЭГТ 3.2. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮЙЛ ЯВЦАД
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АСУУДЛЫГ ТУСГАХ**

ҮЕ ШАТ	БОЛОВСРУУЛАХ АСУУДАЛ
НӨХЦӨЛ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ	<ul style="list-style-type: none"> ➤ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах хүрээнд холбогдох төрийн захиргааны байгууллагууд үндэсний хэмжээнд болон салбарын эрхлэх асуудлын хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийнэ. Энэ үед нэн түрүүнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгах шаардлагатай тулгамдсан асуудлыг тодорхойлно. ➤ Тулгамдсан асуудал гэдэг нь тухайн бодлогын баримт бичгийн хүрээнд хамаарах нийтэд тулгарч байгаа төрөөс зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай асуудал юм. ➤ Нэн ялангуяа гамшгийн нөлөөнд хамгийн эмзэг буюу гамшгийн улмаас их хэмжээний эдийн засгийн хохирол учирдаг, үйлчилгээ нь доголддог салбарууд, эсвэл гамшгийн эрсдэлийг нэмэгдүүлэхэд хамгийн их нөлөөлж байгаа салбаруудыг сонгож эдгээрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг тэдгээрийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт уялдуулан тусгахад түлхүү анхаарна. ➤ Боломжтой бол гамшгийн эрсдэлийн цогц үнэлгээг хийсний үндсэн дээр нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай тулгамдсан асуудлыг сонгох хэрэгтэй.
БОДЛОГЫН ХУВИЛБАРЫГ БОЛОВСРУУЛАХ	<ul style="list-style-type: none"> ➤ Засгийн газар, холбогдох захиргааны байгууллагууд нөхцөл байдлын дүн шинжилгээгээр тодорхойлогдсон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх бодлогын хувилбарыг боловсруулан хүний хөгжил, нийгэм, байгаль орчин, эдийн засгийн хүрээнд урт, дунд хугацаанд тулгамдаж байгаа төрөөс зайлшгүй арга хэмжээ авах шаардлагатай асуудлуудыг шийдвэрлэх хувилбаруудыг тодорхойлно. ➤ Энэ үе шатанд бодлогын баримт бичигт оруулах хувилбаруудыг шаардагдах санхүүжилт, хүлээгдэж байгаа үр дүн, бусад бодлоготой уялдах уялдаа, зарцуулах хугацаа, шаардлагатай хүний нөөц, оролцогч талуудын дэмжих магадлал гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлж, эрэмбэлж, хэлэлцэн, тухайн асуудлыг бодлогын баримт бичигт оруулах эсэхийг шийднэ. Иймд энэ үе шатанд гамшгийн эрсдэлийн мэдрэмжтэй бодлогын асуудлыг хасалгүй тусгах чиглэлд онцгой анхаарч эцэслэн батлагдсан бодлогын баримт бичиг

	<p>эрсдэлийн мэдрэмжтэй хөгжлийг дэмжсэн байх нөхцөлийг бүрдүүлнэ.</p>
<p>БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ ХҮРЭХ ҮР ДҮН, ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Бодлогын баримт бичгийн зорилго, зорилт нь нөхцөл байдлын дүн шинжилгээгээр тодорхойлогдож, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, сонгосон хувилбарт үндэслэсэн урт, дунд, богино хугацаанд хүлээгдэж байгаа эерэг өөрчлөлтийг илэрхийлсэн байх шаардлагатай. Зорилго, зорилтын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа, арга хэмжээ нь бодлогыг хэрэгжүүлэгч байгууллагаас нийлүүлж байгаа ажил, үйлчилгээ байна. Эдгээр нь тодорхой, хэмжигдэхүйц, хүрч болохуйц, хэмжигдэхүйц бодитой, хугацаатай байна. ➤ Аливаа бодлогын баримт бичгийн зорилго, зорилт нь өөрөөсөө урт хугацааны болон дээд шатны бодлогын баримт бичгийн зорилго, зорилтыг хангахад чиглэсэн буюу бодлогын уялдааг сайтар хангасан байх ёстой.
<p>БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ТОДОРХОЙЛОХ</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Бодлогын баримт бичгийн үр дүн, ололт амжилтад хяналт-шинжилгээ хийх, үнэлэхэд ашиглах шалгуур үзүүлэлтийг зорилго, зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээ тус бүрээр хүлээгдэж байгаа үр дүнг бүрэн хэмжихүйц, аль болох тоогоор илэрхийлэхүйц байдлаар боловсруулна. Шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа хэмжих нэгж, суурь болон хүрэх түвшин, мэдээллийн эх сурвалж, мэдээлэл цуглуулах арга зүй, мэдээлэл цуглуулах давтамж, хариуцах байгууллагыг тодорхойлж өгнө. ➤ Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хянах, үнэлэхэд ашиглах шалгуур үзүүлэлт нь гамшгийн эрсдэлийг болон уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээ хэр ач холбогдолтой байж, үр дүнд хүрч чадсан эсэхийг тогтоох бүрэн боломжтой байдлаар тодорхойлогдох ёстой.
<p>БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, ЭХ ҮҮСВЭРИЙГ ТОДОРХОЙЛОХ</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг бодлогын баримт бичгийн зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээ бүрээр тодорхойлно. ➤ Санхүүжилтийн эх үүсвэр нь улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, засгийн газрын үнэт цаас, концессын гэрээ болон бусад эх үүсвэр байж болно.

Үндэсний хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг байгууллагууд нэгдсэн арга зүй, үйл явцыг нийтлэг ашиглаж байгаа нь төрийн бодлого боловсруулах үйл ажиллагаанд эрсдэлийн асуудлыг тусгах боломжийг олгож байна. Уур амьсгал, гамшгийн эрсдэлийн асуудлыг эдгээр арга хэрэгсэлд тусгах нь ирээдүйн бодлого хөтөлбөрүүд бас энэ асуудлыг үйл ажиллагааныхаа нэг хэсэг болгон тусгах эрхтэй болж байна.

Эндээс аль салбарт гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг авч үзэж байгаа, ямар үйл ажиллагааг хэрэгжүүлж байна, цаашид анхаарал хандуулах эсвэл ямар асуудлыг сайжруулах шаардлагатай талаар ойлголттой болж, салбар дундын зохицуулалтыг сайжруулах боломж бүрдэнэ.

Манай улсын хувьд гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодлогын босоо уялдааг Улсын Их Хурал болон Засгийн газрын түвшинд болон салбарын хэмжээнд харьцангуй сайн хангаж, харин хэвтээ уялдааг буюу салбарууд хоорондын уялдааг хангах асуудал эрхэлсэн байгууллага нь бодлогоо бусад бодлоготой уялдуулах асуудал харьцангуй сул байдаг.

3.3. ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТУСГАН ТӨЛӨВЛӨХ НЬ

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх өөр нэг хэлбэр нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд нь Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний гуравдугаар бүлэгт “Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-г боловсруулж хэрэгжүүлэх гэдгийг гарын авлагын 3.1-д тодорхойлсон. Энэхүү Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний салбар төлөвлөгөө болох Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг хэрхэн боловсруулах талаар авч үзье.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8.1-д “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна” гэж заасан.

Хуулийн энэ заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/388 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах загвар”-ыг тус тус баталсан. Эдгээр баримт бичигт зааснаар Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг дараах 3 төрлөөр боловсруулна. Үүнд:

1. **Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө**
2. **Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөө**
3. **Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө**

Эдгээр төлөвлөгөөний нэг салбар төлөвлөгөө нь Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө байна. Төлөвлөгөөний загварыг хавсралт 3-аас харна уу.

ХҮСНЭГТ 3.3. ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨРӨЛ	ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ САЛБАР ТӨЛӨВЛӨГӨӨ	ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ БҮРЭЛДЭХҮҮН	ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛАХ ЭЗЭН	ТӨЛӨВЛӨГӨӨГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	ТӨЛӨВЛӨГӨӨНД ХЯНАЛТ ТАВИХ
Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө	Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Бүрэлдэхүүн: <ul style="list-style-type: none"> ➤ Онцгой байдлын байгууллага ➤ Засаг даргын Тамгын газар ➤ Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги ➤ Хуулийн этгээд ➤ Сайн дурын хэсэг ➤ Иргэний төлөөлөл 	Засаг дарга	Орон нутгийн төсөв	Иргэдийн төлөөлөгчдийн хурал Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл
Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөө		Гамшгаас хамгаалах албаны даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг Бүрэлдэхүүн: <ul style="list-style-type: none"> ➤ Онцгой байдлын байгууллага ➤ мэргэжлийн анги ➤ Хуулийн этгээд ➤ Сайн дурын хэсэг ➤ Иргэний төлөөлөл 	Гамшгаас хамгаалах албаны дарга	Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц	Онцгой комисс
Байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө	Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө	Байгууллагын удирдлагын шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг Бүрэлдэхүүн: <ul style="list-style-type: none"> ➤ Байгууллагын бүтцийн нэгжийн төлөөлөл 	Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн дарга, удирдлага	Байгууллагын төсөв, үйл ажиллагааны зардал	Онцгой байдлын байгууллага

Орон нутгийн Засаг дарга Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний салбар төлөвлөгөө болох Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан тайлагнана.

ЗУРАГ 3.1. ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА, БОЛОВСРУУЛАХ АСУУДАЛ

1

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ ХЭСЭГТ:

- Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зорилго
- Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад баримтлах зарчим
- Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хамрах хүрээ, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцох холбогдох талууд, тэдгээрийн чиг үүрэг

ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДАЛ, ХҮЧ ХЭРЭГСЛИЙН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХОР УРШГИЙН АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭГ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ, САЙЖРУУЛАН БАРЬЖ БАЙГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

- Гамшгаас хамгаалах бэлэн байдал, хүч хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлэх, хор уршгийн арилгах арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах
- Сэргээн босгох арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, сайжруулан барьж байгуулах

2

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАНИЛЦУУЛГА

ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА ХЭСЭГТ:

- Нутаг дэвсгэр, газар зүй, байгаль, цаг уурын мэдээлэл
- Хүн ам зүй, нийгэм, эдийн засгийн үзүүлэлт
- Дэд бүтцийн мэдээлэл

ТӨЛӨВЛӨГӨӨ ХЭРЭГЖИХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО ХЭСЭГТ:

- Гамшгаас хамгаалах тогтолцооны зохион байгуулалтын схем
- Гамшгаас хамгаалах тогтолцоог бүрдүүлэгч талуудын гүйцэтгэх чиг үүрэг
- Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах талууд, тэдгээрийн хамтын ажиллагааны талаарх мэдээлэл

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХЭСЭГТ:

- Үнэлгээ хийсэн байгууллагын товч мэдээлэл
- Үнэлгээний зорилго
- Үнэлгээнд ашигласан арга, аргачлал
- Үнэлгээнд авч үзсэн гамшгийн төрөл тус бүрээр аюул, өртөх байдал, эмзэг байдал, чадавхын үнэлгээ, үүсгэсэн цагийн байдал, хохирлын таамаглал эрсдэлийн түвшин, эрсдэлийн зураг
- Гамшгийн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт
- Гамшгийн эрсдэлийн төрөл тус бүрээр боловсруулсан эрсдэлийг бууруулах зөвлөмж

3

ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ГАМШГИЙН ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- Эрх зүйн болон бодлогын хэрэгжилтийг орон нутгийн түвшинд хангах
- Гамшгийн эрсдэлийг ойлгох, болзошгүй гамшгийн эрсдэлийг тодорхойлох, үнэлэх
- Гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүгийн механизмыг хөгжүүлэх

ОРОН НУТАГТ ГАМШГИЙГ ДАВАН ТУУЛАХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

- Хот суурин газрыг гамшгийг тэсвэрлэх чадавхтай байдлаар төлөвлөх, хөгжүүлэх
- Хүрээлэн буй орчныг хамгаалах, экосистемийг сайжруулах
- Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа зохион байгуулах, холбогдох талууд, иргэд, олон нийтийн чадавхыг бэхжүүлэх
- Дэд бүтцийн гамшгийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХЭСЭГТ:

- Үнэлгээ хийсэн байгууллагын товч мэдээлэл
- Үнэлгээний зорилго
- Үнэлгээнд ашигласан арга, аргачлал
- Үнэлгээнд авч үзсэн гамшгийн төрөл тус бүрээр аюул, өртөх байдал, эмзэг байдал, чадавхын үнэлгээ, үүсгэсэн цагийн байдал, хохирлын таамаглал эрсдэлийн түвшин, эрсдэлийн зураг
- Гамшгийн эрсдэлийн үнэлгээний дүгнэлт
- Гамшгийн эрсдэлийн төрөл тус бүрээр боловсруулсан эрсдэлийг бууруулах зөвлөмж

4

ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ, ХАВСРАЛТЫГ БОЛОВСРУУЛАХ

ЭРЭН ХАЙХ, АВРАХ, ХОР УРШГИЙГ АРИЛГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Зарлан мэдээлэл дамжуулах арга хэлбэр
- Гамшгийн дараах хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх хүч хэрэгслийн хуваарилалт
- Мэдээ, мэдээллийг цуглуулах, удирдлагыг мэдээллээр хангах зохион байгуулалт
- Ар тал хангалтын зохион байгуулалт

ГАМШГААС ХАМГААЛАХ ДАЙЧИЛГАА ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Дайчлах хүч хэрэгслийн нэр төрөл, байршил
- Дайчилгаа явуулах удирдлага, зохион байгуулалт
- Хүч хэрэгслийг бүртгэх, байршуулах зохицуулалт

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Нүүлгэн шилжүүлэх шийдвэр гаргах зохицуулалт
- Нүүлгэн шилжүүлэх тухай зарлан мэдээллийг хүргэх шийдэл
- Нүүлгэн шилжүүлэлтэд оролцогч талуудын ажлын тусгай горимын зохицуулалт
- Хэв журам, аюулгүй байдлыг хангах асуудал
- Аюулгүй талбайн бүртгэл, зохион байгуулалт
- Ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн амыг нүүлгэн шилжүүлэх арга зам
- Нүүлгэн шилжүүлэлтийн үеийн хангалтын зохион байгуулалт
- Хоргодох байрны байршил, багтаамж, бүртгэл мэдээлэл, эрүүл мэндийн болон хоол хүнсний хангалт, байрны ариун цэвэр, аюулгүй байдал, хог хаягдлын зохион байгуулалт
- Нөөц байр, ус, цахилгаан, дулаанаар хангах шийдэл

СЭРГЭЭН БОСГОХ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Гамшгийн дараах хэрэгцээ, хохирлын үнэлгээ хийх хүч хэрэгслийн хуваарилалт
- Хүний анхдагч хэрэгцээ (орон байр, ундны ус, хоол хүнс, дулаан хувцас, эм, харилцаа холбоо, цахилгаан дулаан, нэн шаардлагатай нийгмийн үйлчилгээ)-г хангах зохион байгуулалт
- Гамшгийн улмаас учирсан хохирлыг арилгах, нөхөн барагдуулах шийдэл
- Дэд бүтцийн хэвийн ажиллагааг хангах

ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙГ ЗОХИЦУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

- Хүмүүнлэгийн тусламжийн хэрэгцээг тогтоох
- Хүмүүнлэгийн тусламжийг хүсэх, хүлээн авах, хадгалах, хуваарилах, тээвэрлэх зохион байгуулалт

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТ

ТУШААЛ ШИЙДВЭР ЗАХИРАМЖЛАЛЫН БАРИМТ БИЧИГ, ГЭРЭЭ:

- Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, штабыг байгуулсан шийдвэр
- Хамтран ажиллах талуудтай хийсэн гэрээний эх хувь
- Удирдлагын шийдвэр гаргах захирамжлалын баримт бичгийн төсөл

ХОЛБОО ЗАРЛАН МЭДЭЭЛЭЛ:

- Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд томилгоожсон холбогдох талуудтай холбоо барих хаяг, утас
- Зарлан мэдээллийг дамжуулах бүдүүвч
- Зарлан мэдээллийн дуут дохионы техник хэрэгслийн байршил
- Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд удирдах бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг

ХҮЧ ХЭРЭГСЭЛ, НӨӨЦИЙН СУДАЛГАА:

- Гамшгийг хор уршгийг арилгах ажиллагаанд оролцох томилгоот хүч хэрэгслийн мэдээлэл
- Нүүлгэн шилжүүлэх үед ашиглах бүх төрлийн нөөцийн судалгаа

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН СУДАЛГАА:

- Онц чухал объектын судалгаа
- Галын аюултай болон бусад

ЗУРАГ, ЗУРАГЛАЛ:

- Удирдлагын шийдвэрийн зураг
- Байр зүйн зураг
- Аврах үйл ажиллагааны бүдүүвч, план зураг

3.4. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ, ТУРШЛАГА

Төлөвлөгөө батлагдсанаас хойш төлөвлөгөөнд шууд болон шууд бусаар оролцох талуудад төлөвлөгөөний зорилго, ач холбогдол, оролцох чиг үүргийн талаар мэдээлэл хүргэх, мэдээллээр хангах, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцох холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөллийг чадавхжуулахад анхаарах шаардлагатай. Аливаа зорилтот үйл ажиллагааг үр дүнтэй явуулах гэдэг нь төлөвлөсөн арга хэмжээг цаг хугацаанд нь багтааж, өгөгдсөн нөөцийг ашиглан хэрэгжүүлэх явдал юм.

Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө амжилттай хэрэгжихэд нөлөөлдөг гол хүчин зүйл чухал нь:

- Гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилт
- Дээд удирдлагын манлайлал
- Гамшгийн эрсдэлийг бууруулах нөлөөллийн арга хэмжээ юм.




ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ САНХҮҮЖИЛТ

Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрхэн санхүүжүүлэх талаарх ойлголттой болж үйл ажиллагаагаа нийцүүлэх нь ирээдүйн үр ашигтай хөрөнгө оруулалтын нэг алхам юм.

Гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтийн байж болох эх үүсвэрийг олон улсын болон үндэсний бодлого, эрх зүйн баримт бичигт дараах байдлаар тодорхойлж өгсөн байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт гамшгийн эрсдэлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх арга зам дараах байдлаар тусгагдсан байдаг.

ЗУРАГ 3.2. СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ БАРИМТ БИЧИГТ
ТУСГАГДСАН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН САНХҮҮЖИЛТИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ



Дээрх зурагт үзүүлснээр олон улсын хэмжээнд Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн үзэл санаа, зарчимд үндэслэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх олон арга зам байдаг бөгөөд хөгжлийн, хүмүүнлэгийн тусламжийн, уур амьсгалын өөрчлөлт эсвэл гэнэтийн аюулт үзэгдэл тохиолдсон үед гаргах зорилготой санхүүгийн эх үүсвэрүүд байдаг. Мөн эрсдэлийг

шилжүүлэх даатгал, нөхөн төлбөр олголт, гамшгаас хамгаалах арга хэмжээний хөрөнгө оруулалт, татвараар дэмжих бодлого, гамшгийн дараах олон улсын хандив зэрэг эрсдэлийг хуваалцах, багасгах арга зам байдаг. Түүнчлэн гамшгийн эрсдэлийн сан, Засгийн газрын төсөв, төсвийг шилжүүлэх механизм, хөрөнгийн зээлийн сан, лизинг зэрэг арга хэрэгслүүд байна.

Зарим улс оронд үндэсний хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах бие даасан санхүүжүүлэх механизмтай байдаг. Жишээлбэл, гамшгийн бэлэн байдлыг дээшлүүлэх сан, сэргээн засварлах эсвэл уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаанд зориулсан сан байна. Зарим улс оронд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны санхүүжилт нь улсын төсвөөс гол яамдын шугамаар хөрөнгө оруулалт хийх замаар шийдвэрлэдэг. Гэхдээ эдгээр гол яамдын санхүүжилт, хөрөнгө оруулалт нь хөгжлийн урт хугацааны төсөл, хөтөлбөрийн нэг хэсэг болж, нийгмийн суурь үйлчилгээг дэмжих нөхцөлтэй байдгийн хувьд эрсдэлийг бууруулахад нөөц, хүчин чармайлт шаардсан далайц ихтэй ажил болдог. Энэхүү төрийн бодлого зохицуулалт нь гамшгийн эрсдэлийг бууруулах үндсэн гол үйл ажиллагаанд чиглэгдсэн байх бөгөөд улсын төсвөөс гадна хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татаж чаддаг давуу талтай.

ХҮСНЭГТ 3.4.УЛСЫН ТӨСВӨӨС ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОМЖ

ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВТ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТУСГАХ	УЛСЫН ТӨСӨВ ЭСВЭЛ ТУСГАЙ САНГААС ГАРГАХ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ САНХҮҮЖИЛТ	ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ УЯЛДУУЛЖ САНХҮҮЖҮҮЛЭХ
Зарлан мэдээллийн системийг бэхжүүлэх	Гамшгаас хамгаалах албыг бэхжүүлэх	Газар ашиглалтын төлөвлөлт
Уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн эрсдэлийн хяналт мониторинг сайжруулах	Зарлан мэдээллийн системийг боловсронгуй болгох	Дэд бүтэц, нийтийн тээвэр
Нүүлгэн шилжүүлэх хүлээн авах байр байгуулах	Уур амьсгалын өөрчлөлт болон гамшгийн эрсдэлийн хяналт мониторингийг сайжруулах	Усны нөөцийн төлөвлөлт ба дэд бүтэц
Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр ба үйл ажиллагааны төлөвлөгөө	Аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийн үнэлгээ	Эрсдэлийн мэдрэмжтэй нийгмийн хамгаалал
Гамшгийн эрсдэлийн үнэлгээ	эрсдэлийг бууруулах бүтцийн арга хэмжээ	Үерийн далан суваг барих зэрэг эрсдэлийг бууруулах бүтцийн арга хэмжээ
Гамшгийн хор уршгийг арилгах арга хэмжээ		Байгаль орчныг хамгаалах
Гамшгийн нөөц бүрдүүлэлт		Биологийн төрөл зүйлийг хамгаалах
Хямралын үеийн эрсдэлийн даатгал		
Бичил даатгал ¹⁴		

(Эх сурвалж: Charlene Watson et al, Finance for reducing disaster risk: 10 things to know, 2015)

¹⁴ Бага орлоготой, ядуу иргэд, бичил бизнес эрхлэгдэд зориулан боловсруулсан даатгалын бүтээгдэхүүн бөгөөд хураамж шимтгэлийн хувьд харьцангуй хямд, өндөр олговортой даатгал.

Манай улс гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтийн эх үүсвэрийг хүснэгт 3.5-д үзүүлсэн хэлбэрээр хууль тогтоомжид тодорхойлж өгсөн байдаг.

ХҮСНЭГТ 3.5. ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ	САНХҮҮЖҮҮЛЭХ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ХОЛБОГДОХ ЗҮЙЛ, ЗААЛТ
<p>ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана (51.1); ➤ Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, сум, нийслэл, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна (51.2); <p>ҮНДЭСНИЙ БОЛОН ОРОН НУТГИЙН ЗӨВЛӨЛ: Монгол Улсын холбогдох хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийн зорилт болон шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгуулах талаар бодлогын зөвлөмж өгөх (27.1.1)</p> <p>ГАМШГААС ХАМГААЛАХ АЛБА: Салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах (33.1.1)</p>
<p>ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ</p>	<p>БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН САН:</p> <ul style="list-style-type: none"> ➤ байгалийн гамшигт үзэгдлээс учирч болох эрсдэлийг бууруулах чиглэлээр олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, танин мэдэхүйн үйл ажиллагааг дэмжих (7.3.11) <p>ЗАСГИЙН ГАЗРЫН НӨӨЦ САН:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Засгийн газрын нөөц сан нь тухайн жилийн төсөвт урьдчилан тооцож, төлөвлөн тусгах боломжгүй, хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээ болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.8-д заасан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, 4.1.15-д заасан гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулах зорилгоор улс, орон нутгийн төсвийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлын хүрэлцэхгүй хэсгийг санхүүжүүлэх зориулалттай байна (11.1.) <p>ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САН:</p> <ul style="list-style-type: none"> ➤ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх (19.3.2); ➤ орчны эрүүл мэндийг хамгаалах (19.3.3.) <p>ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ САН:</p> <ul style="list-style-type: none"> ➤ бэлчээрийн даацыг тодорхойлох, мал оторлон өвөлжүүлэхтэй холбогдсон судалгаа явуулах (21.3.5); ➤ худаг сэргээн засварлах, уст цэг шинээр гаргах (21.3.6.); ➤

Хүснэгт 3.5-өөс гадна олон улсад гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтийн дараах эх үүсвэрүүдийг ашиглаж байна. Үүнд:

- Гамшгийг даван туулах чадавхыг бий болгох урт хугацааны бонд
- Хөгжлийн бодлогын зээл
- Орон нутгийн хөгжлийн сан
- Гамшгийн эрсдэлийн даатгал
- Олон улсын санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн санхүүжилт.

Санхүүжилтийн эдгээр эх үүсвэрүүдээс хэрхэн хамгийн тохиромжтойг нь сонгох вэ гэдэг асуудал тулгардаг. Энэхүү асуудлыг шийдвэрлэхдээ гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа болон гамшгийн эрсдэлийн цар хүрээндээ нь хамааруулан дараах зурагт үзүүлсэн байдлаар сонгох боломжтой.

ЗУРАГ 3.3. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ЦАР ХҮРЭЭ, САНХҮҮЖИЛТИЙН ХАМААРАЛ



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ МАНЛАЙЛАЛ

Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд дээд удирдлагын манлайлал маш чухал үүрэг гүйцэтгэнэ. Дээд удирдлага хүчтэй санаачилга, манлайлалтай байх нь аливаа хийж хэрэгжүүлэх ажлаараа оролцогч талууддаа хүлээн зөвшөөрөгдөх, олон нийтийн дунд үнэлэмж дээшлэх, улмаар эрхэлсэн асуудал нь бүх түвшинд амжилттай хэрэгжих, олон нийтийг сэдэлжүүлэх, оролцоог нэмэгдүүлэхэд ач холбогдолтой.

Дээд удирдлагын манлайлал гэдэг нь тодорхой зорилтуудыг хангахын тулд манлайлагчийн зүгээс бусад бүрэлдэхүүний үйл ажиллагаанд нөлөөлөх үйлдэл юм.

Гамшгийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд тухайн бүтэц (Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, Гамшгаас хамгаалах улсын албад)-ийн дээд удирдлагын манлайлал нь онцгой чухал үүрэгтэй бөгөөд дараах үйлдлүүдийн тусламжтайгаар манлайллыг хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

- 1) **ОЙЛГОЛТ, ДЭМЖЛЭГ**
- 2) **УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**
- 3) **ОРОЛЦОО**
- 4) **ШИЙДВЭР**

1. ОЙЛГОЛТ, ДЭМЖЛЭГ:	
<p>Дээд удирдлага нь гамшгийн эрсдэлийн удирдлага, түүнийг хэрэгжүүлэхийн ач холбогдол, үр ашгийн талаар сайн ойлголттой байх. Ингэснээр гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нэвтрэх гол хөдөлгөгч хүч болно. Үүнээс гадна эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа ажил, арга хэмжээг дэмжин урамшуулдаг механизмтай байх нь эрсдэлийн удирдлагын үйл явцын тасралтгүй ажиллагаанд эергээр нөлөөлдөг.</p>	<p> ОЙЛГОЛТ: Улс, аймаг, нийслэл, дүүрэг болон хариуцсан салбарын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрхэн удирдан, зохион байгуулах талаар судлах.</p> <p> АЛИВАА АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ: Улс, аймаг, нийслэл, сум, дүүрэг болон хариуцсан салбарын хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын болон үндэсний бодлого, стратеги, Гамшгаас хамгаалах тухай хууль, холбогдох журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, эрсдэлийн удирдлагын дадал, хэвшил, хандлагыг төлөвшүүлэх гэх мэт.</p>
2. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:	
<p>Эрсдэлийн хяналт, удирдлагын тогтолцоог бүрдүүлсэн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.</p>	<p> УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ НЬ: Зөвлөл, албаны бүрэлдэхүүнийг томилгоожуулах, чиг үүргийг хуваарилах, тэдгээрийн сургалт, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, холбогдох дүрэм журмаа шинэчлэн нэмэлт өөрчлөлт оруулан батлан мөрдүүлэх гэх мэт юм. Бүтцээ тодотгосны дараа бие бүрэлдэхүүн бүрийг үүрэгжүүлнэ.</p>
3. ОРОЛЦОО:	
<p>Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хянах, зохицуулах, чиглүүлэх зэрэг үйл ажиллагаанд дээд удирдлагын зүгээс оролцох.</p>	<p> ДЭЭД УДИРДЛАГА: дээрх бүх үйл ажиллагаанд өөрийн биеэр 1 ба түүнээс дээш удаа оролцох</p>
4. ШИЙДВЭР:	
<p>Гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой аливаа арга хэмжээг авч хэлэлцэж, хэрэгжихүйц тодорхой шийдвэр гаргаж мөрдүүлдэг байхаас гадна шийдвэрийн оновчлол, үр ашгийг тооцдог байх.</p>	<p> ТОДОРХОЙ ШИЙДВЭР: Зөвлөл, хариуцсан салбарын үйл ажиллагаа болон гамшгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо хоорондын уялдааг хангах, эрсдэлийг удирдахад шаардлагатай хөрөнгө, санхүүжилтийг нэн тэргүүнд шийдэх, холбогдох бүрэлдэхүүнийг сурган бэлтгэх, энэ чиглэлээр идэвх зүтгэлтэй ажиллаж буй ажилтан, алба хаагчдыг урамшуулах механизм бий болгох, гэх мэт.</p>

МАНЛАЙЛАГЧ-ТӨРИЙН ТҮШЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2017 онд Монгол Улсын Шадар сайд буюу Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайд байх үедээ НҮБ-аас “Манлайлагч-Төрийн түшээ”-ээр өргөмжлөгдсөн байна.



НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах “МАНЛАЙЛАГЧ -ТӨРИЙН ТҮШЭЭ” өргөмжлөл нь гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр тухайн бүс нутагтаа болон дэлхийн хэмжээнд манлайллаа үзүүлэн ажиллаж буй удирдагчдад хүртээдэг эрхэм шагнал юм. Энэхүү шагналыг 2017 онд Мексикийн Холбооны улсын Канкун хотноо зохион байгуулсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн хөтөлбөрийн Ү чуулганы үеэр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Тусгай төлөөлөгч Роберт Глассер Монгол Улсын Шадар сайд У. Хүрэлсүх (одоогийн Монгол Улсын Ерөнхийлөгч)-д гардуулсан.

НҮБ-аас Монгол Улсын Шадар сайдад гамшгаас хамгаалах хууль эрх зүй, бодлогын шинэчлэл хийж гамшгийн эрсдэлийг бууруулах засаглалыг бэхжүүлэх чиглэлээр манлайлал, нөлөөллөө үзүүлэн, олон улсын байгууллага, дэлхийн бусад улс орнуудтай нягт хамтарч ажиллаж, Азийн бүс нутаг төдийгүй дэлхийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах үйлст оруулсан хувь нэмэр, удирдах чадвар, арга барил, ажлын туршлагыг үнэлж тус шагналыг олгож байгааг онцолжээ.

НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах “Манлайлагч-Төрийн түшээ” өргөмжлөлийг Монгол Улсаас хүртсэн нь олон улсын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах засаглалыг бэхжүүлэх үйл ажиллагаанд манай улсын оруулж буй хувь нэмрийг үнэлсэн явдал билээ.




Эх сурвалж: “Дэлхий түүнийг үнэлж “Манлайлагч-Төрийн түшээ”-гээр өргөмжилжээ. 2017 он, <http://www.mglnews.mn/>; <https://nema.gov.mn/>; <https://www.undr.org/news/mongolias-deputy-pm-honoured-asia-drr-champion>

3.5. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД НӨЛӨӨЛЛИЙН АРГЫГ АШИГЛАХ

Үндэсний болон аймаг, нийслэл, сум, дүүрэг, хариуцсан салбарын түвшинд гамшгийн хохирлыг бодитой бууруулах, гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэхэд оролцогч талуудад чиглэсэн, тэдний оролцоог хангасан үйл ажиллагаа ач холбогдолтой болохыг олон улсын туршлага харуулдаг. Иймд тэдгээр талуудад чиглэсэн нөлөөллийн ажил явуулах нь чухал ач холбогдолтой.

НӨЛӨӨЛӨЛ НЬ гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, үзэл баримтлалыг таниулах, ил тод гарган ярих, оролцогчдын анхаарлыг хандуулах, шийдвэр гаргагч нарыг тухайн асуудлыг шийдвэрлэх алхам руу чиглүүлэх, хүмүүсийн ойлголт, зан үйл, асуудалд хандах хандлагыг өөрчлөх, чадваржуулахад чиглэсэн үйл ажиллагаа юм. Үүнийг удирдлага, бүрэлдэхүүн, хувь хүний зүгээс хийж болно. Нөлөөллийн ажлын хамрах үйл ажиллагааг хүснэгт 3.7-д үзүүлэв.

ХҮСНЭГТ 3.7. НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ХАМРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА


<p>НӨЛӨӨЛӨЛ НЬ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, СТРАТЕГИЙГ ӨРГӨН МЭДҮҮЛЭХ, ХАМГААЛАХ ЭСВЭЛ ШИЙДВЭР ГАРГАГЧ НАРТ ТАНИН МЭДҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЮМ.</p>	<p>ЗУРГААР ИЛЭРХИЙЛСЭН БАЙДАЛ</p>
<p>Нөлөөлөл гэдэг бол асуудлыг ил тод зоригтой гарган ярих, чухал асуудалд хүмүүсийн анхаарлыг хандуулах, шийдвэр гаргагч нарыг тухайн асуудлыг шийдвэрлэх алхам руу чиглүүлэх үйл ажиллагаа юм.</p>	
<p>Нөлөөлөл гэдэг нь нөхцөл байдлыг эергээр өөрчлөхийн тулд бусад хүмүүс, байгууллагуудтай холбоо сүлжээ тогтоож, хамтран ажиллана гэсэн үг юм.</p>	
<p>Нөлөөлөл гэдэг нь хувь хүмүүсийн хооронд болон мэдээллийн хэрэгслээр тодорхой зорилготой мэдээллийг дамжуулах үйл ажиллагаа юм.</p>	
<p>Нөлөөлөл нь хүмүүсийн ойлголт, зан үйл, асуудалд хандах хандлагыг өөрчлөхөд чиглэсэн үйл ажиллагаа юм.</p>	
<p>Нөлөөлөл нь бүлгийн гишүүдийг өөрсдийгөө төлөөлөхөд нь тусалж, дэмжих, чадваржуулах үйл ажиллагаа юм.</p>	

Дээрх хүснэгтэд үзүүлсэн нөлөөллийн үйл ажиллагаануудаас зөвлөл, албадын хувьд дараах нөлөөллийн ажил голлох үүрэгтэй байна. Үүнд:

- Удирдлага, шийдвэр гаргагчид нөлөөлөх;
- Олон улсын байгууллага, хандив тусламжийн байгууллагад нөлөөлөх;
- Олон нийтэд нөлөөлөх болно.

Нөлөөллийн ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дараах 7 алхмыг баримтлах шаардлагатай.

ЗУРАГ 3.4. НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ЦИКЛ



ХҮСНЭГТ 3.8. НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН АНХААРАХ АСУУДАЛ

АЛХАМ		АНХААРАХ АСУУДАЛ
1	НӨЛӨӨЛӨЛ ҮЗҮҮЛЭХ АСУУДЛАА ТОДОРХОЙЛОХ 	<ul style="list-style-type: none"> ➤ ГЭБ арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг бүрэн шийдвэрлэж чадахгүй байгаа шалтгаан нь юу вэ? ➤ Асуудлыг шийдвэрлэхэд хэн илүү үүрэг, хариуцлага хүлээх вэ? ➤ Асуудлыг шийдэх боломжтой ямар шийдвэр, үйл ажиллагаа байна вэ? ➤ Орон нутгийн асуудлыг үндэсний, цаашилбал олон улсын асуудлуудтай холбох уу? ➤ Хөрөнгө бүрдүүлэх боломж олдох уу? ➤ Эдгээр шийдвэр, үйл ажиллагаанууд хүн амд хэрхэн нөлөөлөх вэ?
2	БАРИМТ, НОТӨЛГӨӨ ЦУГЛУУЛАХ	<ul style="list-style-type: none"> ➤ Сүүлийн үеийн шинэчлэгдсэн судалгаа мөн үү? ➤ Холбогдох судалгаа, эрсдэлийн үнэлгээний үр дүн, гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөмж тодорхой байна уу? ➤ Хэрхэн шинжилж, боловсруулах вэ?
3	ЗОРИЛГО, ЗОРИЛТОО ТОДОРХОЙЛОХ	<ul style="list-style-type: none"> ➤ Бид юуг өөрчлөхийг хүсэж байна вэ? Ямар аргаар? ➤ Ямар асуудлаас эхлэх нь зүйтэй вэ? ➤ Энэ нь чухал асуудал мөн үү? ➤ Энэ асуудлаар нөлөөллийн ажил явуулах бодит боломж байна уу?
4	ЗОРИЛТОТ БҮЛЭГ, СОНИРХОГЧ ТАЛУУДЫГ ТОДОРХОЙЛОХ	<ul style="list-style-type: none"> ➤ Хэний төлөө өөрчлөлт хийх вэ? ➤ Шийдвэр гаргагчид ба шахалт үзүүлэгчид, болон дэмжигчид ба эсэргүүцэгчдийг хэрхэн тодорхойлох вэ?
5	НӨЛӨӨЛЛИЙН СТРАТЕГИ, ТАКТИКАА СОНГОХ	<ul style="list-style-type: none"> ➤ Хамтрах, олон нийтэд чиглэсэн компани ажил болон гамшгийн эрсдэлийг бууруулах стратеги ба тактикуудаас алийг нь сонгох вэ?
6	ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ	<ul style="list-style-type: none"> ➤ Хэн, юуг, хэзээ хийх вэ? ➤ Нөлөөллийн үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах вэ? ➤ Ямар нөөцөд тулгуурлан хэрэгжүүлэх вэ?
7	ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ	<ul style="list-style-type: none"> ➤ Нөлөөллийн ажил нь зорилгоо биелүүлсэн үү? ➤ Ямар үр дүн, үр нөлөө гарсан бэ? ➤ Богино болон урт хугацаанд гарсан өөрчлөлтүүд юу вэ?



АЛХАМ 1. НӨЛӨӨЛӨЛ ХИЙХ АСУУДЛАА ТОДОРХОЙЛОХ

Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, арга хэмжээнээс нөлөөлөл хийх шаардлагатайг нь тодорхойлно. Тухайлбал, төлөвлөгөөнд тусгагдсан зарим үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бодлого шийдвэрт нөлөөлөх шаардлага бий болдог. Мөн түүнчлэн хэрэгжилтэд хяналт тавих нь орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулж, ард иргэдийн аюулгүй байдлыг хангахад томоохон хувь нэмэр болно. Иймээс талууд гамшгийн эрсдэлийг бууруулах

төлөвлөгөөг хэрхэн ажил хэрэг болгож хэрэгжүүлэх тал дээр хамтдаа хэлэлцэж нөлөөлөл шаардлагатай үйл ажиллагаа, арга хэмжээг тодорхойлно.

Жишээлбэл дараах арга хэмжээ хамрах боломжтой. Үүнд:

- Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг зохицуулах бодлого, эрх зүйн орчныг орон нутагт нутагшуулах, бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах, одоо байгаа бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг сайжруулах;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хамтын ажиллагааны сүлжээ бий болгож, хамтран ажиллах;
- Гамшгийн эрсдэл, эрсдэлийг бууруулах арга хэмжээний талаар зөвлөл, албадын бүрэлдэхүүний ойлголт мэдлэгийг дээшлүүлэх;
- Гамшгийн эрсдэлийн үр дагавар, тулгамдсан асуудалд олон нийтийн анхаарлыг татах;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд оролцож буй зөвлөл, салбарын бие бүрэлдэхүүн, олон нийтэд тусламж дэмжлэг үзүүлэх;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд оролцож буй зөвлөл, салбарын бие бүрэлдэхүүн, олон нийтийн эрхийг хамгаалах, тэдний нийгмийн оролцоог дээшлүүлэх;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд оролцож буй зөвлөл, салбарын бие бүрэлдэхүүн, олон нийтийг чадваржуулах;
- Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө нөөцийг төвлөрүүлэх, нэмэгдүүлэх;
- Газар хөдлөлийн нөлөөллийг бууруулахын тулд барилгын норм, стандартыг бий болгох, мөрдүүлэхэд Засгийн газарт бүхий л түвшинд нөлөөлөх;
- Үерийн аюулыг бууруулж гуу жалга, газрын доройтлоос урт хугацаандаа урьдчилан сэргийлэхэд чиглэсэн газрын менежмент, төлөвлөлтийг сайжруулахад нөлөөлөх;
- Үерийн аюулыг нэмэгдүүлэхүйц газар байрласан, мөн үерийн үед хүрч очих боломжгүй зам, гүүр гэх мэт дэд бүтцийн тохиромжгүй байршил, зохисгүй загвар, зураг төслийн эсрэг нөлөөллийн ажил хийх;
- Гамшгийн үеийн хоргодох байрыг байгуулах, эмнэлэг, сургуулиудыг гамшигт илүү тэсвэртэй байдлаар хүчитгэх талаар шийдвэр гаргагчдад нөлөөлөх;
- Холбогдох яам болон газар, хэлтсийн зөвлөлдөх уулзалт, ажлын хэсэгт хүүхэд, залуучуудын төлөөллийг оруулахад нөлөөлөх;
- Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг эмзэг бүлгийнхэнд гамшгийн хариу арга хэмжээ, яаралтай тусламжийг хүртээмжтэйгээр хүргэхэд ТББ-уудад нөлөөлөх.

Гамшгийн эрсдэлийг бууруулах гол асуудлуудаа тодорхойлсны дараа дараах асуултын дагуу тайлбараа хийнэ. Энэ нь 6 дугаар алхам буюу Нөлөөллийн ажлын төлөвлөгөө боловсруулахад тусална.

ХҮСНЭГТ 3.9. НӨЛӨӨЛӨЛ ҮЗҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ ГОЛ АРГА ХЭМЖЭЭ

НӨЛӨӨЛӨЛ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ГЭБ АРГА ХЭМЖЭЭ	ТАВИГДАХ ШАЛГУУР АСУУЛТ	ТАЙЛБАР
1. 2. 3. ...	Яагаад заавал эдгээр асуудлуудаар нөлөөлөл хийх шаардлагатай вэ?	
	Яагаад энэ асуудлуудыг чухал гэж үзэж сонгосон бэ?	
	Энэ шийдвэрийг гаргахад ямар эх үүсвэрийг ашигласан бэ?	



АЛХАМ 2. БАРИМТ НОТЛОГОО ЦУГЛУУЛАХ

Асуудлаа маш сайн ойлгох нь сайн нөлөөлөл явуулахын үндэс суурь юм. Иймээс нөлөөлөл үзүүлэх асуудлын хүрээний судалгааг сайтар хийсэн байх шаардлагатай бөгөөд энэ нь асуудлыг хөндөж, шийдвэрлүүлэхэд танд шаардлагатай баталгаа, нотолгоог гаргаж өгөх болно. Хүснэгт 3.10-д баримт нотолгоо цуглуулах боломжтой эх сурвалжийн жишээ, судлах зүйл, анхаарах асуудлыг үзүүлэв.


ХҮСНЭГТ 3.10. НӨЛӨӨЛӨЛ ҮЗҮҮЛЭХ АСУУДЛЫН ТАЛААРХ БАРИМТ НОТЛОГООГ ЦУГЛУУЛАХ БОЛОМЖТОЙ ЭХ СУРВАЛЖ

БАРИМТ НОТЛОГОО ЦУГЛУУЛАХ ЭХ СУРВАЛЖ	СУДЛАХ ЗҮЙЛ	АНХААРАХ АСУУЛТУУД
<ul style="list-style-type: none"> ➢ Хэрэгцээг тодорхойлох үнэлгээ ➢ Гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүн, мэдээлэл ➢ НҮБ, Дэлхийн Банк, Засгийн газар, ТББ гэх мэт байгууллагуудын Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээний дагуу гаргасан тайлангууд ➢ Эрдэм шинжилгээний судалгаануудын үр дүн ➢ Орон нутагт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагууд нийгмийн хариуцлагын хүрээнд хийж гүйцэтгэж буй ажил, үйлчилгээ ➢ Бусад мэдээлэл авч болохуйц эх 	<ul style="list-style-type: none"> ➢ Гамшгийн эрсдэлийг бууруулах судалгаануудын хувьд орон нутаг, бүс нутаг, улс оронд тохиолдож буй эрсдэлүүд, эдгээр нь хүмүүст, эмзэг бүлгийнхэнд хэрхэн нөлөөлж болох ➢ Гамшгаас хамгаалах хууль, гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө эсвэл засгийн газрын бусад журам, тогтоолууд байгаа эсэх, эдгээр нь бүрэн хэрэгжиж байна уу, илүү үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэл байна уу ➢ Улс төрчид, албан тушаалтуудын зүгээс гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлийг дэмжиж байгаа эсэх 	<ul style="list-style-type: none"> ➢ Ижил төстэй үйл ажиллагаатай байгууллагуудыг тогтоох, хамтрах /ингэснээр нөөцөө хуваалцах, нөлөөллийн компаниг ажлынхаа далайцыг нэмэгдүүлж илүү үр дүнд хүрэх боломж бий болно/ ➢ Гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлийн хууль эрх зүйн баримт бичгүүдэд эмгэгтэйчүүд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй

сурвалжууд болон бодит туршлагауд	➤ Залуучууд эсвэл орон нутаг, иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг удирдах, дэмжих талаарх заалтууд байна уу	хүмүүс, үндэстний цөөнх гэх мэт зорилтот бүлгийн хэрэгцээг тусгасан уу?
-----------------------------------	--	---

Хүснэгт 3.10-ыг ашиглан нөлөөлөл үзүүлэх шаардлагатай асуудлуудаа тодорхойлсон бол одоо гол асуудаа тодорхойлох хэрэгтэй болно. Үүний тулд “Асуудлын мод”-ыг “Зорилгын мод” болгон хувиргах замаар ерөнхий зорилгоо тодорхойлж болно. Зураг 3.5-д “Асуудлын мод”-ны загварыг үзүүлэв. Үүнийг сургалтын том цаасан дээр зурж болно.

ЗУРАГ 3.5. “АСУУДЛЫН МОД”-НЫ ЗАГВАР



- “АСУУДЛЫН МОД”-ны эх бие хэсэгт гол асуудлуудыг бичнэ. Энэ асуудал нь алхам 1-д тодорхойлсон эн тэргүүний асуудал гэж тодорхойлсон нэг асуудал байж болно.
- Зурсан модныхоо үндэс хэсэгт асуудлын шалтгаануудыг бичнэ. Дараа нь эдгээрийгээ зурсан модныхоо үндэс хэсэгт байрлуулна. Энэ нь гол асуудлыг хэлж өгөх ба энэ асуудал яагаад үүссэн бэ? Үүний шалтгаан нь юу вэ? гэсэн асуултад хариулж, үндэс суурь нь болсон шалтгааныг тодорхойлоход тусална
- Модныхоо мөчир бүрт гол асуудлаас үүсэх үр дагаврууд юу болохыг тодорхойлон бичнэ, Энэ нь үндсэн асуудлууд түүнээс үүсэх үр

дагавруудыг хэлж өгөх ба үүний тулд “үүний үр нөлөө юу вэ?” гэсэн асуултыг өөрсдөөсөө асуугаарай.

Асуудал бүрийг эерэг үр дүн болгон өөрчилснөөр үндсэн шалтгаан нь үндсэн шийдэл болж чадна. Жишээлбэл: Хэрэв гол асуудал нь усны ослын улмаас амиа алдагсдын тоо өндөр байсан ба үүний үндсэн шалтгаануудын нэг нь хүмүүсийн мэдээлэл, хандлагаас шалтгаалж байгаа бол үүнийг “Хүн амд сургалт, сурталчилгаа хийх” эерэг үр дүн болгож болно.



АЛХАМ 3. ЗОРИЛГОО ТОДОРХОЙЛОХ

Дээрх үр дүнгүүд дээр дүн шинжилгээ хийснээр нөлөөллийн ажлыг зохион байгуулагч нь нөлөөллийн ажлын зорилгоо тодорхойлох боломжтой болно. Энд “УХААЛАГ/SMART” дүн шинжилгээ хийх үйл явцаар дамжуулан нөлөөллийн ажилдаа дээд тал нь 3 зорилт тавих нь тохиромжтой. Үүний тулд дараах асуултуудын дагуу ямар өөрчлөлтийг бий болгохыг хүсэж байгаагаа тодорхойлно. Үүнд:

- **ОЙЛГОЛТЫН ӨӨРЧЛӨЛТ** – яриа, үг хэллэг, харилцан яриа, хэлэлцүүлгийн түвшинд гарч буй өөрчлөлт. Жишээ нь: орон нутгийн удирдагчид үг яриа, хэлэлцүүлэг, харилцан яриандаа гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохын ач холбогдлыг онцлон ярьж эхэлсэн.
- **ҮЙЛ ЯВЦЫН ӨӨРЧЛӨЛТ** – аливаа зүйлийг хийх арга замын өөрчлөлт. Жишээ нь: гамшгийн эрсдэлийг бууруулах талаарх төрийн бодлого/хууль тогтоомжийг бүх түвшний оролцогч талуудтай өргөн хүрээнд зөвлөлдөх замаар гаргадаг болсон.
- **ХАНДЛАГЫН ӨӨРЧЛӨЛТ** – бусад оролцогчид буюу тэдгээрийн үнэ цэнэ, шалтгаанд хандах хандлагын өөрчлөлт. Жишээ нь: орон нутгийн засаг захиргаа нь төрийн бус байгууллага болон орон нутгийн бүлгүүдийг гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр түнш гэж үзэж, тэднийг өрсөлдөгч гэж харах бус тэдэнтэй харин хамтран ажиллаж эхэлсэн.
- **АГУУЛГЫН ӨӨРЧЛӨЛТ** – стратеги, бодлогын баримт бичиг, төсөвт гарсан бодит өөрчлөлтүүд. Жишээ нь: үндэсний стратегид гамшгийн эрсдэлийг бууруулах болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэл тусгагдсан эсвэл гамшгийн эрсдэлийг бууруулах болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлийн үйл ажиллагаанд төсөв хуваарилагдсан.
- **ТӨЛӨВ БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТ:** хувь хүн болон байгууллагын үйлдэл, төлөв байдалд гарсан тогтвортой өөрчлөлт. Жишээ нь: аюул, гамшгийн эрсдэлийн хичээлийн хөтөлбөрт гамшгийн эрсдэлийг бууруулах агуулгыг оруулах замаар гамшгийн эрсдэлийг бууруулахад хандах хандлагын өөрчлөлтийг орон нутгийн түвшнээс үндэсний түвшинд хүртэл хийх.



АЛХАМ 4. ЗОРИЛТОТ БҮЛГЭЭ ТОДОРХОЙЛОХ

Нөлөөллийг зохион байгуулагчийн хувьд зорилтот бүлэг нь тухайн сонгосон асуудлын хүрээнд нөлөөлөхийг зорьж буй хувь хүн, байгууллага эсвэл засгийн газрын агентлагууд байж болно. Зорилт тус бүрийг хэрэгжүүлэхэд оролцох хүмүүсийг тодорхойлж, үүнээсээ хэн нь тухайн нөлөөлөл хийхээр сонгосон асуудлын хувьд гол тоглогчид болох, мөн тэд тухайн асуудлын хувьд ямар хамаарал, холбоотой болохыг тодорхойлох нь таны нөлөөллийн стратеги хэн рүү төвлөрч, чиглэхийг зааж өгнө. Мөн түүнчлэн дараа нь асуудалд холбоотой байх боломжтой талууд, эсвэл дэмжигчид, эсэргүүцэгчдийг тодорхойлох хэрэгтэй. Таны нөлөөллийн ажлын явцын дунд эдгээр нь гэхдээ өөрчлөгдөх магадлалтай юм.

Оролцогч талуудыг тодорхойлж, дүн шинжилгээг дараах байдлаар хийнэ. Үүнд:

1. Бүх оролцогч талуудыг тодорхойлох
2. Оролцогч талуудыг судлах, дүн шинжилгээ хийх
3. Үр дүнг эрэмбэлэх
4. Үр дүнд суурилан зорилтот бүлгээ сонгох

УХААЛАГ/SMART ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Дараах асуултуудын дагуу зорилго, зорилтууддаа дүн шинжилгээ хийгээрэй.

S	ТОДОРХОЙ: Та яг юуг өөрчлөхийг хүсч байна вэ? Таны үйл ажиллагаа хэнд чиглэж байна вэ?	
M	ХЭМЖИГДЭХҮЙЦ: Зорилгодоо хүрсэн эсэхийг яаж мэдэх вэ? Ямар үе шат ахиц дэвшлийг харуулах вэ?	
A	ХҮРЭХ БОЛОМЖТОЙ: Таны нөөц, бололцоо (хүний нөөц, бусад байгууллагуудтай хамтын ажиллагаа, хөрөнгө санхүү гэх мэт) тодорхой, бодитой юу? Улс төрийн нөхцөл байдал, соёлын нөхцөл байдлыг харгалзан үзвэл энэ нь хэр бодитой вэ? (Орон нутгийн удирдлага, төрийн байгууллагуудтай хэрхэн хамтрах вэ, хэр хариу үйлдэл үзүүлдэг вэ? гэх мэт)	
R	ХАМААРАЛТАЙ БАЙХ: Энэ нь таны ерөнхий зорилгод хувь нэмэр оруулж байна уу?	
T	ЦАГ ХУГАЦАА ТОДОРХОЙ БАЙХ: Хэр удаан үргэлжлэх вэ? Тодорхой хугацаа байна уу?	

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ ТОДОРХОЙЛОХ: нөлөөлөл үзүүлэх асуудлаар нөлөөллийн ажил хийхэд оролцох боломжтой талуудыг жагсаалтыг гаргана.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫГ СОНГОХДОО АНХААРАХ АСУУДАЛ:

- Тухайн нөлөөлөл үзүүлэхээр сонгосон асуудалд хэн хэн хамаарах вэ?
- Тухайн асуудалтай холбоотой үзүүлэх үйлчилгээг хэн хариуцдаг вэ?
- Тухайн асуудлын хүрээнд таны дэвшүүлсэн саналыг хэн дэмжиж, мөн хэн эсэргүүцэх магадлалтай вэ?
- Хэнийг оролцуулбал нөлөөллийн ажил илүү үр дүнтэй болж чадах вэ? Эсвэл эсрэгээрээ хэнийг оролцуулаагүйгээс болж үр дүн буурах магадлалтай вэ?
- Таны нөлөөллийн үйл ажиллагаанд санхүүгийн болон техник арга зүй, бусад нөөцийн дэмжлэгийг хэн үзүүлж чадах вэ?
- Таны нөлөөллийн мессежийг хэн дэмжих магадлалтай вэ?

Оролцогчдыг жагсаан бичихдээ холбоонууд, төрийн албан хаагчид, иргэний нийгэм, шууд болон шууд бус нөлөө бүхий хүмүүс, олон нийт, байгууллагууд, олон нийтийн удирдагчид, улс төрчид, ТББ-ын ажилтнууд гэх мэт төлөөллүүдийг бодолцоно.

Зорилтот бүлэг нь дараах хоёр төрлөөс бүрдэнэ. Үүнд:

ҮНДСЭН БҮЛЭГ	ХОЁРДОГЧ БҮЛЭГ
эдгээр нь шууд өөрчлөлт хийх эрх мэдэлтэй шийдвэр гаргагчид юм. Тухайлбал, Засгийн газрын гишүүн, агентлагийн удирдлагууд, орон нутгийн төрийн байгууллагын удирдах албан тушаалтнууд, УИХ-ын гишүүд, Засаг дарга, донор хандивлагчид гэх мэт.	эдгээр нь үндсэн бүлгийн шийдвэрт нөлөөлж чадах хүмүүс байна. Тухайлбал, зөвлөл, албадын гишүүд, мэргэжилтэн, хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллага, олон нийтэд нөлөө бүхий удирдагчид, багш нар, ТББ, судалгааны хүрээлэнгүүд, мэргэжлийн байгууллагууд эсвэл шийдвэр гаргагчдад мэдээлэл, зөвлөхүүд.

Үндсэн бүлэгт шууд хүрч чадахгүй байх тохиолдолд үр дүнтэй нөлөөллийн төлөвлөлт хийснээр шийдвэр гаргагчдад илүү их нөлөө үзүүлэх боломжтой хоёрдогч бүлэгт хүрч чадна.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ: Тухайн нөлөөлөл хийхээр сонгосон асуудлыг чухалд тооцдог, асуудалд нөлөөлөх эрх мэдэлтэй хүмүүс таны гол зорилтот бүлэг байх ёстой. Харин ямар ч нөлөөгүй, эсвэл асуудалд хандаж буй таны байр суурийг эсэргүүцэж байгаа хүмүүс зорилтот бүлэгт орох магадлал бага байдаг. Үүнийг ялгаж, салгахад дараах хүснэгтийг ашиглах боломжтой.

ХҮСНЭГТ 3.10. ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ

ОРОЛЦОГЧ ТАЛУУД	НӨЛӨӨЛӨЛ ҮЗҮҮЛЭХЭЭР СОНГОСОН АСУУДАЛД ХАНДАХ ХАНДЛАГА	НӨЛӨӨЛӨЛ ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛ ТУХАЙН ОРОЛЦОГЧ ТАЛЫН ХУВЬД ХЭР ЧУХАЛ БОЛОХ	НӨЛӨӨЛӨЛ ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛД ОРОЛЦОГЧ ТАЛЫН НӨЛӨӨЛӨХ ХҮЧ
Олон нийтийн дунд нөлөө бүхий удирдагч	Маш сайн	Дунд	Хүчтэй
Улс төрч	Маш эсрэг	Дунд	Сул
ТББ-ын ажилтан	Сайн	Өндөр	Хүчтэй

Энд:

1. *Нөлөөлөл үзүүлэх асуудалд хандах хандлага нь ямар байж болох вэ? Энэ асуултын хариултыг дараах тэмдэглэгээгээр хүснэгтийн хоёр дахь баганад бичээрэй: Маш эсрэг; Эсрэг; Төвийг сахисан; Сайн; Маш сайн.*
2. *Энэ асуудал оролцогч талуудын хувьд хэр чухал вэ? Энэ асуултын хариултыг дараах тэмдэглэгээгээр хүснэгтийн гурав дахь баганад бичээрэй: Бага (тухайн асуудал тэдний хувьд чухал биш); Дунд; Өндөр (тухайн асуудал тэдний хувьд маш чухал)*
3. *Тухайн оролцогч тал энэ асуудалд хэр нөлөөлж чадах вэ? Энэ асуултын хариултыг дараах тэмдэглэгээгээр хүснэгтийн хоёр дахь баганад бичээрэй: Сул; Дунд зэрэг; Хүчтэй;*

Үүний дараа тэднийг таны нөлөөллийн кампанит ажилд хэр тустай байх байдлаар нь тэд таны нөлөөллийн зорилтот бүлэг болох уу эсвэл хамтрагч болох ёстой юу гэсэн асуултын дагуу эрэмбэлэх боломжтой. Ингэж эрэмбэлэхэд дараах хүснэгтийг ашиглах боломжтой.

ХҮСНЭГТ 3.11. НӨЛӨӨЛЛИЙН ЗОРИЛТОТ БҮЛЭГ, ХАМТРАГЧИЙГ СОНГОХ МАТРИЦ

Оролцогч талын нөлөөлөл	Хүчтэй			Яам, агентлагийн дарга (МС)		ТББ-ын ажилтан (Ө)	Асуудал оролцогч талд хэр чухал болох
	Дунд зэрэг						
	Сул						
		Маш эерэг	Эерэг	Төвийг сахисан	Сул	Маш сул	
Нөлөөллийн зорилгод хандах оролцогч талуудын хандлага							

Энд: *Босоо тэнхлэг нь оролцогч талын нөлөөллийг илэрхийлнэ (сул, хүчтэй). Хэвтээ тэнхлэг нь оролцогч талын хандлагыг илэрхийлнэ (маш эерэг; маш сайн). Тухайн асуудал оролцогч талд хэр чухал вэ гэдгийг илэрхийлэх бага; дунд зэрэг; өндөр гэсэн тэмдэглэгээг оролцогч тал тус бүрийн хажууд бичнэ.*

Эдгээр оролцогч талуудын байр суурь тогтмол биш байдаг ба тэдэнд нөлөөлөх нь таны зорилго байх болно. Мөн энэхүү шинжилгээг тодорхой хугацааны дараа хийж тэдний байдалд ямар нэгэн өөрчлөлт гарсан эсэхийг харах боломжтой.



АЛХАМ 5. НӨЛӨӨЛӨХ СТРАТЕГИА СОНГОХ

Нөлөөллийн ажлаа үр дүнтэй явуулахын тулд өөрийн зорилтот бүлэг, нөөц боломж, ур чадвар, харилцаа холбоо, цаг хугацаа зэргийг харгалзан нөлөөллийн зорилгодоо хүрэх хамгийн тохиромжтой аргыг сонгох нь чухал юм. Мөн зорилтот бүлэгтээ хүрэхийн тулд олон үр дүнтэй аргыг сонгох хэрэгтэй.

Нөлөөлөл хийх аргаа сонгохдоо санаж байх ёстой гол зүйл бол тэдгээрийг өөрийн зорилго, зорилтод нийцүүлэх явдал юм. Үүнийг доорх Нөлөөллийн стратегийн зураглалд үзүүлэв. Энэхүү зураглалаас та зарим зорилгууд нь бусдаасаа илүү зорилттой байгаа бол харин зарим зорилтууд нь бусдаасаа илүү олон аргатай байгааг харж болно.

Нөлөөлөл хийхэд хэрэглэх аргуудын тооны хувьд тогтсон тоо байхгүй бөгөөд та хүссэн өөрчлөлтөө бий болгохын тулд тохиромжтой, шаардлагатай гэж үзсэн олон аргыг ашиглах хэрэгтэй. Нөлөөллийн төрөл, стратегиудыг ерөнхийд нь дараах таван бүлэгт хувааж болно.

Үүнд:

1. КОМПАНИТ АЖИЛ
2. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛ
3. ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ
4. ЛОББИ ХИЙХ
5. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ.



ОЛОН НИЙТИЙН КОМПАНИТ АЖИЛ

Олон нийтийн компанит ажил гэдэг нь олон нийтийг татан оролцуулж, тухайн нөлөөллийн асуудлын талаарх таны байр суурийг илэрхийлэхэд тэдний дэмжлэгийг авах үйл явц юм. Гамшиг, ГЭБ талаарх олон нийтийн компанит ажлын нэг чухал ач холбогдол нь үүгээр дамжуулан орон нутгийн гол **зорилтот бүлгүүдийг чадавхжуулахад** оршино.

Лобби хийхэд засгийн газрын тодорхой зорилтот бүлэгт захидал бичих, түүнтэй уулзах зэрэг байдаг бол харин олон нийтийн компанит ажилд хэвлэл мэдээллийн холбоотой ажил илүү байдаг.

Олон нийтийн кампанит ажил нь таны нөлөөллийн мессежийг "олон нийтэд" хүргэх, илүү өргөн хүрээний дэмжлэгийг авч, асуудлыг илүү өргөн хүрээнд таниулж, анхаарлыг татахад маш үр дүнтэй арга байж болох юм. Аливаа асуудлын талаарх олон нийтийн санаа бодлыг өөрчлөх нь улс төрчид, засгийн газрын үйл ажиллагаанд нөлөөлөхөд гол түлхэц болдог.

ОЛОН НИЙТИЙН КАМПАНИТ АЖЛЫН ЗАГВАР, ЖИШЭЭ 1

ТУНХАГ БИЧИГ ГАРГАХ: Тунхаг нь таны кампанит ажлын гол мессежийн тойм байх болно. Энэ бол таны кампанит ажлын шалтгаан, шийдвэрлэхийг хүсч буй асуудал, санал болгож буй шийдлүүдийн товч тодорхой тойм юм. Үүнийг ямар ч сурталчилгааны кампанит ажилд ашиглах боломжтой. Жишээ нь: ухуулах хуудас, вэб сайт гэх мэт.

ОЛОН НИЙТИЙГ ОРОЛЦУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ: Таны зорилго бол асуудалд шийдэл олох зорилгоор хүмүүсийг кампанит ажилдаа элсүүлж, үүгээрээ дамжуулан өргөн хүрээнд олон нийт эсвэл улс төрчдийн хандлагад нөлөөлөх явдал байж болно. Таны гол зорилго хэсэг бүлэг хүмүүсээс бүрдсэн бүлгүүдийг өдөөж, тэдэнд нөлөөлж, мөн тэднийг гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлын ач холбогдлын талаар чадавхжуулж, сургах явдал юм.

ОЛОН НИЙТЭД ЧИГЛЭН БИЧИХ: Энэ нь тодорхой зорилгод бүлэгт захидал, имэйл, ухуулах хуудас илгээх явдал юм. Үүнд мөн тунхаглалаа илгээж болно. Ингэхдээ захидал, ухуулах хуудас хэвлэх, тараахад хэр их зардал гарах, мөн таны зорилтот бүлгийн хэд нь Интернет болон цахим шуудангаар холбогдох боломжтойг бодолцох нь чухал.

ӨРГӨДӨЛ ГАРГАХ: Асуудлын хүрээнд овог нэр, и-мэйл, хаягийн хамт олон тооны гарын үсэг цуглуулах нь эрх мэдэлтэй хүмүүст тухайн нөлөөллийн асуудлыг дэмжихэд нөлөөлөх сайн арга бөгөөд илүү олон тооны гарын үсэг авахын тулд хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах хэрэгтэй.

ҮЙЛ АЖИЛЛАГАА: Кампанит ажлын хүрээнд жагсаал, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, эрдэмтэн, судлаачдын уулзалт, боловсролын хөтөлбөр, бүжиг, дуу, театр үзвэр зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан хүмүүсийн мэдлэгийг нэмэгдүүлэх боломжтой. Үүний хүрээнд нөлөөллийн кампанит ажил хийж буй байгууллагын хувьд өөрийн хүмүүсийн ур чадвар, туршлагыг нэн тэргүүнд анхаарах нь чухал. Хамтран ажиллагсдын мэдлэг, чадвар, туршлагад үндэслэн нөлөөллийн ажлыг явуулах нь илүү дүнтэй байх болно.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛ: хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь таны кампанит ажлын стратегид маш чухал. Үндсэн зорилтот бүлэг болон олон нийтэд өргөн хүрээнд нөлөө үзүүлэхэд телевиз, радио, сонин, хэвлэл нь маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймээс гамшгийн эрсдэлийг бууруулах хүрээнд таны нөлөөлөхөөр сонгосон асуудлыг онцгой сонирхдог сэтгүүлч байгаа эсэхийг олж мэдээрэй, учир нь сэтгүүлчид хэвлэл мэдээллийн хэрэгслээр таны үйл хэргийг дэмжих, салбарын хүмүүстэй холбоо тогтооход үргэлж бэлэн байдаг. Зурагт болон ухуулах хуудас хэлбэрээр сурталчилгаа хийх нь хэвлэмэл материал тул гол агуулгыг илэрхийлэхэд үр дүнтэй байдаг ч энэ нь зардал ихтэй, мөн яг тодорхой зорилтот бүлэгтээ хүрэхэд хүндрэлтэй байх талтай.

ТУНХАГ БИЧИГ, БОГИНО ХЭМЖЭЭНИЙ ЗУРВАС/ МЕССЕЖ/ БОЛОВСРУУЛАХ



Таны нөлөөллийн мессеж тодорхой, ойлгомжтой байх ёстой. Нөлөөллийн асуудлаа дараах дарааллын дагуу 500-аас илүүгүй үгээр бичээрэй. Үүнд:

1. Нөлөөллийн асуудал, асуудлын талаарх байр сууриа тайлбарласан энгийн мэдэгдэл бич
2. Энэ нь яагаад чухал асуудал болохыг нотлох баримтуудыг танилцуул.
3. Өөрчлөлтийн үр дүнг харуулахын тулд бодит жишээг ашигла.
4. Ямар өөрчлөлт хийх шаардлагатайг тайлбарлахын тулд шийдлээ танилцуул.

Жишээлбэл:

- Иргэд, олон нийтэд бэлэн байдлын талаар сургалт хийх нь гамшгийн эрсдэлийг бууруулдаг
- ГЭБ төсөлд хамрагдсан иргэн хэлэхдээ: "Тусламжийн байгууллагууд ихэвчлэн гамшгийн дараа тусламжийн бараатай түгээдэг. Энэхү үйл ажиллагааг гамшгийн өмнө орон нутагт ГЭБ сургагч багш нарыг сургаж, олон нийтийг чадавхжуулахад илүүтэй чиглүүлбэл иргэд олон нийтийн оролцоотой орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулж, гамшгийг хохирол багатай даван туулж чадна, гамшгийн эрсдэл, хохирлыг бууруулж чадна" гэжээ.
- ГЭБ талаарх олон нийтэд чиглэсэн сургалт, арга хэмжээнд гамшигт өртөмтгий бүлгийн иргэдийг хамруулах нь чухал.

ГЭБ үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгах ёстой.

Үүнийг хэнд хандаж, ятгаж үнэмшүүлэх гэж зорьж байгаа сайтар бодох хэрэгтэй. Энэ нь өндөр албан тушаалтан уу, олон нийтийн төлөөлөгч үү, зорилтот бүлэгт тохирохуйц мессежийг агуулсан байх, төвөгтэй үг хэллэгээс зайлсхийх, тодорхой, бодитой байх, шаардлагатай гол өөрчлөлтийг нэгтгэн дүгнэх, өөрчлөлт яагаад чухал болохыг тайлбарлах хэрэгтэй гэдгийг санаарай.

ОЛОН НИЙТИЙН КАМПАНИТ АЖЛЫН ЗАГВАР, ЖИШЭЭ 2

ХУРАЛ, СЕМИНАР, ЗӨВЛӨГӨӨН: Хурал, семинар, зөвлөгөөн зохион байгуулах нь нөлөөллийн асуудлыг олон нийтэд таниулах, тэдний анхааралд хүргэх арга зам юм. Олон нийтийн арга хэмжээг нөлөөллийн зорилгодоо хүрэхэд ашиглаж болох ба энэ нь таны зорилтот бүлэгтээ хүрэх эхний алхам байж магадгүй.

Үүгээр дамжуулан та нөлөөллийн гол агуулгаа аль болох олон хүмүүст хүргэж чадна. Мөн гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах асуудлаар олон нийтийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ГЭБ талаар сургалт зохион байгуулж болно.

Кампанит ажлаа сурталчлахын тулд нэр нөлөө бүхий илтгэгчдийг урих боломжтойгоос гадна хэрэв зохион байгуулж байгаа олон нийтийн арга хэмжээнд тань олон хүн ирж байгаа бол орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн анхаарлыг татах боломж бүрдэнэ.

ОЛОН НИЙТИЙН КАМПАНИТ АЖЛЫН ЗАГВАР, ЖИШЭЭ 3

УХУУЛАХ ХУУДАС, ЗУРАГТ МАТЕРИАЛ АШИГЛАХ: Хэвлэмэл материал ашиглах нь олон хүнд хүрэх бас нэг арга юм. Энэ нь таны гол санаа, гамшгийн эрсдэлийг бууруулах мессеж бүхий дэлгэрэнгүй мэдээллийн ухуулах хуудас эсвэл зурагт хуудаснууд байж болно.

Зурагт хуудас, ухуулах тараах материалуудыг зорилтот бүлэг хэн бэ гэдгээ сайтар бодож хийх хэрэгтэй ба хэдэн ширхэг хэвлэх шаардлагатай, ямар үнэ өртөгтэй, хаана байршуулах талаараа мөн бодолцоорой.

Тараах материалууддаа юуг өөрчлөхийг хүсэж байгаа талаар чухал мессежээ анхаарал татахуйц, ойлгомжтой хэлбэрээр оруулж, зорилтот бүлэгт ойлгомжтой үг хэллэг ашиглахаа бүү мартаарай! Та бүхний боловсруулсан тараах, ухуулах материалууд нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өөр өөр үндэстэн ястан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэх мэт орон нутгийг бүхэлд нь төлөөлж байгаа эсэхийг шалгаарай.



ЖҮЖИГЧИЛСЭН ТОГЛОЛТ

Нөлөөллийн асуудлынхаа талаар мэдээлэл түгээх, сурталчлахад ашиглаж болох хөгжилтэй аргуудын нэг нь жүжигчилсэн тоглолт юм. Энэ төрлийн нөлөөллийн сурталчилгаа нь бичиг үсгийн боловсролын түвшнээс үл шалтгаалан илүү өргөн хүрээнд, олон хүнд хүртээмжтэй, нээлттэй, хөгжилтэй арга замаар хүрэх боломжтой.

Шинэлэг арга барилыг ашиглах нь хүмүүсийн анхаарлыг татах сайн арга боловч хийж буй зүйл тань таны гамшгийн эрсдэлийг бууруулах агуулга болон нөлөөллийн зорилтуудтай тодорхой уялдаж байх нь чухал юм.



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Гамшгийн эрсдэлийг бууруулах талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, ялангуяа гамшгийн эрсдэлийг бууруулах нь яагаад чухал вэ гэдгийг сурталчлахад хэвлэл мэдээллийн хэрэгсэл маш чухал хэрэгсэл, арга зам юм. НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газрын мэдээлснээр гамшгийн асуудал хариуцсан ажилтнууд, судлаачид, сэтгүүлчидтэй илүү нягт ойр хамтран ажиллах нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг бодлого, шийдвэр гаргагчдад болон олон нийтэд илүү сайн хүргэхэд тусална.

Хэрэв та нөлөөллийн кампанит ажилд хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглахаар төлөвлөж байгаа бол зорилгодоо хүрэх төлөвлөгөөгөө гаргах, хэрэгжүүлэх оновчтой аргыг сонгох нь чухал. Мөн дараах асуултуудыг сайтар бодолцоорой.

- Та хэвлэл мэдээллээр дамжуулан хэнд ямар санаа өгөх вэ?
- Та олон нийтэд хэрхэн хүрэх вэ?
- Та хэвлэл мэдээллийн кампанит ажлыг хэзээ хэрэгжүүлэх вэ, энэ нь таны бусад стратегитай хэр нийцэх вэ?
- Зорилтот бүлэг хөдөө орон нутаг эсвэл хотод байгаа юу?
- Та нөлөөллийн ажлаа мэргэжлийн хүмүүс, олон нийт, эсвэл залуучууд гэх мэт тодорхой бүлэгт чиглүүлэхийг зорьж байна уу?
- Мэдээлэл хүлээн авах зорилтот бүлэг телевиз, интернэт, радио хэр ашигладаг вэ?
- Мэдээлэл хүлээн авах зорилтот бүлэг телевиз, интернэт, радио хэр ашигладаг вэ?
- Мэдээний нийтлэл эсвэл зурагт хуудас, онлайн видео зэрэг нүдэнд харагдахуйц мэдээлэл байх уу гэх мэт.



ЛОББИ ХИЙХ

Лобби гэдэг нь ихэвчлэн өөрчлөлтийг хэрэгжүүлэхийн тулд хувь хүмүүст нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэхийг оролдох үйл явц бөгөөд эдгээр нь ихэвчлэн энэхүү өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд нөлөө, эрх мэдэл бүхий засгийн газрын албан тушаалтнууд, гол шийдвэр гаргагчид руу чиглэдэг.

Лобби хийхэд захидал бичих, хуралд оролцох гэх мэт олон янзын албан ёсны үйл ажиллагаа, аргуудыг хэрэглэж болох ба мөн сүлжээ байгуулах, арга хэмжээнд оролцох гэх мэт албан бус аргууд байж болно. Лобби хийх нь хувь хүмүүсийн хооронд хэлэлцээр хийх үйл ажиллагаа тул энэ үйл явц нэлээд их цаг зарцуулна. Иймээс богино хугацаанд заавал шууд үр дүнд хүрэхийг зорих шаардлагагүй. Мөн түүнчлэн хэрэв лобби нь засгийн газрын гамшгийн менежмент, ГЭБ төлөвлөгөө, бодлогыг сайжруулахад чиглэж байгаа бол энэ үйл явц хянагдаж, батлагдахад маш их хугацаа шаардагдах ба энэ нь тухайн улсын улс төрийн тогтолцоо, нөхцөл байдлаас шалтгаална. Хэрэв шаардлагатай бол үүнийг нөлөөллийн ажлын төлөвлөгөөндөө тусгах нь чухал юм.



ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ ЯВУУЛАХ АРГАЧЛАЛ

Манай Улсын хувьд Төсвийн тухай хуульд заасан төсвийн цагалбарын дагуу гамшгийн эрсдэлийг бууруулахад санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг орон нутагт болон олон нийтэд явуулах боломжуудыг дараах хүснэгтэд харууллаа.

ХҮСНЭГТ 3.12. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХАД САНХҮҮЖИЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН АРГАЧЛАЛ

БОЛОМЖ		ХЭЗЭЭ ЯВУУЛАХ	ХЭНД НӨЛӨӨЛӨХ	ХЭРХЭН ХИЙХ
1. УЛСЫН ТӨСӨВ	Улсын төсөвт тусгуулах зорилгоор төсвийн байгууллагын төсвийн саналд ГЭБ санхүүжилтийг тусгахад нөлөөллийн ажил явуулах	Жил бүрийн 7 сарын 25-наас өмнө	<ul style="list-style-type: none"> ➢ Сайд, Засаг дарга нар ➢ Төсвийн байгууллагын удирдлага ➢ Төрийн албан хаагчид 	<ul style="list-style-type: none"> ➢ “Асуудлыг фото зургаар нотлох” арга ➢ Хэвлэл мэдээллийн ажил ➢ Лобби хийх
2. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ	Орон нутгийн төсөвт ГЭБ санхүүжилт тусгахад нөлөөллийн ажил явуулах	Жил бүрийн 12 сарын 5 ба 10-аас өмнө	<ul style="list-style-type: none"> ➢ Иргэдийн төлөөлөгчдийн хуралд ➢ ЗДТГ, Санхүү, төрийн сан, хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан нэгжийн дарга, мэргэжилтэн 	<ul style="list-style-type: none"> ➢ Лобби хийх ➢ Аймаг сумдын ИТХ-ын дарга, төлөөлөгчид, ТББ-ыг татан оролцуулах ➢ Хэвлэл мэдээллийн ажил
3. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН	Орон нутгийн хөгжлийн санд ГЭБ хөрөнгө оруулалтыг тусгахад нөлөөллийн ажил явуулах	Дараагийн төсвийн жилд тус сангаас санхүүжүүлэх ажлыг гаргах тул тухайн оны эхний хагас жилд багтаан хийх	<ul style="list-style-type: none"> ➢ Иргэд, олон нийтэд ➢ Иргэдийн нийтийн хуралд ➢ Засаг даргад ➢ Иргэдийн төлөөлөгчдийн хуралд 	<ul style="list-style-type: none"> ➢ Компанит ажил буюу бүх нийтийн аян өрнүүлэх ➢ Ухуулах хуудас, зурагт материал ашиглах ➢ ИНХ-ын хуралдаанд мэдээлэл тавих, итгэн үнэмшүүлэх

Гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнгээр бий болсон эрсдэлийг бууруулах арга хэмжээний жагсаалтад тулгуурлан нөлөөллийн ажлыг явуулна. Гамшгийн эрсдэлийг бууруулах төсвийг нэмэгдүүлэх үр дүнтэй нөлөөллийн ажил хийхэд анхаарах зүйл:

1. Бодлого, хөтөлбөртэй уялдсан байх. Төсөв боловсруулахад баримталдаг бодлогын баримт бичгүүд, салбарын болон орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй уялдсан, тэдгээрийн хэрэгжилтэд хувь нэмэр оруулахуйц арга хэмжээнд санхүүжилт шийдвэрлүүлэх нь оновчтой байдаг.
2. Төсөвт тусгахын тулд бусад ажлуудтай өрсөлдөнө гэдгийг ойлгох. Санхүүжилт дутмаг байгаа нь ихэнхдээ хөрөнгө, мөнгө дутсантай холбоотой биш, харин шийдвэр гаргах түвшинд тухайн ажилд тэргүүлэх ач холбогдол өгөхгүй байх явдал байдаг.
3. Нөлөөллийн ажил нь хандив цуглуулах эсвэл хөрөнгө босгохоос тэс өөр зүйл гэдгийг санах. Нөлөөллийн ажил явуулах сэтгэл шулуудсан бол та мөнгө нэхэх биш нийгэмд ач холбогдолтой, илүү үр ашигтай шийдлийг санал болгоно. Энэ шийдлийнхээ үр ашгийг нотолж, зайлшгүй хэрэгцээтэй гэдгийг нотлох шаардлага гардаг.
4. Хамтран ажиллах хүмүүсийг оновчтой сонгох. Бидэнд төсөв шийдэхэд хэрэгцээтэй хүмүүстэй биш хамтран ажиллахад тохиромжтой буюу тухайн ажлыг бүтээхийн төлөө сэтгэлтэй хүмүүстэй ажиллах хэрэгтэй. Эдгээр хүмүүстэй хамтран "эсэргүүцэгчид"-тэй холбоо барьж, тэднийг баримт нотолгоотой мэдээллээр хангах, төсвийн төлөвлөлтийн үед болон төсөв батлагдсаны дараа хуваарилсан төсөв хөрөнгө бүрэн эсэхийг баталгаажуулах, мөн зарцуулалтад хяналт тавих хэрэгтэй.
5. Орон нутгийн удирдлагуудтай зөвшилцөлд хүрэх. Нөлөөллийн ажлын эхэнд орон нутгийн төсвийн хуваарилалтын талаар орон нутгийн удирдлагатай маш сайн зөвшилцөх хэрэгтэй.
6. Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах. Хамгийн чухал зүйл бол нөлөөллийн ажлын үр дүнд батлагдсан төсвийг цаг хугацаанд нь хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй зарцуулж байгаад хяналт тавих хэрэгтэй.



АЛХАМ 6. НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

Зорилго, зорилтоо тодорхойлсон, таны нөлөөллийн зорилтот бүлэг хэн байхыг сонгосон, мөн нөлөөлөх стратеги оновчтой болсны дараа **Нөлөөллийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө** боловсруулах боломжтой болно. Алхам бүрийн төгсгөлд хийж гүйцэтгэсэн хүснэгт болон бичсэн хураангуй мэдээллүүдээ ашиглан та гамшгийн эрсдэлийг бууруулах нөлөөллийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд шаардлагатай гол мэдээллүүдээ нэгтгэх боломжтой.

Харин одоо үйл ажиллагааныхаа хураангуй хүснэгтийг доорх загвараар хийж болно. Үйл ажиллагаа бүрийг хариуцах албан тушаалтныг тодорхойлох нь зүйтэй.

ХҮСНЭГТ 3.13. НӨЛӨӨЛЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР

ЗОРИЛТ	ЗОРИЛТОТ БҮЛЭГ	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ЯВЦЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХУГАЦАА	ХАРИУЦАХ ЭЗЭН	ХЯНАЛТ
Ирэх оны төсөвт ГЭБ арга хэмжээний шаардагдах төсвийн эх үүсвэрийг батлуулах	Аймаг, сум, дүүргийн ЭД, тэдгээрийн Тамгын газар	ГЭБ төсөв батлахын ач холбогдлыг онцолсон лобби уулзалт хийх	Зорилтот бүлгийн 80% нь ГЭБ гол санаа, агуулгыг ойлгож хүлээн авсан байна.	6 сарын дотор (он, сар, өдөр)	ГЭБЗ-ийн дарга	(Мониторинг хийх өдрөө бичих)
	ЭДТГ-ын Санхүү, төрийн сан, Хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан нэгжүүд	Холбогдох албан тушаалтнуудад ГЭБ талаар мэдлэг, ойлголт өгөх сургалт, өдөрлөг хийх,			Нөлөөллийн бүлэг	
	Хэвлэл мэдээлэл	ГЭБ гол санаа, агуулгыг үнэ, төлбөргүй цацаж, сурталчлах, мэдлэг ойлголт өгөх, уулзалтыг хийх	ТВ, сонин хэвлэл, радио гэх мэт гол хэвлэл мэдээллүүдээр цацагдсан байдал	3 сарын дотор (он, сар, өдөр)	Нөлөөллийн бүлэг	(Мониторинг хийх өдрөө бичих)



АЛХАМ 7. ХЯНАЛТ БА ҮНЭЛГЭЭ

Нөлөөллийн ажлын үр дүнг үнэлэх нь дараагийн ажлыг илүү үр дүнтэй зохион байгуулахад ихээхэн ач холбогдолтой. Хэрэв та гамшгийн эрсдэлийг бууруулах нөлөөллийн ажлын төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлж, хүссэн өөрчлөлтөө бий болгохыг хүсэж байвал үйл ажиллагааныхаа үр дүнг хянаж, үнэлэх ёстой. Энэ нь танд ахиц дэвшил, үр дүнгээ дүгнэх боломжийг олгох ба нөгөөтээгүүр тийм ч сайн үр дүнтэй хэрэгжүүлж чадаагүй ажиллагаанаасаа суралцах боломжийг олгоно. Нөлөөллийн бүлгийн гишүүд хянах, тайлагнах, үнэлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох ёстой. Хяналт, үнэлгээний талаарх ойлголтоо дараагийн бүлгээс тодруулаарай.

Та нөлөөллийн кампанит ажлынхаа хүрээнд олон төрлийн үйл ажиллагаа явуулахдаа амжилт, үр дүнгээ хянах хэрэгтэй ба үүний тулд дараах үзүүлэлт, мэдээллийг цуглуулах хэрэгтэй. Үүнд:

- **СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТ:** энэ нь нөлөөллийн ажлын эхэнд таны сонгосон асуудлын талаар одоогийн нөхцөл байдал ямар байгааг харуулах үзүүлэлт. Хэрэв таныг энэ асуудлын талаар ямар нэг зүйл хийж эхлэхээс өмнө нөхцөл байдал ямар байсныг ойлгохгүй бол та ямар өөрчлөлтийг бий болгосон эсвэл хувь нэмрээ оруулснаа тодорхойлоход хэцүү байх болно.
- **НӨӨЦ:** энэ нь таны илгээсэн имэйлийн тоо, боловсруулсан төлөвлөгөө, гаргасан ухуулах хуудасны тоо, үйл ажиллагаа бүрд зарцуулсан хугацаа, санхүү, лобби төлөвлөгөө, сургалт, зохион байгуулсан уулзалт гэх мэт таны ашигласан нөөц ба таны хийсэн арга хэмжээ

- **ШУУД ҮР ДҮН:** энэ нь таны хийсэн үйлдлүүдийн шууд үр дүн юм, Жишээлбэл, цахим шуудангийн хариу, кампанит ажлын талаар танаас хүссэн мэдээлэл, бэлтгэсэн тайлан, хурлын тэмдэглэл, хийсэн айлчлалын тайлан, хэвлэл мэдээлэлд таны кампанит ажлын талаар дурдсан тоо гэх мэт.
- **ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД:** ахиц гарч байгаа эсэхийг хэмжих үзүүлэлт. Өөрчлөлт гарч байгаа эсэхийг хэлж өгнө.
- **ДУНД ШАТНЫ ҮР ДҮН:** энэ нь нөлөөллийн ажлын явцад бий болсон дунд хугацааны өөрчлөлт, үр дүн юм. Жишээ нь: мэдлэг, зан төлөв, хүртээмж гэх мэт
- **ҮР НӨЛӨӨ:** Энэ бол таны бий болгож, хүрэхийг хүсэж буй урт хугацааны, эцсийн өөрчлөлт юм. Богино хугацаанд та энэ өөрчлөлтийг ганцаараа хийх боломжгүй. Иймд олон оролцогч талуудын оролцоог хангаснаар гамшгийн эрсдэлийг бууруулахад хувь нэмрээ оруулж чадна гэдгээ ойлгох нь чухал.

НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛДАА ХЯНАЛТ МОНИТОРИНГ ХИЙХ:

Та нөлөөллийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхдээ үйл ажиллагааныхаа хэрэгжилтэд өдөр, долоо хоног, сар бүр хяналт мониторинг хийх аргачлалтай байх хэрэгтэй. Энэхүү аргачлал нь нөлөөллийн бүлгийн гишүүн бүр ашиглах боломжтой байхаар энгийн байх хэрэгтэй. Жишээлбэл, дараах байдлаар хийж болно.

ХҮСНЭГТ 3.14. НӨЛӨӨЛЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД МОНИТОРИНГ ХИЙХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИШЭЭ

ХУГАЦАА	ХААНА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ЗОРИЛТОТ БҮЛЭГ	ХҮРСЭН ХҮНИЙ ТОО (ЭР, ЭМ)	ШУУД ҮР ДҮН

Дээрх мэдээлэлд үндэслэн сар бүр дүн шинжилгээ хийж болно. Үүнд:

- Зохион байгуулж буй үйл ажиллагааны төрлүүд
- хаана хийж байгаа
- Хэдэн хүнд хүрсэн (хэдэн хүн хамрагдсан), мөн нас, хүйсээр мэдээллээ ангилах асуулт нэмж болно.
- Эдгээр үйл ажиллагааны шууд үр дүн нь юу байсан гэх мэт

Ингэж мэдээллээ тогтмол цуглуулснаар Нөлөөллийн ажлын төлөвлөгөөгөө цаг тухайд нь хэрэгжүүлж байгаа эсэхийг дүгнэх боломжтой болох ба бий болгож буй жижиг түвшний өөрчлөлтүүдээ тодорхойлж чадна.

Энэхүү мэдээллээ нөлөөллийн бүлгийн гишүүд хоорондоо хуваалцаж, нөлөөллийн ажил хэр сайн явж байгаа мөн тулгарч буй бэрхшээлээ ярилцаж шийдэл гаргахдаа ашиглах хэрэгтэй. Ийм уулзалтыг улирал бүр эсвэл зургаан сар тутам хийх нь тохиромжтой. Уулзалтын үеэр ярилцах зүйлсийг чиглүүлэх гол асуултаудаа урьдчилан тодорхойлох хэрэгтэй.

ЧИГЛҮҮЛЭХ ГОЛ АСУУЛТЫН ЖИШЭЭ:



1. Энэ улиралд таны зорилтот бүлэг хэн байсан бэ?
2. Та тэдэнтэй уулзаж, ярилцаж чадсан уу? Үгүй бол яагаад?
3. Энэ улиралд юу сайн болсон бэ?
4. Ямар бэрхшээлтэй тулгарсан бэ? Та асуудлыг хэрхэн шийдсэн бэ?
5. Та өөрийн үйл ажиллагаанаас ямар үр дүнд хүрсэн бэ? Жишээ нь: ГЭБ арга хэмжээний санхүүжилт нэмэгдсэн, олон нийт, хүмүүс асуулт асууж, үйл ажиллагаанд оролцож байсан, харилцаа холбоогоо нэмэгдүүлсэн гэх мэт
6. Таны дараагийн төлөвлөгөө юу вэ?

Эцсийн үнэлгээ хийх үед та хяналт, мониторингоос маш их мэдээлэлтэй болсон байх болно. Тиймээс үнэлгээг ерөнхий өөрчлөлтийг эргэн харж, юу сурч мэдсэнээ ойлгох, дараагийн хугацаанд юу хийх төлөвлөгөө, үйл явцад гарсан аливаа өөрчлөлтийг хийх боломж гэж харах хэрэгтэй.


Түүнчлэн дараагийн удаад нөлөөллийн ажлыг сайжруулахын тулд дараах асуултуудын дагуу шинжилгээ хийгээрэй.

- Нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх санхүүжилт хэр үр дүнтэй зарцуулагдсан бэ? Нэмэлт санхүүжилтийг хэрхэн бүрдүүлсэн бэ?
- Бүх арга хэмжээ уулзалтууд амжилттай болж чадсан уу? Хэрэв зарим нь амжилттай болж чадаагүй бол яагаад? Цаашид ложистикийг хэрхэн сайжруулах вэ?
- Танай байгууллага, зөвлөл, алба хэт их ачаалалтай байсан уу, үүнээс болж ажилтан, гишүүдийн дунд шантрах асуудал гарсан уу? Үүнийг цаашид хэрхэн сайнаар шийдэх вэ? Нөлөөллийн зорилго илүү нарийсгах уу эсвэл хүчин чармайлтаа илүү сайн удирдах боломжтой болгохын тулд цаг хугацааг сунгах уу?

3.6. ЦАГ АГААР, УУР АМЬСГАЛЫН НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН МЭДЭЭНД ТУЛГУУРЛАСАН САНХҮҮЖИЛТИЙН АРГЫГ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХАД АШИГЛАХ НЬ

Гарын авлагын энэ хэсэгт “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь (ADAPT) төсөл”-өөс санал болгож байгаа цаг агаар, уур амьсгалын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ болон энэхүү урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилтийн аргыг гамшгийн эрсдэлийг бууруулахад хэрхэн ашиглах боломжийг тодорхойлж өгсөн.

ЗУРАГ 3.6. ЦАГ АГААР, УУР АМЬСГАЛЫН ГАРАЛТАЙ ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН МЭДЭЭНД ТУЛГУУРЛАСАН САНХҮҮЖИЛТИЙН АРГЫГ АШИГЛАН БУУРУУЛАХ




НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ (IBF)

Уламжлалт цаг агаарын сэрэмжлүүлэх мэдээ нь “цаг агаар ямар байх талаар мэдээлэх” буюу аюулын цар хүрээнд анхаарал хандуулдаг бол нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ нь тухайн аюулд өртөх байдал болон эмзэг байдлыг авч үзэж “цаг агаарын мэдээг сонсоод бид юу хийж чадах вэ” буюу аюулын үед юу болох талаар нарийвчилсан дүн шинжилгээ хийх гэсэн үг юм. Нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ (IBF) гэдэг нь аюулаас учирч болох хохирлыг тоон байдлаар тайлбарлаж, урьдчилсан мэдээнд гамшигт үзэгдлийн нөлөөллийг хаана, хэзээ, ямар түвшинд хүрэхийг тодорхойлно.

Нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ нь эрсдэлийн үндсэн байгуулагч болох аюулыг тодорхойлоод зогсохгүй түүний нөлөөлөлд өртөх эд зүйлийн эмзэг байдлын үнэлгээг давхар хийж, цаг агаар, уур амьсгалын гаралтай аюултай үзэгдлийн янз бүрийн салбар, аж ахуйн нэгж, хүн ам, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар мэдээлэл өгөхөд чиглэгдсэн цаг агаарын урьдчилсан мэдээний шинэ арга юм.

Нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээг гаргаснаар байгаль, цаг уурын эрсдэлийн эсрэг дорвитой арга хэмжээ авч хүний амь нас, эд хөрөнгө, амьжиргааг хамгаалах нөхцөл бүрдэнэ. Нөлөөлөлд суурилсан урьдчилсан болон сэрэмжлүүлэг мэдээг боловсруулж гаргах нь ус, цаг уурын алба болон гамшгийн эрсдэлийг бууруулах байгууллага хоорондын хамтын ажиллагаа сайжирч, ийм урьдчилсан мэдээг ашигласнаар шийдвэр гаргагчид тодорхой бус байдалд зохих арга хэмжээ авах, сонголт хийх боломжтой болдог байна.

ЗУРАГ 3.7. НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ



Эх сурвалж: АДАПТ төсөл, "Цаг агаар, уур амьсгалын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ-урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилтийн гарын авлага, 2023

Уламжлалт урьдчилсан мэдээ болон нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээний ялгааг үерийн аюулын төрөл дээр жишээ болгон авч үзье.

ХҮСНЭГТ 3.15 УЛАМЖЛАЛТ УРЬДЧИЛСАН МЭДЭЭ БОЛОН НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН МЭДЭЭНИЙ ХАРЬЦУУЛАЛТ БОЛОН ДАХИН БОЛОВСРУУЛСАН НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ ОЙЛГОЛТ

АЮУЛ	УЛАМЖЛАЛТ УРЬДЧИЛСАН МЭДЭЭ	НИЙТИЙН ХЭРЭГЛЭЭНД/ХУВЬ ХҮНД ЗОРИУЛСАН НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ	ТУХАЙЛСАН САЛБАРЫН ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ
ҮЕР	Хүчтэй борооны урьдчилсан мэдээ. 3 цаг 100-150мм бороо орохоор тооцоолсон.	Голын ус үерийн хэмжээнд хүрнэ. Голын сувгаас 30 метрийн зайнд орших орон байр, ферм болон бэлчээрийн талбай үерт автаж, сүйднэ.	Усны үерийн урьдчилсан мэдээгээр 3 хоногийн турш 5 хоногийн босго утгыг +0.85 давахаар тооцоологдсон. Нөлөөллийн урьдчилсан мэдээгээр хүн амын 40% нь нөлөөнд автаж, аж ахуйн 25% нь алдагдал хүлээхээр байна.

Эх сурвалж: АДАПТ төсөл, "Цаг агаар, уур амьсгалын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ-урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилтийн гарын авлага, 2023

Манай улс цаг агаарын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээг богино (1-7 хоног) болон урт (сар, улирал, хагас жил) хугацаагаар гаргана. Богино хугацааны нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээний жишээг дараах зурагт үзүүлэв. Энэ мэдээнд мэдээнд аюултай үзэгдлийн ноосолсон малд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөг дурдаж өгсөн нь нөлөөлөлд үндэслэсэн сэрэмжлүүлэх мэдээ болж байна.

МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ ХЭЛТЭС

2021 оны 06 дугаар сарын 29


Улаанбаатар хот 46 **Утас: 326609, 326603**
Жуулчны гудамж – 5 **№ 180** **Факс: 326614, 263862**

Дохио!!! Цаг агаарын аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ:
 Өнөө шөнө Сэлэнгэ, Төв аймгийн нутгаар хүйтэн бороо үргэлжлэн орох тул ноосолсон мал осгох эрсдэл үүсэж болзошгүйг сэрэмжлүүлж байна.
Малчид, иргэдийн анхааралд:
 Өнөө маргаашдаа төв болон зүүн аймгуудын нутгаар бороо үргэлжлэн орох тул үер усны аюулаас сэрэмжтэй байхыг анхааруулж байна.

Эх сурвалж: АДАПТ төсөл, "Цаг агаар, уур амьсгалын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ-урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилтийн гарын авлага, 2023


Ийм мэдээ нь малчид, иргэд тухайн аюулт үзэгдэлд өртөх байдлыг бууруулах арга хэмжээг авах боломжийг олгосноороо учирч болзошгүй эрсдэлийг бууруулж чадна. Цаг агаарын нөлөөлөлд өртөх салбар, байгууллагын талаарх жишээг хавсралт 5-оос харна уу. Богино хугацааны нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээний хувьд манай оронд хамгийн их хохирол учруулдаг цаг агаарын аюулт үзэгдлээс хүчтэй салхи, цасан болон шороон шуургыг сонгон авч тус аюулын нөлөөлөх газар нутаг, цар хүрээг тооцон тархалт болон өртөх хувийг тодорхойлон цаг агаарын гамшигт үзэгдэл болох магадлалыг тооцож, тухайн үзэгдлийн нөлөөллийн улмаас хэр хэмжээний хохирол учрах магадлалтай байгааг бага, дунд, их болон маш их гэсэн ангиллаар гаргаж нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээг бэлтгэж нийтэд мэдээлж, сэрэмжлүүлэх боломжтой юм.

ЗУРАГ 3.8. ХҮЧТЭЙ САЛХИ, ШУУРГАНЫ АЮУЛЫН НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ ГАРГАХ БҮДҮҮВЧ



Эх сурвалж: АДАПТ төсөл, "Цаг агаар, уур амьсгалын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ-урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилтийн гарын авлага, 2023

ЗУРАГ 3.9. ЗУДЫН ГАМШГИЙН НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ ГАРГАХ БҮДҮҮВЧ



Эх сурвалж: АДАПТ төсөл, "Цаг агаар, уур амьсгалын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ-урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилтийн гарын авлага, 2023


Урт хугацааны нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээний хувьд удаан хугацаанд үргэлжилдэг уур амьсгалын эрс тэс үзэгдлүүдээс ган, зудын аюулын зураглалыг манай оронд 2015 оноос эхлэн гаргаж, тус мэдээгээ тухай бүр иргэд, хөдөө аж ахуйн салбарын хэрэглэгчид, бүх түвшний шийдвэр гаргагчид, онцгой байдлын байгууллага болон олон улсын тусламжийн байгууллагуудад мэдээлж байна.

УРЬДЧИЛСАН МЭДЭЭЛЭЛД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТ (FBF)

Энэхүү нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээгээр тодорхойлсон цаг агаар, уур амьсгалын гамшигт үзэгдлийн нөлөөллийн түвшин, эрсдэл, эмзэг байдал, учирч болзошгүй хохирол, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээг эртнээс авах боломжийг урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилтийн арга нь олгоно. Урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилтийн (FBF) гол зорилго нь гамшгаас урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлийг бууруулахад оршино.


Ус, цаг уурын албаны нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээнд үндэслэж урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилтийн үйл явц эхэлдэг. Урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилтийн гол нөхцөл нь учирч болзошгүй хохирол, эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээг эртнээс авахад зориулсан нөөц болон санхүүгийн эх үүсвэртэй байх явдал юм.

ЗУРАГ 3.10. УРЬДЧИЛСАН МЭДЭЭНД ТУЛГУУРЛАСАН САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ ЯВЦ



Эх сурвалж: АДАПТ төсөл, "Цаг агаар, уур амьсгалын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ-урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилтийн гарын авлага, 2023

ЗУРАГ 3.11. НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ БОЛОН УРЬДЧИЛСАН МЭДЭЭНД ТУЛГУУРЛАСАН САНХҮҮЖИЛТИЙН УЯЛДАА ХОЛБОО



Эх сурвалж: АДАПТ төсөл, “Цаг агаар, уур амьсгалын нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ-урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилтийн гарын авлага, 2023

Урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын үүрэг, хариуцлага, санхүүжилтийг идэвхжүүлэх тогтолцоог улс орны онцлог, аюулт үзэгдлийн төрөлд нийцүүлэн боловсруулсан шалгуур үзүүлэлт, стандарт үйл ажиллагааны журамд тодорхойлсон байна.

НӨЛӨӨЛӨЛД СУУРИЛСАН УРЬДЧИЛСАН МЭДЭЭНД ТУЛГУУРЛАСАН САНХҮҮЖИЛТИЙН АРГААР ЗУДЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ НЬ

Манай орны хувьд цаг агаар, уур амьсгалын онцгой нөхцөлдөө нийцсэн нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ, урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилтийн хөгжүүлэлтийг амжилттай хийж эхэлсэн бөгөөд үүний нэг жишээ нь их хэмжээний малын хорогдлыг үүсгэдэг зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээ болно.

ШИГТГЭЭ 6:

“ЦАГ УУРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТ” ТӨСӨЛ

Монголын улаан загалмайн нийгэмлэг (МУЗН) нь “Цаг уурын урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилт” төслийг 2017 оноос хойш холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж эхэлснээс хойш 20 мянга гаруй малчин өрхөд тусламж үзүүлээд байна. Энэ арга хэмжээ нь зудын эрсдэл өндөр, маш өндөр гэсэн урьдчилсан мэдээ гарсан тохиолдолд зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээнд шаардлагатай санхүүжилтийг шийдэх гол арга хэрэгсэл болж ашиглагдаж байна. МУЗН цаг уурын урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилт төслийн тусламжид хамрагдах малчин өрхөд өөрөө малаа малладаг байх, 50-200 толгой малтай байх гэсэн үндсэн шалгуурыг тавьдаг. Мөн нь дараах шалгуурын аль нэгийг мөн хангасан байхыг шаарддаг. Үүнд:

- **Өрх толгойлсон малчин**
- **Өрх нь өндөр насны гишүүнтэй байх**
- **Өрх нь хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй байх**
- **Өрх нь 16-аас доош насны 5 болон түүнээс дээш хүүхэдтэй байх.**

Төслийн санхүүжилт нь Ус цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгээс гаргадаг сумын түвшний зудын эрсдэлийн нөлөөлөл, цасны урьдчилсан мэдээ - /7 хоног/, температурын урьдчилсан мэдээ - /7 хоног/, өвлийн улирлын төлөв - /сар, улирал/ зэрэг мэдээлэлд үндэслэн гаргадаг зудын эрсдэлийн зурагт суурилдаг. Зудын эрсдэлийн үнэлгээгээр 3 ба түүнээс дээш аймгийн газар нутгийн 20%-аас илүү газар нутагт зуд болох магадлал өндөр байвал санхүүжилтийн схем идэвхжиж эхэлнэ. Малын хорогдол жилд дунджаас 6% байдаг ба хэрэв малын хорогдол 10%-аас дээш болно гэж дүгнэсэн тохиолдолд урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилтийн схемийг ажиллуулах шаардлагатай гэж үздэг.

Зудын үед эмзэг бүлгийн малчдыг зудад өртөхөөс урьдчилан сэргийлэх, малын хорогдлыг бууруулах болон малчдын эрүүл мэнд, хоол хүнсний хангамжийг бууруулахгүй байх зорилгоор ойролцоогоор 100 ам.доллартой тэмцэх бэлэн мөнгө болон “малын тэжээлийн багц”-ийг малчин өрхөд олгодог байна.

МУЗН нь 2017-2018 оны өвөл Английн улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран 4 аймгийн 223 өрхөд тусламж үзүүлсэн, мөн 2020 онд нийт 19 аймгийн 113 сумын цөөн малтай, олон хүүхэдтэй, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүн бүхий 2000 эмзэг бүлгийн өрхөд тусламж хүргэсэн. Энэхүү цаг уурын урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилт төсөл нь эмзэг бүлгийн гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн төдийгүй гамшгийн эрсдэлийг бууруулах санхүүжилтийн шинэ арга хэлбэр гэдгийг орон нутгийн түвшинд нотлон харуулснаараа чухал ач холбогдолтой болсон.

Цаг уур, орчны шинжилгээний газраас 2022 оны 12-р сарын 1-ний өдөр гаргасан зудын эрсдэлийн зургаар зуд нэн өндөр болон өндөр эрсдэлтэй гарсан Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Сүхбаатар, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Ховд, Увс, Завхан зэрэг 13 аймгийн зорилтот бүлгийн 1000 малчин өрхөд хүмүүнлэгийн тусламж үзүүлсэн. Энэхүү тусламжийг Олон улсын Улаан

загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбоотой хамтран хэрэгжүүлэх бөгөөд зудын нэн өндөр болон өндөр эрсдэлтэй гарсан эдгээр 13 аймгийн 1000 малчин өрх бүрд 370'000 төгрөгийн бэлэн мөнгөний тусламжийг Хаан банкаар дамжуулан олгосон байна.

Эдгээр төслийн үр дүнгийн үнэлгээгээр санхүүжилт авсан малчин өрхийг санхүүжилт аваагүй өрхтэй харьцуулахад малын хорогдол багатай байсан гэсэн дүгнэлт гаргасан байдаг.

Өнөөгийн байдлаар цаг агаарын урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилтийн арга нь зөвхөн олон улсын байгууллагаас хариуцан төслийн хүрээнд хэрэгжиж байна. Өнгөрсөн хугацаанд олон улсын байгууллагын шугамаар хэрэгжүүлсэн энэхүү арга хэмжээ үр нөлөө өндөртэй байгаа нь тухайн төслийн үр дүнгийн үнэлгээгээр тогтоогдсон.

Иймд цаашид цаг агаарын урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилтийн удирдлага, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн, үндэсний онцлогийг тусган боловсронгуй болгох шаардлагатай. Энэ нь зудын эрсдэл өндөр, маш өндөр гэсэн урьдчилсан мэдээ гарсан тохиолдолд зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээнд шаардлагатай санхүүжилтийг шийдэх гол арга хэрэгсэл болж ашиглагдаж байх нь зүйтэй юм.

Цаашид энэ арга хэмжээг үндэсний хэмжээнд зудын эрсдэлийг бууруулах үр дүнтэй тогтолцоо болгож хөгжүүлэхийн тулд цаг агаарын урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилтийг идэвхжүүлэх тогтолцоог бий болгох хэрэгтэй. Олон улсын туршлагаас үзэхэд цаг агаарын урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилтийг идэвхжүүлэх тогтолцоог стандарт үйл ажиллагааны журмаар дамжуулан бий болгодог байна.

Стандарт үйл ажиллагааны журам гэж цаг уурын урьдчилсан тооцооллын тодорхойлолтоор идэвхэждэг, урьдчилан мэдээлэх үйл ажиллагааг алхам алхмаар хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгохыг хэлнэ. Түүнд хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагааны төрлүүд, үндсэн болон туслах чанарын оролцогчид, тэдгээрийн үүрэг хариуцлагууд болон зорилтод бүлэг, цаг хугацааг зохицуулах зааварчилгаа багтдаг.



Үр нөлөөллийн түвшнээс хамаарах цаг агаар болон уур амьсгалтай холбоотой үзэгдлүүдийн эрчимжилтийн босго үзүүлэлтэй байх ёстой ба онцлог босго үзүүлэлтийг давах үр дагаврын онцлог тохиолдлыг түүхчилсэн ажиглалт болон өртөх байдал болон эмзэг байдлын өгөгдөл мэдээллийг ашиглаж тооцно (зудын эрсдэлийн критик зааг-дунд түвшин). Эдгээр гурван төрлийн бүрэлдэхүүн хэсгүүд нь стандарт үйл ажиллагааны журамд нэгтгэгддэг болно.

Стандарт үйл ажиллагааны журам нь зааварчилгааны дагуу хэрэгжих үйл ажиллагааны үүрэг гүйцэтгэдэг ба үйл ажиллагааг эхлүүлэх мөчид тулсан үед хурдан хугацаанд ажиллах чиг үүрэг хариуцлагуудыг зураглан гаргадаг байна. Мөн оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг хариуцлагуудыг тодорхой зааж өгсөн байдаг. Стандарт үйл ажиллагааны журмыг эрдэмтэн судлаачид, хүмүүнлэгийн тусламжийн болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн зөвлөлөөр хэлэлцэж баталдаг.

Стандарт үйл ажиллагааны журмыг зудын эрсдэлийг цаг уурын урьдчилсан мэдээнд тулгуурлан бууруулах үйл ажиллагаанд оролцогч талуудын оролцоотойгоор боловсруулснаар үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Хүснэгт 3.16-д цаг уурын урьдчилсан мэдээлэлд суурилсан санхүүжилтийг идэвхжүүлэх төлөвлөгөөний загварыг үзүүлээ.

Энэ нь зудын эрсдэлийн зурагт суурилсан эрт хариу арга хэмжээг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг нотолсон үндэслэл болохоос гадна хөрөнгө мөнгө босгох хуваарилах, зарцуулах засгийн газрын шийдвэрийн үндэслэл болно. Гэхдээ зудын эрсдэлийн зурагт суурилсан эрт хариу арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгө мөнгийг идэвхжүүлэхийн тулд улсын болон орон нутгийн төсөвт суулгасан заалтуудын хэд хэдэн дагалдах баримт бичгийг урьдчилан боловсруулах шаардлагатай. Үүнд:



- Зудын эрсдэлийн үнэлгээ болон зудын эрсдэлийн зураглал бүхий нөхцөл байдлын тухай гамшгийн эрсдэлийг бууруулах Улс аймаг, орон нутгийн зөвлөлийн танилцуулга.
- Зудын эрсдэлийн үнэлгээ болон зудын эрсдэлийн зураглал бүхий нөхцөл байдалд үндэслэсэн эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх тухай Улсын болон аймаг орон нутгийн онцгой комиссын даргын тушаал шийдвэр
- Зудын эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө
- Эрт хариу арга хэмжээнд хамрагдах зорилт бүлгийн судалгаа
- Эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх улсын болон орон нутгийн тусгай сан төсвийг санхүүжүүлэх Засгийн газрын тогтоол шийдвэр
- Засгийн газрын шийдвэрт үндэслэсэн эрт хариу арга хэмжээний худалдан авалтын төлөвлөгөө. Энэхүү худалдан авалтын төлөвлөгөө эмзэг малчин өрхийн мэдээлэлд үндэслэнэ.

ХҮСНЭГТ 3.16. ЦАГ УУРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭЛЭЛД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙГ ИДЭВХЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР¹⁵

	АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ХАРИУЦАГЧ БАЙГУУЛЛАГА	ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА	ХУГАЦАА
ЗУДЫН ЭРСДЭЛИЙН ИНДЕКСИЙН МЭДЭЭГ БОЛОВСРУУЛАХ				
1	Өртөх байдал, чадавхын үзүүлэлтүүдийг тодорхойлох өгөгдөл, мэдээг урьдчилж бэлтгэсэн байх <i>Энд сумын нутаг дэвсгэр дээрх малчин өрхийн өвөлжөөг газрын нэгдмэл санд бүртгэсэн байх, отор нүүдлээр ирсэн малчин өрхийн байршлыг бүртгэн, тэмдэглэсэн байх, холбогдох бусад мэдээллүүд</i>	Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл	ХАА газар, Газрын харилцаа, хот байгуулалтын газар, сумын газрын даамал	6-8 сар
2	Тухайн жилийн бэлчээрийн ургацын мэдээ болон гангийн индексийн мэдээ боловсруулах	УЦОСМХ		7-8 сар
3	Аюул, эмзэг байдлын индексийг статик, динамик индексэд тулгуурлан тодорхойлох	УЦОСМХ, ОБЕГ	Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл	8 сар
4	Анхааруулах зураг үйлдэх	УЦОСМХ, ОБЕГ		6-8 сар
5	Зудын аюулын анхааруулах мэдээ боловсруулах /Зудын эрсдэлийн критик заагаас давсан аймаг орон нутаг, малчдад сэрэмжлүүлэх мэдээ, мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах анхааруулга санамж хүргүүлэх/	УЦОСМХ, ОБЕГ	Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл	9 -р сар 1
6	Хүйтний улирлын мэдээ гаргахаас өмнө өртөх байдал, чадавхын үзүүлэлтүүдийг тодорхойлох өгөгдөл, мэдээнд тодотгол хийж бэлтгэх	Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл	ХАА газар, сумын ЗДТГ	10-р сар
7	Хүйтний улирлын мэдээ боловсруулах	УЦОСМХ		10-р сар

¹⁵ ОБЕГ-ын даргын тушаал 2019-03-13 А\68 Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх зааврын 2.3.14. Зуд Улаан, улбар шар түвшин

5.1. Иргэдэд гамшгийн аюулын зарлан мэдээллийн талаарх ойлголт мэдээлэл, зарлан мэдээлэл хүлээн аваад хариу арга хэмжээ авах мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг ОБАЭТЗБ зохион байгуулна.

Гамшигт үзэгдлийн талаарх урьдчилан сэргийлэх мэдээг Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор баталсан "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам"-ын 3.1-д заасны дагуу дамжуулна

"Сэрэмжлүүлэх мэдээлэл" гэж мэргэжлийн байгууллагын дүгнэлт, мэдээллийн үндсэн дээр болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор зарлан мэдээллийн хэрэгслээр урьдчилан мэдээлэхийг хэлнэ.

2.6. "Бүх нийтийн зарлан мэдээлэл" гэж засаг захиргаа нутаг дэвсгэрийн хэд хэдэн нэгжид үүссэн буюу үүсэж болзошгүй гамшгийн тухай мэдээллийг орон даяар зарлан мэдээллийн хэрэгслээр хүргэхийг хэлнэ.

2.7. "Хэсэгчилсэн зарлан мэдээлэл" гэж сум, дүүрэг, аймгийн нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт үүссэн буюу үүсэж болзошгүй гамшгийн тухай мэдээллийг зарлан мэдээллийн хэрэгслээр хүргэхийг хэлнэ.

8	Аюул, эмзэг байдлын индексийг динамик болон статик индекс тулгуурлан тодорхойлох	УЦОСМХ, ОБЕГ	УОК	10-р сар
9	Сэрэмжлүүлэх зураг үйлдэх	УЦОСМХ, ОБЕГ		10-11 сар
10	Зудын аюулын сэрэмжлүүлэх мэдээ боловсруулах /Зудын эрсдэлийн критик заагаас давсан аймаг орон нутаг, малчдад анхааруулах мэдээ, мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх анхааруулга санамж хүргүүлэх/ мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг шалгах/	УОК, ЗГ	УЦУОСМХ, ОБЕГ, Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл	10-11 сар
11	Цаг уурын урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилт төсөл идэвхжих	ЦУУМТС төсөл	ОУБ	11 сар
12	Тухайн жилийн хүйтний улирлын хүндэрсэн нөхцөл байдлын үзүүлэлтийг эрсдэлийн үнэлгээнд тооцох	УЦОСМХ		Нөхцөл байдлаас хамаарна
13	Урьдчилан сэргийлэх зураг үйлдэх	УЦОСМХ, ОБЕГ		
ЗУДЫН ИНДЕКСИЙН МЭДЭЭГ ТҮГЭЭХ				
14	Аймаг, сумдын зудын эрсдэлийн үнэлгээнд үндэслэн бүх төрлийн мэдээллийн хэрэгслийг ашиглан зудаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх мэдээг дамжуулах	УЦОСМХ, ОБЕГ	Орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл	10-11 сар
15	Аймаг, сумдын зудын эрсдэлийн үнэлгээнд үндэслэн мал өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх тухай албан даалгавар аймаг, орон нутагт хүргүүлэх	УОК	ХХААХҮЯ, ОБЕГ	11-р сарын 1
16	Зудын индексийн мэдээ, нөхцөл байдлын мэдээнд үндэслэн зудаг өртөж болзошгүй аймаг, сумдын зудын эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэх. Аюул, эмзэг байдлын индексийг динамик, статик болон нэмэлт индексэд тулгуурлан тодорхойлох	УОК, УЦОСМХ, ОБЕГ	ХХААЯ, СЯ,	Нөхцөл байдлаас хамаарна
ЗУДЫН ЭРСДЭЛИЙН ИНДЕКСЭД СУУРИЛСАН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БА САНХҮҮЖИЛТ				
17	Зудын эрсдэлийн сэрэмжлүүлэх зураг дахь эрсдэлийн түвшний критик заагаас хэтэрсэн буюу эрсдэлийн түвшин “Их”, “Маш их” үнэлэгдсэн орон нутагт эрсдэлийг бууруулах санхүүжилт шаардлагатай гэсэн хүсэлт гаргах	Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөл	Орон нутгийн онцгой комисс	11-р сарын 15
18	Цаг уурын урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилтийг олгох шийдвэрийн сонголтыг хийнэ.	Төсөл ОУБ	ОУБ	11-р сарын 20
19	Эрт хариу арга хэмжээг санхүүжүүлэх хэрэгцээг тодорхойлох, нэмэлт санхүүжилтийн хүсэлт гаргах	ХХААХҮЯ, СЯ	УОК, Орон нутгийн онцгой комисс	11-р сарын 15-аас 12 дугаар сарын 15


20	Улсын болон орон нутгийн төсвийн зудын индексэд суурилсан заалтыг Засгийн газрын нөөц хөрөнгө болон гамшгаас хамгаалах тусгай сангаас идэвхжүүлж зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээг санхүүжүүлэх	МУЗГ, УОК	СЯ, ХХААХҮЯ, ОУБ	12 дугаар сарын 15-30
----	--	-----------	------------------	-----------------------

Санхүүжилтийг олгох шийдвэрийн сонголтыг хийхдээ зураг 3.12-д үзүүлсэн алгоритмыг ашиглаж болох юм гэж үзлээ. Тус зурагт үзүүлсэн алгоритмын гол зорилго нь цаг уурын урьдчилсан мэдээнд тулгуурлан зудын эрсдэл бүхий эмзэг бүлгийн малчин өрхийн малыг онд оруулж тэдний амьжиргааг хамгаалахад урьдчилан дэмжлэг үзүүлэхэд оршино.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд шийдвэрийн сонголтын олон хувилбар байж болох бөгөөд санхүүжилт буюу дэмжлэгийг үр дүн, үр ашигтай байлгахын тулд оновчтой хувилбарыг хэрхэн сонгохыг санал болгосон. Энэ хувилбарыг малчин өрхийн эрсдэлээс зайлсхийх, эрсдэлийг бууруулах, шилжүүлэх, дасан зохицох чадавхыг харгалзан эмзэг бүлгийн өрхийн амьжиргааг хамгаалах тохиолдолд хэрэглэж болно. Өөрөөр хэлбэл малчин өрхийн отор нүүдэл хийх, малаа тэжээх боломж, малын индексжүүлсэн даатгалд хамрагдалт, өрхийн орлого зэрэг санхүүгийн чадавхыг харгалзан зорилтот бүлгийг оновчтой зөв сонгоход хэрэглэнэ.



ЗУРАГ 3.121. ЗУДЫН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЦАГ УУРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙГ ОЛГОХ ШИЙДВЭРИЙН СОНГОЛТЫН АЛГОРИТМЫН ЗАГВАР



БҮЛЭГ 4. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ, ҮР ДҮН

4.1. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ

Гамшгийн эрсдэлийн удирдлагын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох хяналт нь эрсдэлийн удирдлагын үйл явцын хэрэгжилт, үр дүнгийн чанар, үр нөлөөг баталгаажуулах, сайжруулах зорилготой төдийгүй, эрсдэлийн удирдлагыг улам бүр боловсронгуй болгоход чиглэдэг учраас эрсдэлийг бууруулахад шийдвэрлэх нөлөөтэй байдаг.



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ: Энэ нь аливаа үйл ажиллагаа төлөвлөсний дагуу явж байгаа эсэх, мөн сайжруулалт, өөрчлөлт хийх шаардлагатай эсэхийг явцын дунд тодорхойлох үйл явц бөгөөд үнэлгээ хийх баримт нотолгоог бэлтгэн нийлүүлэх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл хяналт-шинжилгээ нь хүрсэн үр дүнгийн учир шалтгааныг логик хэлхээнд задлан тодорхойлох шинжилгээ байдаг. Хяналт-шинжилгээ бол шалтгаан үр дагаврын тухай ойлголт, мэдээллийг бий болгоно.

ҮНЭЛГЭЭ: Энэ нь норматив шинжилгээ ба үнэ цэнийг харьцуулан тодорхойлох шинжилгээ буюу үр дагавар, үр ашиг, үр нөлөө гэх мэтийг тодорхойлно. Үнэлгээ нь шинэ тулгамдсан асуудлыг томъёолох, асуудлыг шийдэх хувилбарт шаардлагатай суурь түвшнийг тодорхойлоход дэмжлэг болох мэдээллийг бий болгоно.

Хяналт-шинжилгээ нь бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, арга хэмжээ зорилтот үр дүнгийн төлөө ажиллаж байна уу гэдэг асуултад хариулт хайдаг товчхондоо энэ нь зөв хэрэгжиж байна уу үгүй юу гэсэн асуултад хариулахыг оролдоно. Харин үнэлгээ нь хэрэгжилтийн үр дүнд бий болсон үнэ цэнийг илрүүлэхийг чухалчлан үзнэ. Үнэлгээ бол хэрэгжилтийн дүнд зорилтот үр нөлөө, үнэ цэнээ бүтээсэн үү буюу хүрсэн үр дүнгийн үнэ цэнэ нь юу вэ гэсэн асуултад хариулна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хэрэгжилтэд тавих хяналт-шинжилгээ нь гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого, хөтөлбөр, хөгжлийн бодлогод туссан арга хэмжээний болон гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, төслийн арга хэмжээний хугацаа, хүрэх үр дүн, бусад шаардлагатай зүйлийг тогтоох, арга хэмжээний хэрэгжилтийн гүйцэтгэлийг төлөвлөсөн үр дүнтэй харьцуулж, оролцогч талуудад мэдээлэл өгөх зорилгоор тодорхой давтамжтай хийгдэх, тасралтгүй үргэлжлэх үйл явц юм (зураг 4.1).


Хяналт-шинжилгээний хүрээнд арга хэмжээ бүрийн ахиц, хугацаа, шалгуур, төсөв, зорилт, үр дүн болон эрсдэлийг бууруулах арга хэмжээн дэх нөлөөллийг авч үзнэ. Энд мөн тухайн арга хэмжээг хэрэгжихэд сөргөөр нөлөөлж болох хүчин зүйлийг тогтооно. Хяналт-шинжилгээ нь мэдээлэл цуглуулах, шалгах уулзалт хийх болон тайлагнах хэсгүүдээс бүрдэнэ.

ЗУРАГ 4.1. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ



ҮНЭЛГЭЭ нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг дэх гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний болон гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, төслийн зорилго, зорилтууд биелсэн эсэхийг тогтоохын тулд бий болсон үр нөлөө, үнэ цэнийг үнэлэх арга хэмжээ юм (Зураг 4.2).

ЗУРАГ 4.2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ



Хяналт-шинжилгээ ба үнэлгээ нь зорилго, агуулга, шалгуур үзүүлэлтийг сонгох, мэдээлэл цуглуулах арга болон хугацааны хувьд харилцан хамааралтай, эргэх холбоотой үйл ажиллагаанууд байдаг.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний онол, аргазүйн үндсийг “Өөрчлөлтийн онол”-д тулгуурлаж явуулна. “Өөрчлөлтийн онол” нь аливаа үйл ажиллагааны өөрчлөлтийг үндсэн 5 үе шатаар хэмжиж үр дүн, үр нөлөөг тодорхойлж, хүссэн үр дүнд хэрхэн хүргэх тухай онол юм.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, төлөвлөгөө, төсөл нь төлөвлөсний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд байнга хяналт-шинжилгээ хийдэг бол, урдаас товлосон хугацаанд үнэлгээг хийнэ.

Гарын авлагын гамшгийн эрсдэлийг бууруулах засаглал гэсэн 2 дугаар бүлэг болон гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт гэсэн 3 дугаар бүлэгт үндэслэж авч үзвэл, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд дараах чиглэлээр хяналтыг хэрэгжүүлэхээр байна.

ЗУРАГ 4.3. ӨӨРЧЛӨЛТИЙН ОНОЛЫН ҮЕ ШАТ



ЗУРАГ 4.4. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ЧИГЛЭЛ



4.1.1. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 4.1.15-д "хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ" гэж хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа энэ хуульд заасан зарчмыг баримталсан байдал, хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогчдын чиг үүргээ хэрэгжүүлсэн болон хамтран ажилласан байдал, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнд хийсэн цогц үнэлгээг" хэлнэ гэж тодорхойлсон байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай" хууль болон Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хийнэ.

ХҮСНЭГТ 4.1. ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГТ ТУССАН ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧИГ	ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТАЛ	ЭРХ ЗҮЙН ҮНДЭС
УЛСЫН ТҮВШИНД		
Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
Хөгжлийн зорилтот хөтөлбөр		
Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр		
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө		
Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр		
Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө		
Улсын төсөв	Улсын Их Хурал	Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4
САЛБАРЫН ТҮВШИНД		
Салбарын эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөө	Төрийн захиргааны байгууллагын дарга	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам;
ОРОН НУТГИЙН ТҮВШИНД		
Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	Нутгийн захиргааны байгууллага	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам;
Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр		
Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө		
Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйл
Орон нутгийн төсөв		

4.1.2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ, ЭДГЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн баримт бичгийн зорилтын хэрэгжилтийн явц, үйл ажиллагааны үр дүнд болон энэхүү стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 51 дүгээр тушаалаар батлагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу Онцгой байдлын ерөнхий газар хариуцаж хэрэгжүүлнэ.

ХҮСНЭГТ 4.2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛ	ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТАЛ	ЭРХ ЗҮЙН ҮНДЭС
Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн хэрэгжилтийн явц, үйл ажиллагааны үр дүнгийн хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ	Онцгой байдлын ерөнхий газар (2 жил тутам хийж Засгийн газарт танилцуулна)	Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн 6.1, 6.2 дахь заалт
Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ		Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” 51 дүгээр тушаалын 3 дахь заалт

4.1.3. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтэд тавих хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 189 дүгээр тогтоолоор баталсан Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажиллах журмыг үндэслэн Үндэсний зөвлөлийн ажлын алба буюу Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газар хариуцаж хэрэгжүүлнэ.

ХҮСНЭГТ 4.3. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛ	ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТАЛ	ЭРХ ЗҮЙН ҮНДЭС
Гамшгийн эрсдэлийг бууруулах бодлогын зөвлөмжийн хэрэгжилт (Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлөөс гаргасан)	Үндэсний зөвлөлийн ажлын алба (Онцгой байдлын ерөнхий газар)	Засгийн газрын 2020 оны 189 дүгээр тогтоолоор батлагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажиллах журам

Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн ажлын алба нь Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн зөвлөмжийг хэрэгжүүлэгч талуудаас ажлын биелэлтийг албан бичгээр гаргуулан авч биелэлтэд хяналт-шинжилгээг хүснэгт 4.4-ын дагуу, үнэлгээг хүснэгт 4.5-ын дагуу хийнэ.

ХҮСНЭГТ 4.4. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО	ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАХ ТАЛ	ХЭРЭГЖИЛТИЙГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ҮР ДҮНТЭЙ БАЙДАЛД ДҮГНЭЛТ ГАРАХ ХЭЛБЭР
Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийн явц, үр дүнг хэмжих	холбогдох төрийн байгууллага, улсын албад	төлөвлөсөн үр дүнгүүд арга хэмжээний хугацаа	<ul style="list-style-type: none"> ▪ цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ▪ тодотгол хийж хэрэгжүүлэх ▪ тухайн арга хэмжээг зогсоож тохиромжтой арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх

ХҮСНЭГТ 4.5. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ҮНЭЛГЭЭ ХИЙХ

ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО	ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАХ ТАЛ	ХЭРЭГЖИЛТИЙГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ҮР ДҮНТЭЙ БАЙДАЛД ДҮГНЭЛТ ГАРАХ ХЭЛБЭР
Зөвлөмжид тусгагдсан одоо үргэлжилж байгаа, дууссан арга хэмжээний зорилгод хүрсэн эсэхийг хэмжих	холбогдох төрийн байгууллага, улсын албад	<ul style="list-style-type: none"> ▪ зорилго, зорилтууд биелсэн эсэх ▪ хүрсэн үр дүн, үр нөлөө 	<ul style="list-style-type: none"> ▪ одоо үргэлжилж байгаа арга хэмжээний хувьд цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжтой, анхаарах асуудал дууссан арга хэмжээний хувьд үр нөлөөтэй, үр нөлөөгүй байдлын дүгнэлт гарна

4.1.4. ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээдийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2, 29.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн бүх шатны Онцгой байдлын байгууллага жил бүр хийнэ.

ХҮСНЭГТ 4.6. ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛ	ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТАЛ	ЭРХ ЗҮЙН ҮНДЭС
Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний хэрэгжилт	Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл	Засгийн газрын 2020 оны 189 дүгээр тогтоолоор батлагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажиллах журам
	Бүх түвшний Онцгой байдлын байгууллага	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2, 29.1.15;

Гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд байгуулагдсан ажлын хэсэг 3-5 жилд нэг удаа Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөний биелэлтийг тухайн түвшний онцгой байдлын байгууллагаас гаргуулан авч төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хүснэгт 4.4-т үзүүлсэн агуулгаар хийх нь зүйтэй.

ХҮСНЭГТ 4.4. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ҮНЭЛГЭЭ ХИЙХ

ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО	ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАХ ТАЛ	ХЭРЭГЖИЛТИЙГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ҮР ДҮНТЭЙ БАЙДАЛД ДҮГНЭЛТ ГАРАХ ХЭЛБЭР
Зөвлөмжид тусгагдсан одоо үргэлжилж байгаа, дууссан арга хэмжээний зорилгод хүрсэн эсэхийг хэмжих	тухайн түвшний Онцгой байдлын байгууллага	<ul style="list-style-type: none"> ▪ зорилго, зорилтууд биелсэн эсэх ▪ хүрсэн үр дүн, үр нөлөө 	<ul style="list-style-type: none"> ▪ Одоо үргэлжилж байгаа арга хэмжээний хувьд цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжтой, анхаарах асуудал ▪ Дууссан арга хэмжээний хувьд үр нөлөөтэй, үр нөлөөгүй байдлын дүгнэлт гарна.

Бүх түвшний Онцгой байдлын байгууллага нь Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэгч талуудаас ажлын биелэлтийг албан бичгээр гаргуулж авч биелэлтэд хяналт-шинжилгээг хүснэгт 4.5-ын дагуу хийх боломжтой.

ХҮСНЭГТ 4.5. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО	ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ГАРГАХ ТАЛ	ХЭРЭГЖИЛТИЙГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ҮР ДҮНТЭЙ БАЙДАЛД ДҮГНЭЛТ ГАРАХ ХЭЛБЭР
Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хэмжих	холбогдох төрийн байгууллага, улсын албад	төлөвлөсөн үр дүнгүүд арга хэмжээний хугацаа	<ul style="list-style-type: none"> ➢ цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ➢ тодотгол хийж хэрэгжүүлэх ➢ тухайн арга хэмжээг зогсоож тохиромжтой арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлэх

4.1.5. ГАМШГААС ХАМГААЛАХ, ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭРХ ХОЛБОГДОХ ДҮРЭМ, ЖУРАМ, УДИРДАМЖ, ЗААВАР, СТАНДАРТЫН ХҮРЭЭНД ГАМШГААС ХАМГААЛАХ ХЯНАЛТААР ДАМЖУУЛАН ХЭРЭГЖҮҮЛНЭ.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд тавих хяналтыг гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр гаргасан холбогдох дүрэм, журам, удирдамж, заавар, стандартын хүрээнд гамшгаас хамгаалах хяналтаар дамжуулан хэрэгжүүлнэ.

ХҮСНЭГТ 4.6. ГАМШГААС ХАМГААЛАХ, ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭРХ ХОЛБОГДОХ ДҮРЭМ, ЖУРАМ, УДИРДАМЖ, ЗААВАР, СТАНДАРТЫН БИЕЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛ	ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТАЛ	ЭРХ ЗҮЙН ҮНДЭС
Гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээрх холбогдох дүрэм, журам, удирдамж, заавар, стандартын биелэлт	Бүх түвшний Онцгой байдлын байгууллага	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйл; Засгийн газрын 2018 оны 40 дүгээр тогтоолоор батлагдсан Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм; Засгийн газрын 2016 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан Гал түймрийн улсын хяналтын дүрэм;
	Төрийн бус байгууллага	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1-д заасан иргэний хяналт

Гамшгаас хамгаалах хяналт нь холбогдох эрх зүйн баримт бичгийг сурталчлах, хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зэргээр зөвлөх чиг үүрэгтэй байхаас гадна тухайн байгууллага, иргэдийн үйл ажиллагаанд байгаа гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг нэмэгдүүлж буй дутагдал, алдааг илрүүлж, шаардлагатай тохиолдолд таслан зогсоох хүртэл арга хэмжээ авч хянах чиг үүрэгтэй. Гамшгаас хамгаалах хяналт дараах төрөлтэй байна.

ЗУРАГ 4.5. ГАМШГААС ХАМГААЛАХ ХЯНАЛТЫН ТӨРӨЛ

ТӨЛӨВЛӨГӨӨТ	ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС	ГҮЙЦЭТГЭЛИЙН
<ul style="list-style-type: none"> • хэзээ, хаана, ямар үйл ажиллагаанд хэрхэн хяналт тавих асуудлыг урьдчилж тодорхойлж, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх хяналт. 	<ul style="list-style-type: none"> • үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт болон холбогдох дээд байгууллагын шийдвэр, цаг үеийн зайлшгүй шаардлагаар хийгдэж байгаа хяналт. 	<ul style="list-style-type: none"> • өмнөх хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах, эсвэл эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгах зорилгоор хийгдэх хяналт.

Гамшгаас хамгаалах улсын албад нь өөрийн салбарын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хяналтыг 1) гамшгийн улсын хяналт, 2) гал түймрийн улсын хяналтын хүрээнд холбогдох дүрэм, журмын дагуу хийлгэх боломжтой. Түүнчлэн өөрийн салбарт дагаж мөрддөг хууль тогтоомж, норм, дүрэмд заасан шаардлага, шалгуурын дагуу хэрэгжүүлнэ. Тухайлбал, Барилгын тухай, Ойн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, гэх мэт.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд тавих хяналтыг Онцгой байдлын байгууллагын улсын хяналтын байцаагч дараах хүснэгтэд үзүүлсэн чиглэлээр хэрэгжүүлнэ.

ХҮСНЭГТ 4.6. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛ

ГАМШГААС ХАМГААЛАХ ХЯНАЛТЫГ ЯВУУЛАХ ЧИГЛЭЛ (Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрмээс)	ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТ ЯВУУЛАХ ЧИГЛЭЛ (Гал түймрийн улсын хяналтын дүрмээс)
1.1.1. Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандарт, эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэрийн биелэлт;	2.1.1. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг хамгаалах чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө, санамж, сэрэмжлүүлэг өгч, галын аюулгүй байдлыг хангуулахад дэмжлэг үзүүлэх;
1.1.2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт;	2.1.2. Галын аюулгүй байдлын тухай, Барилгын тухай, Ойн тухай хууль, галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавих;
1.1.3. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, санхүүжилт, зарцуулалт;	2.1.3. Гал түймэртэй тэмцэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, төсвийн төлөвлөлт, тоног төхөөрөмж, гал унтраах анхан шатны багаж, хэрэгслийн хангалт, ашиглалт, хадгалалтын байдалд хяналт тавих;
1.1.4. Улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах сургалт, бэлтгэл, бэлэн байдал;	

<p>1.1.7. Гамшгийн аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах бэлтгэл, бэлэн байдал;</p> <p>1.1.8. Хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагаа, хязгаарлалтын болон хорио цээрийн дэглэмийн хэрэгжилт;</p>	<p>2.1.4. Барилга байгууламж барих, өргөтгөх, засварлах зураг төсөл техникийн нөхцөл галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор хийсэн магадлалыг хянаж, дүгнэлт гаргах;</p> <p>2.1.5. Гал түймрийн аюулгүй байдлыг хангах талаар хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хэрхэн биелүүлж байгаа байдалд хяналт тавьж, үнэлгээ өгөх, хэрэгжилтийг хангуулах;</p> <p>1.1.6. Хот, суурины төлөвлөлт, барилга байгууламжийн байршлыг тогтоох, объектыг гал түймрийн аюулаас хамгаалахтай холбоотой үйл ажиллагаанд мэргэжлийн дүгнэлт гаргах;</p> <p>1.1.7. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад объектын болон ой, хээрийн түймэр гарсан үед шуурхай мэдээлэх, унтраах бэлтгэл, гал түймрээс хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, учирч болох хохирлыг багасгахад чиглэсэн арга хэмжээг урьдчилан авсан эсэхэд хяналт шалгалт хийж, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>1.1.8. Гал түймэр гарсан тохиолдолд хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хойшлуулшгүй ажиллагаа явуулж, гал түймэр гарсан тухай акт тогтоох, тэмдэглэл хөтлөх;</p> <p>1.1.9. Барилга байгууламж болон үйлдвэрийн технологийн үйл ажиллагаа, галын аюултай бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжид хийсэн гал түймрийн аюулын үнэлгээний чанарт хяналт тавих.</p>
---	--

4.1.6. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Төсөл нь өгөгдсөн хугацаанд тодорхой төсвийн хүрээнд өмнөө тавьсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа байдаг. Ямар ч төсөл дараах бүрдэлтэй байна. Үүнд:

- Анхдагч зорилтот бүлэг болон эцсийн ашиг хүртэгчдийг багтаасан тодорхой оролцогч талуудтай байна;
- Тодорхой зохицуулалт, удирдлага, санхүүжилтийн зохицуулалттай байна;
- Хяналт шинжилгээ, үнэлгээний системтэй байна;
- Төслийн үр ашиг нь зардлаасаа давж гарахыг харуулсан санхүү, эдийн засгийн зохих түвшний шинжилгээг хийсэн байна.

Төслийн удирдлага нь өгөгдсөн хугацаанд тавьсан зорилгодоо хүрэх, амжилттай хэрэгжсэнийг тодорхойлох шалгуурыг хангахын тулд багийн ажлыг эхлүүлэх, төлөвлөх, гүйцэтгэх, хянах, дуусгах үйл ажиллагаа юм. Энэ утгаараа төслийн хэрэгжилтэд тавих хяналт-шинжилгээ, үнэлгээ нь төслийн удирдлагын зайлшгүй нэг бүрдэл хэсэг байдаг.

Гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн төслийн хэрэгжилтэд тавих хяналтыг тухайн төслийн баримт бичигт туссан хяналт-шинжилгээ, үнэлгээний системээр дамжуулан хэрэгжүүлнэ.

ХҮСНЭГТ 4.7. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛ	ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙХ ТАЛ	ЭРХ ЗҮЙН ҮНДЭС
Гамшгийн эрсдэлийг бууруулах төсөл, арга хэмжээний хэрэгжилт	УЛСЫН ТҮВШИНД	
	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 7.6.6-д заасны дагуу;
	САЛБАРЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ТҮВШИНД	
	Санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч тал	Төслийн баримт бичигт туссан хяналт

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээг өөрчлөлтийн онолын үе шатны дагуу хийх бөгөөд үүнийг тухайлсан нэг төсөл дээр хэрхэн хийсэн жишээг доор үзүүлэв.

ШИГТГЭЭ 7:**“ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭНД ТУЛГУУРЛАСАН САНХҮҮЖИЛТ” ТӨСЛИЙН ДУНД ХУГАЦААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

“Цаг агаарын урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилт” төсөл нь МУЗН-ээс зудын эрсдэлийн зурагт үндэслэн өвөлжилт хүндрэх магадлалтай нутгийн малчин өрхүүдийг малаа зудад алдахаас урьдчилан сэргийлж зудын эсрэг эрт хариу арга хэмжээ авахад нь дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой хэрэгждэг.

Зудын эрсдэлийн зургийг Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс зуншлага, бэлчээрийн даац, малын тоо, биомасс, хур тунадасны болон температурын хазайлт, гангийн индекс, цасны зузаан, цасан бүрхүүл, агаарын температур болон хур тунадасны урьдчилсан мэдээ зэрэг үзүүлэлтийг ашиглан эрсдэлийг 5 түвшин (маш өндөр, өндөр, хэвийн, бага, маш бага)-д хувааж гаргадаг. Энэхүү зудын эрсдэлийн зурагт гурав ба түүнээс олон аймгийн 20%-иас их газар нутагт маш өндөр эрсдэл үүссэн тохиолдолд зудын эсрэг эрт хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгоор “Цаг агаарын урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилт” төслийг хэрэгжүүлнэ.

МУЗН-ээс өөрийн салбар хороодоор дамжуулан дараах үндсэн болон нэмэлт шалгуур үзүүлэлтийн аль нэгийг хангасан эмзэг бүлгийн малчин өрхийг сонгон тусламжид хамруулсан байна. Үүнд:



Үндсэн шалгуур:

- 50-400 ХҮРТЭЛХ ТОЛГОЙ МАЛТАЙ МАЛЧИН ӨРХ
 - НЭМЭЛТ ШАЛГУУР:
- 16 ХҮРТЭЛХ НАСНЫ ГУРАВ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ ЭСВЭЛ ЭХ;
- ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНТЭЙ ГЭР БҮЛ;
- ЖИРЭМСЭН ЭСВЭЛ ХӨХҮҮЛ ЭЭЖТЭЙ ГЭР БҮЛ;
- 60-ААС ДЭЭШ НАСНЫ ӨӨРӨӨ МАЛАА МАЛЛАДАГ МАЛЧИН ӨРХ;
- 16 ХҮРТЭЛХ НАСНЫ 5 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ХҮҮХЭДТЭЙ МАЛЧИН ӨРХ.

Тус төслийн үр дүнгийн үнэлгээгээр төслөөс олгосон тусламжийн үйл ажиллагаа зорилгодоо хэр зэрэг хүрснийг “Өөрчлөлтийн онол”-д тулгуурлан, төслийн үр дүнгийн үнэлгээг төслийн үр дагавар ба үр нөлөөний шалгуур үзүүлэлтээр авч үзэж дараах үр дүнг гаргасан байна.



4.2. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

Аливаа үйл ажиллагааны үр дүнг тавьсан зорилгодоо хэр зэрэг хүрсэн байдлаар үнэлдэг. Үр дүнгийн шалгуур нь тоо болон чанарын үзүүлэлт байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үр дүн нь гарын авлагын 1.3-д тодорхойлсон олон төрлийн арга хэмжээг 3 дугаар бүлэгт авч үзсэн төрөл бүрийн төлөвлөлтөөр дамжуулан хэрэгжүүлсний эцэст эрсдэлийн цар хүрээнд гарсан өөрчлөлтөөр хэмжигдэх учиртай.



Дэлхий дахинд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг **“ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2015-2030 ОНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ БАРИМТ БИЧИГ”**-т тусгагдсан зорилгод хэр зэрэг хүрсэн байдлаар үнэлэхээр буюу 2030 он гэхэд дараах үр дүнд хүрнэ гэж тодорхойлсон. Үүнд:

ЗОРИЛГО: Аюулд өртөх байдал, гамшигт эмзэг байдлаас урьдчилан сэргийлэх, бууруулах, гамшгийн хор уршгийг арилгах, сэргээн босгох бэлэн байдлыг сайжруулж, гамшигтай тэмцэх чадварыг бэхжүүлэх эдийн засгийн, бүтцийн, хууль, эрх зүйн, нийгмийн, эрүүл мэндийн, соёлын, боловсролын, байгаль орчны, технологийн, улс төрийн болон институцийн нэгдмэл, харилцан уялдаатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулах, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх.

ХҮРЭХ ҮР ДҮН: Гамшгийн эрсдэл, түүний улмаас хүний амь нас, эрүүл мэнд, амьжиргаа, ард иргэд, бизнес, олон нийт, улс орны эдийн засаг, нийгэм, биет болон соёлын үнэт зүйл, хүрээлэн буй орчинд учрах хохирлын хэмжээг бодитой бууруулах.

Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн зорилго нь үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг удирдлага болгож, гамшгийн хохирлыг бууруулах дэлхийн хэмжээний дор дурдсан 7 зорилтыг хэрэгжүүлснээр биелэгдэх юм.

Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээний зорилтыг:

- 
- **ЗОРИЛТ 1)** 2005-2015 онтой харьцуулахад 2020-2030 онд гамшгийн улмаас амь насаа алдагсдын 100,000 хүн тутамд ноогдох дунджийг бууруулах зорилт тавин 2030 он гэхэд амь насаа алдагсдын тоог бодитой бууруулах;
 - **ЗОРИЛТ 2)** 2005-2015 онтой харьцуулахад 2020-2030 онд гамшигт нэрвэгдэгсдийн 100,000 хүн тутамд ноогдох дунджийг бууруулах зорилт тавин 2030 он гэхэд нэрвэгдэгсдийн тоог бодитой бууруулах;
 - **ЗОРИЛТ 3)** 2030 он гэхэд гамшгийн улмаас учрах эдийн засгийн шууд хохирлын хэмжээг дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүнтэй холбоотойгоор бууруулах;
 - **ЗОРИЛТ 4)** Гамшгийг тэсвэрлэх чадавхыг сайжруулах зэргээр 2030 он гэхэд гамшгийн улмаас нэн чухал дэд бүтэц, суурь үйлчилгээ түүний дотор боловсрол, эрүүл мэндийн байгууламжид учрах хохирлыг бодитой бууруулах;
 - **ЗОРИЛТ 5)** 2020 он гэхэд үндэсний болон орон нутгийн түвшний гамшгийн эрсдэлийг бууруулах стратегитай улс орны тоог бодитой нэмэгдүүлэх;
 - **ЗОРИЛТ 6)** 2030 он гэхэд хөгжиж буй орнуудын энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай, тогтвортой дэмжлэгийг үзүүлэх олон улсын хамтын ажиллагааг бодитой сайжруулах;
 - **ЗОРИЛТ 7)** 2030 он гэхэд аюулын төрөл бүрийг эрт зарлан мэдээлэх систем, гамшгийн эрсдэлийн мэдээлэл, үнэлгээг ард иргэд хүртэх, ашиглах боломжийг бодитой нэмэгдүүлэх гэж тодорхойлсон.

Энэхүү 7 зорилтын уялдааг холбоог авч үзвэл гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого, стратеги баталж, холбогдох бүх талуудын хамтын ажиллагааг сайжруулж, гамшгийн эрт зарлан мэдээлэл, гамшгийн эрсдэлийн талаарх мэдээллийг бүх нийтэд хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх замаар аливаа гамшгийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, хүн амын амьдрал ахуй, эдийн засаг, дэд бүтэцэд үзүүлэх сөрөг нөлөөллийг буюу болзошгүй эрсдэлийг бууруулахад чиглэж байна.

ЗУРАГ 4.6. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ БАРИМТ БИЧГИЙН ЗОРИЛТУУД



Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг эдгээр тавьсан зорилтдоо хэр зэрэг хүрсэн байдлаар хэмжинэ. Энэхүү үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

ЗОРИЛТ 1. 2005-2015 онтой харьцуулахад 2020-2030 онд гамшгийн улмаас амь насаа алдагсдын 100,000 хүн тутамд ноогдох дунджийг бууруулах зорилт тавин 2030 он гэхэд амь насаа алдагсдын тоог бодитой бууруулах

A1	Гамшгийн улмаас амь насаа алдсан болон сураггүй алга болсон хүний тоо 100,000 хүн тутамд /A2-A3 нэгдсэн байдлаар/
A2	Гамшгийн улмаас амь насаа алдсан хүний тоо 100,000 хүн тутамд
A3	Гамшгийн улмаас сураггүй алга болсон хүний тоо 100,000 хүн тутамд

ЗОРИЛТ 2. 2005-2015 онтой харьцуулахад 2020-2030 онд гамшигт нэрвэгдэгсдийн 100,000 хүн тутамд ноогдох дунджийг бууруулах зорилт тавин 2030 он гэхэд нэрвэгдэгсдийн тоог бодитой бууруулах

B1	Гамшигт нэрвэгдсэн хүний тоо 100,000 хүн тутамд /B2-B5 нэгдсэн байдлаар/
B2	Гамшгийн улмаас гэмтэж бэртсэн болон өвчилсөн хүний тоо 100,000 хүн тутамд
B3	Гамшгийн улмаас орон байр /гэр/ сүйдсэн хүний тоо
B4	Гамшгийн улмаас орон байргүй, /гэргүй/ болсон хүний тоо
B5	Гамшгийн улмаас амьжиргаагаа алдсан хүний тоо

ЗОРИЛТ 3. 2030 он гэхэд гамшгийн улмаас учрах эдийн засгийн шууд хохирлын хэмжээг дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүнтэй холбоотойгоор бууруулах

C1	Гамшгийн улмаас дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүнд нөлөөлөхүйц эдийн засгийн шууд алдагдал /C2-C6 нэгдсэн байдлаар/
C2	Гамшгийн улмаас хөдөө аж ахуйн салбарт үүссэн шууд хохирол
C3	Гамшгийн улмаас бусад үйлдвэрлэлийн салбарт үүссэн эдийн засгийн шууд хохирол
C4	Гамшгийн улмаас үйлдвэрийн барилга, байгууламж эвдэрч гэмтсэнээс үүссэн эдийн засгийн шууд хохирол
C5	Гамшгийн улмаас дэд бүтцэд учирсан эдийн засгийн шууд хохирол
C6	Гамшгийн улмаас түүхийн дурсгалт газар, соёлын өвд учирсан эдийн засгийн шууд хохирол

ЗОРИЛТ 4. Гамшгийг тэсвэрлэх чадавхыг сайжруулах зэргээр 2030 он гэхэд гамшгийн улмаас нэн чухал дэд бүтэц, суурь үйлчилгээ түүний дотор боловсрол, эрүүл мэндийн байгууламжид учрах хохирлыг бодитой бууруулах

D1	Гамшгийн улмаас чухал дэд бүтцэд учирсан хохирол /D2-D8 нэгдсэн байдлаар/
D2	Гамшгийн улмаас нурж сүйдсэн эмнэлэг, эрүүл мэндийн барилга, байгууламжийн тоо
D3	Гамшгийн улмаас нурж сүйдсэн боловсролын байгууллагын барилга, байгууламжийн тоо
D4	Гамшгийн улмаас нурж сүйдсэн чухал дэд бүтцийн байгууламжийн тоо
D5	Гамшгийн улмаас үндсэн үйлчилгээ тасалдсан тоо /нийгмийн/(нэгдсэн байдлаар)
D6	Гамшгийн улмаас боловсролын үйлчилгээ тасалдсан тоо
D7	Гамшгийн улмаас эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээ тасалдсан тоо
D8	Гамшгийн улмаас бусад үндсэн үйлчилгээ тасалдсан тоо

ЗОРИЛТ 5. 2030 он гэхэд хөгжиж буй орнуудын энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай, тогтвортой дэмжлэгийг үзүүлэх олон улсын хамтын ажиллагааг бодитой сайжруулах

E1	Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигтэй уялдуулан батлан хэрэгжүүлж буй гамшгийн эрсдэлийг бууруулах стратегитэй улс, орны тоо
E2	Үндэсний стратегитай уялдуулан батлан хэрэгжүүлж буй гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн стратегитай засаг, захиргаадын тоо

ЗОРИЛТ 6. 2030 он гэхэд хөгжиж буй орнуудын энэхүү үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай, тогтвортой дэмжлэгийг үзүүлэх олон улсын хамтын ажиллагааг бодитой сайжруулах

F1	Үндэсний гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд үзүүлсэн олон улсын албан ёсны дэмжлэг туслалцааны дүн /олон улсын албан ёсны дэмжлэг туслалцаа болон бусад/
F2	Үндэсний гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд олон талт хамтын ажиллагааны байгууллагаас үзүүлсэн олон улсын албан ёсны дэмжлэг туслалцааны дүн /олон улсын албан ёсны дэмжлэг туслалцаа болон бусад/
F3	Үндэсний гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд үзүүлсэн олон улсын албан ёсны дэмжлэг туслалцааны дүн /олон улсын албан ёсны дэмжлэг туслалцаа болон бусад/
F4	Гамшгийн эрсдэлийг бууруулахад холбогдох технологийг солилцох, шилжүүлэх хүрээнд үзүүлсэн олон улсын албан ёсны дэмжлэг туслалцааны дүн /олон улсын албан ёсны дэмжлэг туслалцаа болон бусад/
F5	Хөгжиж буй улс орнуудын гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, технологи, инновацыг нэвтрүүлэх, солилцох, шилжүүлэх зорилгоор үзүүлсэн олон улс, бүс нутаг, хоёр талын хамтын ажиллагааны хөтөлбөр, санаачилгын тоо
F6	Гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бий болгох чиглэлээр үзүүлсэн олон улсын албан ёсны дэмжлэг туслалцааны дүн /олон улсын албан ёсны дэмжлэг туслалцаа болон бусад/
F7	Хөгжиж буй улс орнуудын гамшгийн эрсдэлийг бууруулах чадавхыг бий болгох чиглэлээр үзүүлсэн олон улсын албан ёсны дэмжлэг туслалцааны дүн /олон улсын албан ёсны дэмжлэг туслалцаа болон бусад\
F8	Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд холбогдох статистикийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр олон улс, бүс нутаг, хоёр талын хамтын ажиллагааны хөтөлбөр, санаачилгыг хэрэгжүүлсэн хөгжиж буй улс орны тоо

ЗОРИЛТ 7. 2030 он гэхэд аюулын төрөл бүрийг эрт зарлан мэдээлэх систем, гамшгийн эрсдэлийн мэдээлэл, үнэлгээг ард иргэд хүртэх, ашиглах боломжийг бодитой нэмэгдүүлэх

G1	Олон төрлийн аюулын үед эрт зарлан мэдээллийн системтэй улс орны тоо /G2-G5 нэгдсэн байдлаар
G2	Олон төрлийн аюулын мониторинг болон урьдчилан мэдээлэх системтэй улс орны тоо
G3	Орон нутгийн засаг захиргааны нэгж болон үндэсний мэдээллийн хэрэгслээр дамжуулан эрт зарлан мэдээлэл хүлээн авдаг хүний тоо 100 000 хүн тутамд

G4	Эрт зарлан мэдээллийн талаарх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байгаа орон нутгийн засаг захиргааны хувь
G5	Үндэсний болон орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийн холбогдох үнэлгээ, мэдээллийг хүртээмжтэй, хэрэглэхэд дөхөм, ойлгомжтой байдлаар ард иргэдэд түгээдэг улс орнуудын тоо
G6	Эрт зарлан мэдээллийн дагуу нүүн шилжиж, болзошгүй гамшгийн эрсдэлээс хамгаалагдсан өртөх байдал болон эрсдэл өндөртэй хүн амын хувь

Дэлхий дахинд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг хэмжихээр тодорхойлсон эдгээр шалгуур үзүүлэлтийг улс орнууд шууд хэрэглэж болохоос гадна Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигтэй уялдуулан батлан хэрэгжүүлж буй гамшгийн эрсдэлийг бууруулах стратегийн хүрээнд улс орныхоо онцлогт тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлж болохыг НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас зөвлөмж болгосон.

Манай улсын хувьд эдгээр нийтлэг шалгуур үзүүлэлтээр гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үр дүнг хэмжихээр сонгосон хэдий ч Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”, Шадар сайдын 2021 оны 51 дүгээр тушаалаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний II үе шат (2021-2025 он)-ны төлөвлөгөөний үр дүнг дараах чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжихээр тодорхойлсон байна.

ЗУРАГ 4.7. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ СЕНДАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭГ МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ II ҮЕ ШАТ (2021-2025 ОН)-НЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР

ҮР НӨЛӨӨ (ҮР НӨЛӨӨНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ)

- Гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, удирдлагын тогтолцоо боловсронгуй болж, хүч хэрэгслийн чадавх дээшилсэн байна.
- Гамшгийн эрсдэлийг үнэлэх тогтолцоо бэхжиж, гамшгийн эрсдэлийн мэдээллийн сан хөгжүүлсэн байна.
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 70 хувьд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийгдсэн байна.
- Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах олон нийтийн мэдлэг, ойлголт, оролцоо нэмэгдсэн байна.
- Монгол Улсын гамшгийн нөхцөл байдлын тайланг жил бүр гаргаж олон нийтэд хүргэсэн байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны үр дүн аюул, өртөх байдал, эмзэг байдлыг бууруулж, гамшгаас хамгаалах бэлэн байдал, чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж гамшгийн эрсдэлийг бууруулах, шинэ

эрсдэл үүсэхээс сэргийлэх замаар гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлж тогтвортой хөгжлийн баталгаа болно.

ЗУРАГ 4.8. ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН



НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ

АЮУЛ	Хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг
АЮУЛТ ҮЗЭГДЭЛ	Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, нуранги, хөрсний гулгалт үүсэх, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах зэргийг
БАЙГАЛИЙН ГАРАЛТАЙ АЮУЛТ ҮЗЭГДЭЛ	Байгалийн хүчин зүйлийн нөлөөлөл, зүй тогтол, хувьсал өөрчлөлтийн нөлөөний үр дүнд үүсэх аюул
БҮТЦИЙН БОЛОН БҮТЦИЙН БУС АРГА ХЭМЖЭЭ	Бүтцийн арга хэмжээнд аюулын болзошгүй нөлөөллөөс зайлсхийх, бууруулах барилга байгууламжийн ажил, эсвэл бүтэц, системийг инженерийн техник, технологиор аюулд тэсвэртэй, даван туулах чадвартай болгохыг; Бүтцийн бус арга хэмжээ нь бодлого, хууль тогтоомж, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, сургалт, дадлага, боловсролоор дамжуулан мэдлэг, туршлагаар гамшгийн эрсдэлийг бууруулахыг
ГАМШИГ	Аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг
ГАМШГИЙН ДАВТАМЖ	Нэг жилд тохиолдох тухайн төрлийн аюулт үзэгдэл, ослын дундаж тоо
ГАМШГИЙН ЭРСДЭЛ	Гамшгийн улмаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хохирлын магадлал
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	Гамшгийн эрсдэл шинээр үүсэхээс сэргийлэх, одоо байгаа гамшгийн эрсдэлийг бууруулах болон үлдэгдэл эрсдэлийг удирдах замаар гамшгийн хохирлыг бууруулах, гамшгийг даван туулах чадавхыг бэхжүүлэх чиглэлээр гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого, стратегийн хэрэгжүүлэхийг
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	Гамшгийн эрсдэлийг үнэлэх, болзошгүй хохирлын хэмжээг багасгах, гамшгийг хохирол багатай

	даван туулах чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ
ГАМШГИЙГ ДАВАН ТУУЛАХ ЧАДАВХ	Аюулд өртсөн хүн ам болон нийгмийн нэн чухал бүтэц, үйл ажиллагааг хамгаалах, сэргээх зэрэг үйл ажиллагааг цаг алдалгүй үр дүнтэй хэрэгжүүлэх замаар аюулын нөлөөллийг тэсвэрлэх, шингээх, зохицох, сэргэх чадвар
ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ	Аюулт үзэгдэл, ослын хор уршиг, хохирол, сөрөг үр дагавраас зайлсхийх, таслан зогсоох, бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж байгаа цогц арга хэмжээ
ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДАЛ	Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, эрэн хайх, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг иж бүрнээр хэрэгжүүлэх бэлтгэл арга хэмжээ
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ	Аюулын зэрэг, аюулд өртөх байдал, учирч болох хохирлын буюу эмзэг байдлын зэргийн хамаарлыг
ГАМШГИЙН МЭДЭЭЛЛИЙН САН	Нэгдсэн ангилал, код, стандарт, арга зүй, ижилтгэсэн баримтын шаардлагын дагуу үүсгэсэн, цуглуулсан, хүлээн авсан, боловсруулсан, хадгалсан өгөгдөл, мэдээлэл, программ хангамжийн иж бүрдэл
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ЗАСАГЛАЛ	Гамшгийн эрсдэлийг бууруулах болон түүнтэй холбоотой бодлогыг удирдан чиглүүлэх, зохицуулах болон хянах бодлого, эрхзүйн орчин, механизм, институт, бусад зохион байгуулалтын тогтолцоог
ГАМШГИЙН НӨӨЦ	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулахаар хадгалсан бараа, материалыг
ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөлтийг
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ ШИЛЖҮҮЛЭХ	Болзошгүй эрсдэлээс үүссэн хохирлыг арилгах нөөцийг бүрдүүлэх болон даатгалд хамруулах арга хэмжээ
ДЭЭД УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ	Тодорхой зорилтуудыг хангахын тулд манлайлагчийн зүгээс бусад бүрэлдэхүүний үйл ажиллагаанд нөлөөлөх хүний нийтлэг үйлдэл
НӨЛӨӨЛӨЛ	ГЭБ үйл ажиллагаа, үзэл баримтлалыг таниулах, ил тод гарган ярих, оролцогчдын анхаарлыг хандуулах, шийдвэр гаргагч нарыг тухайн асуудлыг шийдвэрлэх алхам руу чиглүүлэх, хүмүүсийн ойлголт, зан үйл, асуудалд хандах хандлагыг өөрчлөх, чадваржуулахад чиглэсэн үйл ажиллагаа

ОСОЛ	Уул уурхай, үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг
ӨРТӨХ БАЙДАЛ	Аюулын бүсэд байрлах, түүний нөлөөлөлд өртөх магадлал бүхий хүн ам, эд хөрөнгө, орон сууц, дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ болон бусад биет эд хөрөнгө
ХҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АЮУЛ	Хүний буруутай үйл ажиллагаа болон санамсаргүй ажиллагаанаас үүдсэн аюул
ХОР УРШГИЙГ АРИЛГАХ	Гамшгийн улмаас учрах хор уршгийг таслан зогсоох, хэвийн үйл ажиллагааг сэргээх яаралтай арга хэмжээ
ЭМЗЭГ БАЙДАЛ	Аюулт үзэгдэл, осолд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин өртөж хохирох, сүйдэх зэрэг
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ	Хөгжлийн шийдвэр гаргахдаа эдийн засаг, нийгэм, байгаль орчны тулгамдсан асуудлуудыг цогцоор тусгаж, ирээдүй хойч үеийнхний хэрэгцээгээ хангах боломжийг хязгаарлалгүйгээр өнөөгийн хэрэгцээг хангах үйл ажиллагааг
ХӨГЖЛИЙН БОДЛОГО	Улс, салбар, салбар хооронд болон бүс орон нутгийн түвшинд урт, дунд, богино хугацаанд хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүрэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго, зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээр баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх бүхий этгээдээс баталсан баримт бичгийг
ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ	Хөгжлийн бодлогын хэмжигдэхүйц зорилго, зорилтуудыг үе шаттайгаар тодорхой хугацаанд хэрэгжүүлэхээр тодорхойлсон төлөвлөгөөг боловсруулах үйл ажиллагааг
УЯЛДУУЛАН ТУСГАХ	Нэг үйл явцыг өөр нэг бүтэц, үйл явцын салшгүй нэг хэсэг болгон нэгтгэх, институцилах тухай асуудал
ЦАГ АГААР	Богино хугацааны агаарын мандлын төлөв байдал
УУР АМЬСГАЛ	Урт хугацааны агаарын мандлын төлөв байдал
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ	Орчин цагийн хүний үйл ажиллагаанаас үүдэн дэлхийн дулаарал болж, дэлхийн уур амьсгалын тогтолцоонд гарч буй өөрчлөлт

**УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН
ЗОХИЦОХ**

Ирээдүйд урьдчилан таамаглаж буй уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд нийгэм-экологийн тогтолцооны эмзэг байдлаа бууруулж дасан зохицох үйл ажиллагааг цогцоор авч хэрэгжүүлэх

ҮЛДЭГДЭЛ ЭРСДЭЛ

Тохиолдож болзошгүй эрсдэлд гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авсны дараа үлдсэн эрсдэл

Энэ эрсдэлд чиглэсэн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох чадавхыг бий болгох шаардлагатай.

**ҮЛДЭГДЭЛ ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГА**

Бууруулж болохгүй, мөн урьдчилан сэргийлэх боломжгүй эрсдэлд буюу үлдэгдэл эрсдэлд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа

ХЯНАЛТ

Зорилго, стратегийг хэрэгжүүлэхэд төлөвлөсөн зүйл, түүний бодит биелэлтийг баталгаажуулахад чиглэгдсэн удирдлагын үйл явцыг

ЭРСДЭЛЭЭС ЗАЙЛСХИЙХ

Болзошгүй эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр эрсдэлийг бууруулах удирдлагыг өөрт ашигтайгаар хийхийг

ЭРСДЭЛИЙГ ХУВААЛЦАХ

